

Д. Цэрэнжав
С. Баяраа

**Сонгуулийн мэдээлэл, сурталчилгаанд
хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг**

(Судалгааны ажлын тайлан)

Нээлттэй Нийгэм Форум
Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн
(Соросын Сан)

2003 он

ГАРЧИГ

Оршил

Улс төрийн сонгуулиуд ба хэвлэл мэдээллийн оролцоо

- Сонгуулийн кампаний ажиглалт ба хэлэлцүүлэг
- Улс төрийн эрх ашиг ба хэвлэл мэдээлэл
- Сонгуулийн кампани ба сэтгүүлчдийн оролцоо
- Сонгуулийн сурталчилгаа ба бизнесийн хүчин зүйл
- Мэдээлэл, сурвалжлага, тайлбар ба сурталчилгааны зааг ялгаа
- Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт
- Далд сурталчилгаа
- Олон нийт, ТББ-ын оролцоо, нөлөөлөл

Сонгуулийн кампанит ажлыг мэдээлэхэд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгслийн гаргадаг алдаа, тэдэнд тулгардаг бэрхшээл

- Мэдээлэл олж авах, боловсруулах
- Хараат бус байдал
- Дарамт, шахалт
- Ёс зүй

Хараат Бус, Чөлөөт Хэвлэл мэдээлэл

- ХМХ-ийн эрх чөлөө
- ХМХ-ийн хараат бус байдал
- Чөлөөт хэвлэлийн баталгаа нь хэн байвал зохих вэ?
- “Өөрийн цензур”
- Чөлөөт хэвлэлийн зарчмууд
- Хэвлэл мэдээллийг айлган сүрдүүлэх нь
- Шилдэг туршлагыг төлөвшүүлэх нь

2004 оны УИХ-ын сонгуулийн мэдээлэл, сурталчилгааны төлөв байдал, хэвлэл мэдээллийнхэнд зориулсан санал

ХАВСРАЛТ

- 1996, 2000 оны УИХ-ын сонгуулийн кампанийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлсэн байдалд Монголын Хэвлэлийн Хүрээлэнгээс хийсэн мониторингийн товч тайлан
- 2000 оны УИХ-ын сонгуулийн кампанийг мэдээлсэн хроник
- 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн кампанийг мэдээлсэн хроник
- “Монгол Төрх” сонин 2000 ба 2004 оны сонгуульд
- 1993 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн болоогүй
- Сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэлд тавигддаг зарим шаардлага
- 2000 онд болсон “Улс төр ба реклам” дугуй ширээний ярилцлагын тэмдэглэлээс
- Сэтгүүлчийн ёс зүйн талаархи өгүүллүүд

ОРШИЛ

“Сонгуулийн сурталчилгаанд хэвлэл мэдээллийн гүйцэтгэх үүрэг” нээлттэй ярилцлагын бэлтгэл ажлын хүрээнд бид 1990-ээд оноос хойш Монголд явагдсан УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаатай холбоотой мэдээлэл, материалыг эргэн сөхөхийн зэрэгцээ дэлхийн улс орнуудын туршлагаас судлан энэхүү тайланг бэлтгэлээ. Хэвлэл мэдээллийн үйл ажиллагааны олон талыг хамарсан янз бүрийн дүгнэлт хийж болох байсан бөгөөд эдгээрээс ярилцлаганд оролцогчдын анхаарлыг хандуулж хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн зарим чухал асуудлыг багтаав. Хавсралтад 2000 оны УИХ-ын сонгуулийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэрхэн мэдээлсэн талаар Монголын Хэвлэлийн Хүрээлэнгийн мониторингийн судалгааны товч тайлан зэрэг бидний хэлэлцэж буй асуудалтай холбоотой материалуудыг оруулсан болно.

Энэхүү судалгааг хийх бололцоог бидэнд олгосон Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн “Нээлттэй Нийгэм Форум” хөтөлбөрт талархал илэрхийлье.

**Д. Цэрэнжав, “Монголын ОНМХ-ийн тойм” сэтгүүлийн эрхлэгч
С. Баяраа, “Зориг Сан”-гийн зөвлөх**

Улс төрийн сонгуулиуд ба хэвлэл мэдээллийн оролцоо

Өнгөрсөн жилүүдийн УИХ, Ерөнхийлөгчийн ба орон нутгийн сонгуулийн сонгуулийн мэдээлэл, сурталчилгаа нь ард иргэд, бас нэг удаа гадаадын ажиглагчдын зүгээс маш ихээхэн шүүмжлэл хүлээжээ. Нийт сонгогчдын хувьд улс төрийн намуудын мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчдийн намтар, амлалттай холбоотой сурталчилгааны мэдээлэл материал тооны хувьд хангалттай байсан боловч хэвлэл мэдээллийн өөрийн бие даасан байр суурь, тайлбар, дүн шинжилгээ дутагдалтай байлаа гэсэн дүгнэлтийг хийсэн байна. Сонгогчид хариуцлагатай сонголт хийхэд шаардагдах тийм мэдээллийн орчинг бүрдүүлж чадаагүй юм байна.

Сонгуулийн кампаний ажиглалт ба хэлэлцүүлэг

1990 оноос хойш буюу ардчилсан сонгууль эхэлсний дараа сонгуулийн кампанид хэвлэл мэдээллийн оролцооны асуудлыг сэтгүүлчдийн байгууллагын их хурал, семинар зэрэг арга хэмжээний үеэр хөндөж байсан. Гэхдээ хамгийн анх тусгайлан зориулсан арга хэмжээ бол Европын холбооны ТАСИС хөтөлбөрөөс санхүүжүүлж Олон Улсын Сэтгүүлчдийн байгууллага, МЧАСЭ-ээс хамтран 1995-96 оны онуудад хэрэгжүүлсэн “Сонгууль, хэвлэл мэдээлэл” төсөл юм. Энэ хүрээнд 1996 оны 1-р сарын 16-нд хот, хөдөөгийн хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцсон семинар зохион байгуулжээ. Семинарт оролцогчдоос Улсын Их хурал, Сонгуулийн ерөнхий хороонд өргөн барьсан санал, зөвлөмж баталж илгээсэн. Дараа нь 1996 оны 03-р сарын 26-28-нд дахин семинар зохион байгуулсан ба Засгийн газар, хэвлэл мэдээллийн эзэд, эрхлэгч, редакторуудад хандсан заалтууд бүхий зөвлөмж гаргажээ. Мөн “Сонгууль, хэвлэл мэдээлэл” гарын авлага бэлтгэн хэвлүүлж тараасан байна. 1996 оны сонгуулийн сурталчилгааг дүгнэх ямар нэгэн ажил хийгдээгүй. Гэхдээ Брюссельд төвтэй олон улсын сэтгүүлчдийн байгууллагаас ажиглах хэсэг ирүүлж санал дүгнэлтээ үлдээсэн.

1997 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгааг өмнө нь буюу дараа нь хэлэлцээгүй өнгөрчээ.

2000 оны УИХ-ын сонгуулийн өмнө 2003.05.06-07-ны өдрүүдэд АНУ-ын Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгээс “Хэвлэл мэдээлэл ба 2000 оны сонгууль” семинарыг зохион байгуулжээ. 2000 оны 6-р сарын 20-30-ны өдрүүдэд буюу санал хураахаас өмнөх 10 хоногийг хамарсан мониторингийн судалгааг хэвлэлийн хүрээлэнгээс явуулжээ. Судалгааны дүн сүүлд гарсан тул тэр сонгуульд нөлөөлж эрүүлжүүлэх хүчин зүйл болж амжаагүй.

Харин УИХ-ын сонгуулийн дараа буюу 2000 оны 9-р сарын 15-нд Монголын Рекламын Ассоциаци, Бүгднайрамдахчуудын Олон Улсын Хүрээлэн хамтран “Улс төр ба реклам” сэдэвтэй дугуй ширээний ярилцлагыг зохион байгуулжээ. Энэ үеэр дээрх мониторингийн дүнг танилцуулсан ба сонгуулийн сурталчилгааны бусад асуудлыг хөндөж ярилцсан байна. Хэлэлцүүлэгт реклам сурталчилгаа, олон нийтийн харилцаа (PR)-ийн ажилтнууд оролцсон ба хэвлэл мэдээллийнхэн хамрагдаагүй.

2001 онд болсон Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгууль хамгийн дуулиантай болсон, ноцтой үйлдлүүд гарсан хэдий ч түүний өмнө ба дараа дүгнэж ярилцах ямар нэгэн арга хэмжээ болоогүй, тийм санаачлага гараагүй болно.

Ерөнхийдөө 1996 оныхыг эс тооцвол аль ч сонгуульд Монголын хэвлэл мэдээллийн салбарынхан, ялангуяа сэтгүүлчид ирэх сонгуульд хэрхэн оролцохоо өргөн хүрээтэй ярилцаагүй, бодлого, журам, зөвлөмж боловсруулаагүй, хамгийн харамсалтай нь өнгөрсөн сонгуулийн сурталчилгааны халуун мөрөөр алдаа оноогоо хамтран хэлэлцэж дүгнэлт хийдэггүй юм байна. Ялангуяа 2000 оны сонгуулиас хойш энэ сэдвээрх тусгайлсан уулзалт бүрэн зогсчээ. Зарим нэг ажиглалт, дүгнэлтийг эс тооцвол

Ерөнхийлөгчийн сонгуулиас гадна УИХ-ын сонгуулиас хэдхэн сарын дараа тохиодог орон нутгийн сонгуулийн сурталчилгааны асуудал ор тас орхигдлоо.

Аль ч сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийнхэн ил тод ажилладаг мэт боловч олон нийт, сонгогчдын анхаарал улс төрийн намууд, нэр дэвшигчид, тэдний үйлдэл, зөрчил тэмцэл дээр төвлөрч улмаар хэвлэл мэдээллийг тойрсон ноцтой асуудал халхлагдан үлдэж байна.

Улс төрийн эрх ашиг ба хэвлэл мэдээлэл

Сонгуулийн мэдээлэл, сурталчилгааны талаар хэвлэл мэдээллийнхэн хэлэлцэж ярилцахгүй явж ирсэн нь “улс төрийн шалтгаан”-тай гэж үзэж байна. Сонгуулийн үеэр хэвлэл мэдээллийнхэн өөрийн харьяалал, статус ба эдийн засгийн сонирхолдоо хөтлөгдөн улс төрийн намууд ба нэр дэвшигчдийг сурталчилгааг ил төдийгүй далдуур явуулж, цөөнгүй тохиолдолд тэдний сурталчилгааны аппарат, сонгуулийн штаб, комиссын үргэлжлэл болон ажиллаж байсан. Ийм нөхцөлд сонгуулийн кампанид хэвлэл мэдээллийн оролцоог хөндөж ярилцах нь нэг талаас улс төрчид, нөгөө талаас сонин хэвлэл эрхлэгчид, сэтгүүлчдийн холбоо сүлбээ, ашиг сонирхол, жишээлбэл, тэдний намын харьяалал, улс төрийн байр суурь зэрэг сайн дураар зарлах дургүй сэдвийг хөндөж, цаашилбал сонгуулийн сурталчилгааны орлого руу өнгийнө гэсэн үг юм. Бас аль нэг сонин хэвлэл, радио, телевиз, эсвэл нэр бүхий сэтгүүлчдийн хаягаар хийсэн дүгнэлт, шүүмжлэлийг улс төрийн зорилготой мэтээр тайлбарлах замаар амархан няцаах хандлагатай байна. Улс төржлөө гэхээс эхлээд “эрх баригчид (эсвэл сөрөг хүчин) яг ингэж ярьдаг. Тэдний талд орж байна” гэх мэтээр гуйвуулдаг. Өнгөрсөн сонгуулийн үеэр тодорхой телевиз, радио, сонин сэтгүүл рүү хандсан шүүмжлэл бараг бүх тохиолдолд улс төрийн намууд, тэдгээрийн сонгуулийн штаб, комисс товчоонууд, нэр дэвшигчдын зүгээс гар байлаа. Нэг үгээр хэлбэл хэвлэл мэдээллийн өөрийн шүүмжлэл байсангүй. Яваандаа хэвлэл мэдээллийнхний дунд энэ сэдвээр дуугарахгүй байх “ойлголцол” бий болжээ. Хэвлэл мэдээллийн гол гол хэрэгслүүд буюу нэр нөлөөтэй сэтгүүлчид бараг бүгдээр улс төрийн харьяалалтай, улс төрд оролцдог учраас бусдыг шүүмжлэх нь эргээд өөрийгөө илчлэхэд хүргэнэ гэдгийг сайн ойлгодог.

Нийгмийн амьдралд улс төрийн нөлөөлөл хэт их, заримдаа дарангуйлах хандлагатай болсон нь сонгуулийн кампанийн үеэр харагддаг. Намгүйгээр албан тушаал ахих, төр захиргааны бүх шатны байгууллагад дээгүүр алба хаших ямар ч боломжгүй. Үүнээс хэвлэл мэдээлэл ч ангид байж чадаагүй. Одоогоор хэвлэл мэдээллийн томоохон хэрэгслүүдийн харьяаллыг авч үзвэл бүгдээрээ эрх баригч ба сөрөг хүчин, эсвэл улс төрийн өөр нэгэн бүлэглэлд багтжээ. Хэвлэл мэдээллийн эзэд төдийгүй ерөнхий эрхлэгчид бараг бүгдээрээ улс төрийн намын гишүүд байдаг. Олон хэвлэл эзэн, харьяаллаа нуудаг ч улс төрийн (жишээлбэл ирэх сонгууль гэхэд зах зээлд байр сууриа эзэлсэн байхын тулд) үүсгэн байгуулагдсан. Нэгэнт хэвлэл мэдээллийн хэрэгслүүд улс төрийн тодорхой байр суурийг хамгаалж үйлчилдэг болохоор намууд ба нэр дэвшигчид зөвхөн өөрийн талын сонин хэвлэл буюу телевиз, радиод ханддаг, харин эсрэг тал нь сурталчилгаагаа нийтлүүлдэггүй, ярилцлага өгдөггүй. Нэг талыг хэт давуу сурталчилсныгаа чухам үүгээр тайлбарлаж зөвтгөдөг.

Сонгуулийн кампани ба сэтгүүлчдийн оролцоо

УИХ-ын 2000 оны сонгуулиар жишээ болгон авч үзвэл нэр дэвшигчдын тоо дунджаар 500 байдаг ба тус бүрдээ сурталчилгааны сонин гаргаж, нэвтрүүлэг, клип хийдэг (хэрвээ эрх мэдэл, хөрөнгө чинээ ихтэй нэр дэвшигч бол хэд хэдийг), үүний тулд сэтгүүлчдийг хөлсөлж авдаг гэж үзвэл монголын сэтгүүлчид бараг бүгдээрээ сонгуулийн сурталчилгаанд оролцож байна. Зарим нэр дэвшигч сурталчилгааны бүхэл бүтэн баг ажиллуулжээ. Томоохон хэвлэл мэдээлэлд ажилладаг нэр хүндтэй, энэ

утгаараа олон нийтэд нөлөөтэй сэтгүүлчид нэр дэвшигчдийн багт албан ёсоор багтаж буюу эчнээгээр ажиллажээ.

Сонгуулийн кампанийн үеэр бүгд бизнес хийжээ. Хэвлэл мэдээллийн эзэд төдийгүй сэтгүүлчид өөрсдөө. 2000 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшигчдын тоо 500-гаад байсан, тус бүрдээ сурталчилгааны сонин гаргаж, нэвтрүүлэг, клип хийсэн (хэрвээ эрх мэдэл, хөрөнгө чинээ ихтэй нэр дэвшигч бол хэд хэдийг), үүний тулд сэтгүүлчдийг хөлсөлж авдаг гэж үзвэл монголын сэтгүүлчид бараг бүгдээрээ сонгуулийн сурталчилгаанд оролцож байлаа. Ялангуяа томоохон хэвлэл мэдээлэлд ажилладаг нэр хүндтэй, энэ утгаараа олон нийтэд нөлөөтэй сэтгүүлчид нэр дэвшигчдийн багт албан ёсоор багтаж буюу эчнээгээр ажилласан. Улс төрийн намуудад ойр байсан сонин хэвлэл, телевиз, радио тухайн намын сурталчилгааны аппаратын шууд үргэлжлэл болж байлаа. Улмаар сонгуулийг мэдээлж сурвалжлах үйл ажиллагаа ба сурталчилгаа хоёрын зааг ялгааг гаргахад бэрхтэй байв. (2000 оны сонгуулиас хойш хэвлэл мэдээллийн байгууллагууд дэргэдээ PR агентлаг байгуулах болсон нь үүний нотолгоо).

Өнгөрсөн 2000 оны УИХ-ын сонгуульд хэвлэл мэдээллийнхэн олноороо, түүний дотор МРТХЭГ-ын дарга, “Монголын мэдээ” агентлагийн захирал, Монголын радиогийн захирал, өдөр тутмын 5 сонины 3 сонины эрхлэгчид нэр дэвшсэн. Сонин хэвлэлийн эзэд, сэтгүүлчид намын гишүүн байх, сонгуульд нэр дэвшихийг хориглох аргагүй боловч энэ талаар ямар нэгэн зохицуулалт үгүйлэгдлээ. Ихэнх тохиолдолд нэр дэвшсэн тэд үндсэн ажлаа үргэлжлүүлэн хийж байлаа. Зөвхөн МҮТВ-ын “Монголын мэдээ” агентлагийн захирал ажлаасаа чөлөөлөгдөж байжээ.

Энэ бүгдийн улмаас сонгуулийн үйл явц, улс төрийн намуудын тэмцэл, нэр дэвшигчдын өрсөлдөөнд манай хэвлэл мэдээлэл шууд татагдан орж байна. Элдэв амлалт, мэдэгдэл, байр суурийг харьцуулах, бие даасан байр сууринаас үнэлэлт дүгнэлт өгөх, анализ дүн шинжилгээ хийх, цаашилбал олон нийтийн санал бодол, хүсэл эрмэлзлэлийг бодитой гаргаж харуулах талаар маш муу ажиллажээ. Ямарваа баримт, мэдээллийн мөрөөр мөшгих, эрэн сурвалжлах замаар нотлох буюу няцаах ажлыг сэтгүүлчид бараг хийгээгүй байна.

Сонгуулийн сурталчилгаа ба бизнесийн хүчин зүйл

Өнгөрсөн жилүүдэд сонгуулийн сурталчилгааны цар хүрээ жил ирэх тусам асар ихээр нэмэгдэж байна. Хэвлэл мэдээллийн хувьд сонгуулийн сурталчилгаанд оролцох нь юутай ч зүйрлэшгүй бизнес болон хувирчээ. Тэд дөрвөн жилд нэг удаа УИХ-ын сонгууль, хэдхэн сар хүлээгээд орон нутгийн сонгууль, мөн дараа жилийн ерөнхийлөгчийн сонгуулийн сурталчилгаагаар асар их мөнгө олдог. Эдийн засгийн утгаараа сонгуулийн сурталчилгааны кампани бол хэвлэл мэдээллийн салбар, сэтгүүлчид рүү хийж байгаа асар том хөрөнгө оруулалт юм.

Гэтэл манайд улс төрийн намуудын сонгуулийн зардлын зөвхөн ерөнхий дүнг сонгуулийн дараа зарладаг. Дотор нь нарийвчлан тайлагнадаггүй учраас, тухайлбал, хэвлэл мэдээллийн ямар байгууллага аль нам, нэр дэвшигчээс мөнгө авч сурталчилгаа хийсэн, эсвэл нуусан зэргийг тодруулах боломжгүй. Ер нь улс төрийн намуудаас сонгуулийн ерөнхий хороонд тайлагнадаг зардлын дүн тухайн сонгуульд зарцуулсан нийт хөрөнгө мөнгөний өчүүхэн хэсэг гэдэгт хэн ч эргэлздэггүй. Сонгуулийн том хандивлагчдийн жагсаалт, тэдний өргөсөн хандивын хэмжээ бүрэн хаалттай. Сонгуульд их мөнгөний үзүүлэх нөлөөг хязгаарлах, ядахдаа журамлах байтугай энэ талаар ярьж ч эхлээгүй байна. Сонгуулийн санхүүг ил тод болгох үүднээс сурталчилгаанд ямар нэгэн тодорхой журам, хязгаарлалт тогтоохыг эрх баригчид ба сөрөг хүчний намууд ба улс төрчдийн аль аль нь хүсэхгүй явж иржээ. Үүний улмаас сонгуулийн сурталчилгааны орлогын хэмжээ төдийгүй тодорхой хэвлэл мэдээллийн байгууллага аль нэг нэр дэвшигч, улс төрийн намыг дэмжсэн, эсвэл шүүмжилсэн нь сэтгүүлчийн үзэл бодол

байр суурь уу, эсвэл мөнгө авч хийсэн захиалгат нийтлэл, сурталчилгааны далд хэлбэр үү, үгүй юу гэдгийг ялгаж салгах, дүн шинжилгээ хийх боломжийг хааж байна. Сонгуулийн сурталчилгааны санхүүжилт бүрэн хаалттай, ямар нэгэн хяналт байхгүйгээр манай хэвлэл мэдээллийнхэн сэтгүүл зүйн төдийгүй ердийн ёс зүйг бүрэн огоорох хүртлээ сурталчилгаанд оролцож байна.

Мэдээлэл, сурвалжлага, тайлбар ба сурталчилгааны зааг ялгаа

УИХ-ын ба бусад сонгуулийн компанийн мэдээлэл ба сурталчилгааны зааг ялгаа бүр улам багасаж ихэнх тохиолдолд ялгахын аргагүй болжээ. Улс төрийн нам, нэр дэвшигчдийн судалгааг хамгийн ихээр явуулдаг телевиз, өдөр тутмын сонинууд, мөн томоохон чөлөөт сонинуудад сонгуулийн компанийн явцын тухай бусад мэдээ, тайлбар, сурвалжлагыг нийтэлж нэвтрүүлдэг боловч тэр нь голдуу мэдээллийн шинжтэй байдаг. Харин намуудын мөрийн хөтөлбөр, нэр дэвшигчийн намтар түүхтэй холбоотой тайлбар, дүн шинжилгээ нь сурталчилгааны үргэлжлэл болж далд сурталчилгааг агуулж байна. Нэр дэвшигчдийн магтаал хэт давамгайлжээ. Хэрвээ шүүмжилсэн бол өөрийн дэмждэг улс төрийн хүчин, нэр дэвшигчдийн сонирхолд нийцүүлэн, зарим тохиолдолд шууд захиалгаар хийж буй үйлдлүүд байна.

Улмаар улс төрийн намуудын тэмцэл, нэр дэвшигчдын өрсөлдөөнд манай хэвлэл мэдээлэл шууд татагдан орж байна. Элдэв амлалт, мэдэгдэл, байр суурийг харьцуулах, бие даасан байр сууринаас үнэлэлт дүгнэлт өгөх, анализ дүн шинжилгээ хийх, цаашилбал олон нийтийн санал бодол, хүсэл эрмэлзлэлийг бодитой гаргаж харуулах талаар маш муу ажиллажээ. Ямарваа баримт, мэдээллийн мөрөөр мөшгих, эрэн сурвалжлах замаар нотлох буюу няцаах ажлыг сэтгүүлчид бараг хийдэггүй.

Сонгуулийн сэдвээрхи мэдээ, сурвалжлага, тайлбар, дүн шинжилгээ ба сурталчилгааны хатуу зааг ялгаа тогтоогүй өдий хүрчээ. Ихэнх сурталчилгаа ердийн нийтлэл, нэвтрүүлэг, ярилцлагын хэлбэрээр явагдаж байлаа.

Цаашдаа сонгуулийн сурталчилгааны өгүүлэл бичих, нэр дэвшигчийг сурталчилсан ярилцлага хийх, тэдэнд зориулсан сонин хэвлэл гаргах, сурталчилгааны нэвтрүүлэг хийх зэргийг сэтгүүл зүйн үндсэн үйл ажиллагаанаас салгаж, зөвхөн улс төрийн намуудын дэргэдэх олон нийттэй харилцах алба, нэр дэвшигчийн хэвлэлийн төлөөлөгч, эсвэл бүр бие даасан PR агентлагуудаар хийлгэх зарчмыг нэвтрүүлэх шаардлагатай болж байна.

Сонгуулийн үеийн хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалт

Өмнөх туршлагаас харахад улс төрийн сонгуулийн компанийг хэвлэл мэдээлэл хэрхэн тусгаж байгааг шүүмжлэх, хөндлөнгөөс нөлөөлөх оролдлогыг сонин хэвлэлийн эзэд, сэтгүүлчид огт тоохгүй өнгөрөөдөг. Ийм яриа хэлэлцүүлгийг хэвлэл мэдээллээр өрнүүлэх боломж тун хязгаарлагдмал. Үндэсний телевиз, радио, томоохон сонинууд үүнийг хийхгүй. Яагаад гэвэл энэ бүх шүүмжлэл тэргүүн ээлжинд тэдэнд хамаатай. Цаашилбал хэвлэл мэдээллийн хаягаар ирсэн шүүмжлэлийг няцаахдаа хэвлэлийн эрх чөлөөгөөр халхавчлах, эсвэл бүр “юуг нийтэлж нэвтрүүлэхийг заах” буюу цензурдэх оролдлого гэх мэтээр буцаах хандлага цухалздаг.

Сонгуулийн өмнө мөнгөний сургаар янз бүрийн бүлэглэл, эвсэлд нэгдэн улс төрийн намуудтай далд тохиролцоонд орж бизнесийн эрх ашгийг тэргүүн ээлжинд тавьж буй хэвлэл мэдээллийн эздийн мөнгөний сонирхлыг сэтгүүл зүйн зарчим, ёс зүйгээр тэнцвэржүүлэх хүч байхгүй. Ийм зарчмыг дэвшүүлэн ажилладаг, сэтгүүл зүйн мэргэжлийн эрх ашгийг тууштай хамгаалдаг байгууллага хамгийн ихээр үгүйлэгдэж байна. Сэтгүүлчдийн тийм байгууллага ч алга. Сэтгүүлчид шударга ажиллахыг

хичээсэн ч өнөөдөр манайд редакцийн бие даасан байдал үгүй учраас эзэддээ захирагдаж сурталчилгаанд оролцохоос өөр аргагүй болж байна.

Ийм хэвлэл мэдээлэл өмнөх жилүүдийн сонгуулийн сурталчилгааны зарчмуудыг өөрчлөх, хэлэлцэх, хэм хэмжээ тогтоохыг хүснэ гэдэгт эргэлзэж байна. Гэхдээ 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанийн өмнө хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын механизмыг бүрэн хэмжээгээр биш юмаа гэхэд сонгуулийн мэдээлэл сурталчилгааг эрүүлжүүлэх, 2000, 2001 оныхоос хавьгүй шударга, тэнцвэртэй явуулахад шаардагдах тэр хэмжээгээр бүрдүүлж эхлэх шаардлагатай болжээ.

Далд сурталчилгаа

Далд сурталчилгааны бас нэг хэлбэр 2000 оны УИХ-ын, 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуулиар түгээмэл ажиглагдлаа. Энэ бол нэргүй нийтлэл, нэвтрүүлэг юм. Улс төрийн намууд ба нэр дэвшигчдийн аль нэгийг магтсан, эсвэл дайрч давшилсан, мөн үнэлэлт дүгнэлт өгсөн мэдээ, материалыг зохиогчийн нэр хаяггүйгээр, эсвэл хуурамч нэрээр цацаж байлаа. Жишээлбэл, сонгуулийн ид үеэр аль нэг нэр дэвшигчийг муулсан нэвтрүүлэг, сурвалжлагыг телевизээр нэвтрүүлэхдээ хэн бэлтгэснийг огт бичдэггүй. 2001 оны ерөнхийлөгчийн сонгуулиар Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди хятадуудаас 1 сая доллар авсан тухай дуулиант өгүүллийн эх сурвалжийг “хэн нэгэн хүн авчирч өгсөн” гэх мэтээр төөрүүлсэн, үнэн хэрэгтээ зохиогчгүй (оронд нь санаанаас зохиосон нэр тавьсан) юм.

Сэтгүүлчид материалынхаа ард нэрээ тавихаас цааргалдаг нь ихэнх тохиолдолд тэр мэдээлэл маапаантай, баталгаагүй, хэн нэгнийг гутаасан, захиалгаар хийгдсэн болохыг шууд харуулж байна.

Гэхдээ манай сонин хэвлэлүүд сонгуулийн сурталчилгааны үеэр “аль нэг улс төрийн намд үйлчлэхгүй” гэж зарладаг, хэн нэгний талд орсон гэж хэлүүлэхийг огт хүсдэггүй хэвээрээ байлаа. Ийм учраас нэлээд үндэслэлтэй, баримт нотолгоотой материалын ард хүртэл нэрээ тавихгүй байсан нь ажиглагдав. Үүнийг нөгөө талаас манай сэтгүүлчид, хэвлэл мэдээллийнхний дунд хэвлэлийн эрх чөлөөний үзэл санаа үнэ цэнэтэй хэвээрээ байна хэмээн тайлбарлаж болох юм. Харамсалтай нь янз бүрийн хүчин зүйл (ээд, эрхлэн гаргагчдын төдийгүй сэтгүүлчдийн бизнесийн эрх ашиг, улс төрийн үзэл бодол, найз нөхдийн харьцаа гэх мэт)-ийн улмаас чөлөөтэй байж чаддаггүй, үүнээсээ ичдэг хэмээн тайлбарладаг. Уг нь сэтгүүлч хүн аль нэг нам, эсвэл нэр дэвшигчдийн талаар эерэг, эсвэл сөрөг байр суурийг илэрхийлэх эрхтэй. Энэ бол үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний нэг хэсэг. Гагцхүү үүнийг хулгайгаар, “чөлөөт” гэсэн халхавчин дор хийж нэрээ нуухад хүрч байгаа нь харамсалтай. Нээлттэй хэлэлцүүлгийн бас нэг сэдэв.энд байна.

Олон нийт, ТББ-ын оролцоо, нөлөөлөл

Сүүлийн арваад жилийн ардчилсан сонгуулийн үйл явцад олон нийтийн хяналт, нөлөөлөл нь зөвхөн цөөн тооны төрийн бус байгууллагын эрх ашиг (эмэгтэй нэр дэвшигчдийн тоо, хувийг нэмэгдүүлэх гэх мэт), эсвэл нэр дэвшигчдийг ил ба далдуур дэмжих (төр, засгийн удирдах хүмүүс, УИХ-ын гишүүд, улс төрчид бараг бүгдээрээ төрийн бус янз бүрийн байгууллагын дарга, тэргүүн, ерөнхийлөгчөөр ажилладаг)-ээс хэтрэхгүй байна. Иймд хэвлэл мэдээллийн хэрэгслүүд дараачийн сонгуульд зүгээр нэг сурталчилгааны хэрэгслүүд биш, харин олон нийтийн зүгээс сонгууль, улс төрчид, нэр дэвшигчдыг хянах хэрэгсэл болох зүгт томоохон алхам хийх хэрэгтэй. Монгол Улс улс төрийн хүрээнд барууны ардчилсан сонгуулийн тогтолцоо, хууль тогтоомж, зарчмуудыг хуулж авсан боловч үүний нөгөө талд заавал байх ёстой, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн зүгээс тавих хяналтын тогтолцоо, зохицуулалтын механизмыг бүрдүүлж чадалгүй өдий хүрчээ.

Олон нийтийн зүгээс үзүүлэх шахалт, шаардлага бас хэвлэл мэдээлэлд өөрт нь үгүйлэгдэж байгааг хэлэх хэрэгтэй. Үүний тулд төрийн бус байгууллагууд сонгуулийн үеэр хэрхэн олон нийтийн эрх ашгийг хэрхэн илэрхийлэх, нэр дэвшигч, улс төрийн намуудад хандсан шаардлага, хяналтын арга механизм болгож дэвшүүлэх нь маш чухал. Телевиз, радио, сонин хэвлэл эрхлэгчид хэвлэлийн эрх чөлөө, олон нийтийн өргөн нэвтрүүлгийн хууль гаргах зэрэг асуудлаар төр засгаас горьдож суух биш иргэний нийгмийн төлөөлөл - төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллавал маш үр дүнтэй байхсан. Бас хэвлэл мэдээлэлд өөрт нь олон нийт, төрийн бус байгууллагуудын зүгээс нөлөөлөл, шахалт шаардлага үгүйлэгдэж байна.

Монгол Улс улс төрийн хүрээнд барууны ардчилсан сонгуулийн тогтолцоо, хууль тогтоомж, зарчмуудыг хуулж авсан боловч үүний нөгөө талд заавал байх ёстой, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн зүгээс тавих хяналтын тогтолцоо, зохицуулалтын механизмыг бүрдүүлж чадалгүй өдий хүрчээ.

**Сонгуулийн кампанит ажлыг мэдээлэхэд сэтгүүлч,
хэвлэл мэдээллийн хэрэгслийн гаргадаг алдаа,
тэдэнд тулгардаг бэрхшээл**

(Энэ бүлгийг бичихдээ олон улсын туршлага болон Монголын зарим жишээг ашигласан болно).

Чилийн дарангуйлагч Аугусто Пиночетийг унагасан сөрөг хүчний хэвлэлийн төлөөлөгчийн мэдэгдсэнээр “Телевизийн 15 минутын нэвтрүүлгээр бид засгийн газраас дарангуйллыг сурталчилсан 15 жилийг арчиж орхисон юм” гэжээ.

Хятадын Коммунист Намын Ерөнхий нарийн бичгийн дарга Жан Зимэнь хэлэхдээ “Олон нийтийн санаа бодлыг залах хэрэгслийг жинхэнэ Марксистууд хатуу хяналтандаа байлгахгүй бол” ямар үр дүнд хүрэхийг Тянь Ань Мений талбайд болсон үйл явдал харууллаа гэсэн байна.

Александр Солженицын Харвардын Их Сургуулийн хүндэт доктор болохдоо хэлсэн үгэндээ “Өрнөдийн орнуудад хэвлэл мэдээлэл хамгийн хүчирхэг зүйл болжээ. Тэрээр хууль тогтоох байгууллага, гүйцэтгэх засаглал, шүүхээс ч илүү хүчтэй” хэмээн мэдэгджээ.

Дээр дурдсан бүхнээс үзэхэд өнөөдөр хэвлэл мэдээллийн хэрэгсэл (ХМХ) нь нийгэмд ямаршуу их нөлөөтэй болох нь харагдаж байна. Ийм хүчирхэг хэрэгслийг ажиллуулж байгаа сэтгүүлч, редактор, эрхлэгч, эзэд нь нийгмийн өмнө хариуцлага хүлээж үнэн зөв, тэнцвэртэй, шударга мэдээлэх ёстой гэсэн зарчмыг дэлхий нийтээр мөрдөж байна.

Сонгуулийн кампанийг мэдээлэх нь сэтгүүл зүйн ерөнхий арга барилын хувьд бусад мэдээллээс онцын ялгаагүй боловч сонгууль гэдэг бол ардчиллын хамгийн чухал үнэт зүйлийн нэг болохын хувьд түүний талаар олон түмэнд үнэн зөв мэдээлэл хүргэсэнээр иргэдэд шударга сонголт хийхэд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл тусалдаг юм. Сонгуулийн хурц өрсөлдөөний дунд нийтлэл, нэвтрүүлгээ бодитой, аль нэг талыг барилгүй, тэнцвэртэй байлгах нь сэтгүүлчдэд мэргэжлийн хамгийн том сорилт болдог билээ.

Сонгуулийн кампанийг мэдээлэхэд сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл алдаа гаргадагийн дээр тэдэнд бодит бэрхшээл тулгардаг. Эдгээр нь хоорондоо харилцан уялдаатай бөгөөд ёс зүйтэй, чанартай сэтгүүл зүйг баримтлахад хэвлэл мэдээллийнхэнээс багагүй эр зориг, хүчин чармайлтыг шаардна. Одоо зарим нийтлэг алдаа, бэрхшээлүүдийг авч үзье.

Мэдээлэл олж авах, боловсруулах

Мэдээлэл олж авах нь нэг талаас сэтгүүлч, сурвалжлагчдын ур чадвартай холбоотой боловч нөгөө талаас эрх зүйн орчноос бас хамаарна. Дэлхийн ардчилсан олон оронд мэдээллийн эрх чөлөөний хууль үйлчилж энэ нь сэтгүүчид болон нийт иргэд хүссэн мэдээллээ саадгүй олж авах баталгаа нь болдог. Гэтэл ийм хуульгүй манайх шиг улс орны сэтгүүлчдэд энэ бэрхшээлийг даван туулах хэрэгтэй болдог. Үүнд дараах арга замууд байж болох юм:

Мэдээллийн олон эх сурвалж ашиглах. Улс төрийн нам буюу нэр дэвшигчээс өгсөн мэдээлэл нь ихэнхдээ өрөөсгөл байдгийн зэрэгцээ зарим тохиолдолд тэднээс мэдээлэл, ярилцлага, сурвалжлага авахад бэрхшээл тохиолддог.

Мэдээлэл **үнэн зөв** байхын тулд олон эх сурвалж ашиглаж давхар нягтлаж байх ёстой. Жишээ нь тухайн нэр дэвшигч Кембриджийн Их Сургууль төгссөн гэж түүний танилцуулга дээр бичсэн байвал энэ нь заавал үнэн байна гэсэн үг биш. Тиймээс интернетээс ч юмуу давхар шалгаж үзэх хэрэгтэй.

Олж авсан **мэдээллийг боловсруулах** шаардлагатай. Уншигч, сонсогч, үзэгчдэд сонгуулийн үйл явцыг ойлгуулахын тулд энгийн, ойлгомжтой, хүртээмжтэй хэлбэрт оруулах нь чухал. Гэтэл улс төрийн нам юмуу нэр дэвшигчээс өгсөн мэдээллийг тэр чигээр нь нийтлэх явдал олонтаа тохиолддог. Мэдээллийг боловсруулахад нэг талаас сэтгүүчдийн мэдлэг чадвар дутдаг ч зарим тохиолдолд тэд материалд задлан шинжилгээ хийхээс түвэгшээх явдал мөн ажиглагддаг.

Мэдээллийн эх сурвалжаа нууцлах. Сэтгүүлчид ганцхан эх сурвалжаас мэдээлэл олж авчихаад түүнийгээ нууцлана гэж зүтгэдэгээс алддаг. Иймээс дээр өгүүлсэнчлэн, олон эх сурвалж ашиглах хэрэгтэй. Нөгөө талаар нотлох баримт хангалттай байх ёстой бөгөөд сэтгүүлчийн судалгааны материалыг нэгжлэгээс хамгаалах, нийтийн эрх ашигт хамаарах мэдээлэл өгсөн хүмүүсийг шийтгүүлэх явдлаас хамгаалах хэрэгтэй. Мэдээлэл олж авахдаа ямагт шударга арга барил хэрэглэх ёстой.

Ер нь сэтгүүлчдийн идэвхгүй, тууштай биш байдал олон алдаа дутагдлын эх үүсвэр болдгийг энд хэлэх хэрэгтэй.

Хараат бус байдал

Редакцийн бие даасан байдлын зарчмыг баримтлан үнэн зөв мэдээлэхийн зэрэгцээ сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэнээс ч, юунаас ч хараат бус байх нь олон нийтийн зүгээс хүндэтгэл хүлээх, тэдний итгэл найдварыг олж авахад хамгийн гол хүчин зүйл байдаг. Гэвч санхүүгийн, улс төрийн болон бусад нөлөөнд автах нь манайд түгээмэл байгаа бөгөөд энэ нь дараах байдлаар илэрч байна:

Бодит байдлыг гажуудуулах. Энэ нь үнэнд нийцээгүй мэдээллийг нягтлалгүйгээр нийтлэх буюу улс төрийн нам болон нэр дэвшигчдийг магтан гоёх юмуу харлуулан муулах байдлаар илэрдэг. Нийтлэл, нэвтрүүлэг бэлтгэхдээ техникийн аргаар гажуудуулж болдог (телевизийн дуранд цуглаанд оролцож байгаа хүмүүсийг олон болгож харуулах г.м.)

Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн хэрэгсэл олон түмэнд үйлчлэхээс биш, улс төрийн нам, улс төрчдөд үйлчлэх ёсгүй.

Тэнцвэргүй мэдээлэх, нэг талыг барих. Мэдээлэл нь үнэн зөв, бодитой боловч аль нэг нам, нэр дэвшигчийн дагнасан сурталчилгаа хийх буюу бусдаас нь илүүтэйгээр мэдээлэхийг хэлнэ. Энэ нь тоо болон чанараар илэрч болдог. Тэнцвэргүй мэдээлэх нь

санаатайгаар хийгдэхээс гадна санамсаргүй байж болно. Тухайлбал сэтгүүлчид цаг хугацаанд шахагдсанаас болж тэнцвэрийг алдагдуулах явдал гардаг.

Тэнцвэргүй мэдээлэл гардгаас болж улс төрчид хэвлэл мэдээллийн хэрэгслийг алгасаж сонгогчидтой шууд харьцах явдлыг сонгоход хүрдэг. Тухайлбал, радио телевизээр шууд нэвтрүүлэг хийхдээ сэтгүүлчийн оролцоогүй, сонгогчдоос шууд асуултыг нь авч хариулах замаар харьцдаг. АНУ-д 1988 онд явуулсан судалгаагаар сонгогчид нэр дэвшигчдийн тухай хамгийн сайн мэдээллийг сэтгүүлчдээс бус улс төрчдөөс өөрсдөөс нь авдаг гэсэн дүгнэлт гарсан байна.

Бүрэн бус дүр зураг. Энэ нь сонгуулийн кампаний өмнөх үеийг мэдээлдэггүй, мөн сонгуулийн дараа түүний мөрөөр сурвалжлах явдлыг орхигдуулдаг байдлаар илэрч болно. Жишээ нь, АНУ-д улс төрийн нам, нэр дэвшигчдэд өгсөн хандивыг нарийн мэдээлдэг мөртлөө сонгуулиас хойш хандивлагчдын ашиг сонирхол яаж илэрч байна гэдгийг тэр болгон эрэн сурвалжилдаггүй юм байна.

Сонгуулийн сурталчилгаа албан ёсоор эхлээгүй боловч аль намаас ямар хүмүүс нэр дэвших магадлалтай байгаа талаар олон нийтэд мэдээлэл хүргэх талаар сэтгүүлчид ажиллаж болох юм.

Нөлөөнд автах. Сэтгүүлч, ХМХ улс төр, бизнес, ХМХ эзэн, эрхлэгч, редактор, спин докторуудын нөлөөнд автах нь янз бүрийн хэлбэрээр илэрдэг.

Өөрийн цензур нь бэрхшээл, дарамт, шахалт, айдсаас бий болдог. Жинхэнэ чөлөөт хэвлэл бол засгийн газар, улс төр, эдийн засгийн эрхшээлээс ангид, нийтлэл нэвтрүүлгийг бэлтгэн түгээхтэй холбоотой эд материалын болон дэд бүтцийн эрхшээлээс хараат бус байна гэж Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны 1991 оны Виндхукийн тунхаглалд заасан байдаг.

Санхүүгийн бэрхшээл. Сэтгүүлчид улс төрийн болон бусад үйл явдал, арга хэмжээнд оролцоход тэр болгон мөнгө төгрөг, санхүү хүрэлцдэггүй. Иймээс зохион байгуулагчид төлбөрийг төлж энэ нь улмаар тэдэнд нийтлэл, нэвтрүүлэгт нөлөөлөх үүд хаалгыг нээж өгдөг.

Дарамт, шахалт

Хэвлэл мэдээлэл хараат байх нь олон шалтгаантай байдаг боловч тэр болгон дарамт, шахалт болохгүй байж болох юм. Дарамт, шахалтаас болж гүтгэлэгийн чанартай мэдээлэл гаргах, эсвэл Гэтэл үнэн бодитой мэдээлэл гаргасаныхаа төлөө ноцтой байдлаар дарамт шахалтанд орох явдал байсаар байна.

Хууль тогтоомж. Сонгуулийн тухай хууль, эрүүгийн болон бусад хуулийн заалтууд сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд дарамт болдог. Ялангуяа албан тушаалтны нэр төрийг гутаасан, тэднийг гүтгэсэн гэх хэргүүд хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд ихээхэн төвөг учруулдаг.

Төрийн мэдлийн ХМХ. Төрийн мэдлийн ХМХ эрх баригчдыг сурталчилж, өөр үзэл бодлыг гаргахгүй, сөрөг хүчнийхэнд үгээ хэлэх боломж олгохгүй байх нь түгээмэл ажиглагддаг. Түүнээс гадна төрийн хяналтанд байгаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр “далд сурталчилгаа” хийгддэг.

Эрх баригчдын зүгээс дарамтлах. Энэ нь төрөл бүрийн шалгалт (хуулийн биелэлтийн, татварын, техникийн стандартын) болон хүнд суртлын бусад арга хэлбэрээр илэрдэг.

Айлган сүрдүүлэх явдал улс төрийн, бизнесийн болон гэмт хэргийн бүлэглэлийн зүгээс гарч болно.

Ёс зүй

Нийтлэг болоод тухайлсан хэм хэмжээ. Сонгуулийн кампанийг мэдээлэхэд баримтлах ёс зүйн зарчмууд нь хэвлэл мэдээллийн ерөнхий ёс зүйд багтна. Эдгээр нь нийтлэг болон тухайн ХМХ-ийн өөртөө тогтоосон хэм хэмжээ болно.

Ашиг сонирхлын зөрчил нь сонгуулийн үйл явцыг мэдээлэхдээ өөрийн үзэл бодолд хөтлөгдөх, сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагааг хувийн ашиг сонирхолд ашиглах зэрэгт илэрдэг. Сонгуулийн үеэр нэр дэвшигчийн хэвлэл мэдээллийн албанд орж ажиллах явдал нь мөн л ашиг сонирхлын зөрчил гэж үздэг.

Хараат Бус, Чөлөөт Хэвлэл мэдээлэл

(Транспаренси Интернейшнл олон улсын байгууллагын материалаас авав)

“Өнөөгийн Америкт эрх мэдэл гэдэг бол мэдээллийн хэрэгслийг хянах явдал мөн”.

Теодор Уайт

Мэдээлэлгүйгээр хариуцлага үгүй. Мэдээлэл бол эрх мэдэл. Мэдээллийг олон хүн эзэмших тусам эрх мэдэл тэр хэмжээгээр тархдаг. Ард түмэн мэдээлэл олж авах бололцоотой байна гэдэг бол хүмүүс улс үндэстэндээ итгэлтэй байх нэгэн тулгуур зарчим юм. Үүнгүйгээр ардчилсан байгууламжууд зохих ёсоор ажиллаж чадахгүй бөгөөд хувь хүмүүс нь, магадгүй өөрсдөө ч энэ тухай мэдэлгүйгээр, эрхээ эдлэж чадахгүйд хүрдэг. Олон нийтэд мэдээлэл хүргэх зарчмын гол хэрэгсэл нь хараат бус, чөлөөт хэвлэл мэдээлэл юм (1).

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрх чөлөө

Нийгмийн зүгээс аливаа үйл ажиллагааны хэдий чинээ нээлттэй ил тод хэв маягийг бий болгоно төдий чинээгээр олон нийтэд мэдээллийн хүртээмж нэмэгдэнэ. Нөгөө талаар хэт их мэдээллийн урсгал нь хамгийн идэвхтэй иргэний хувьд ч гэсэн нийгэмд болж буй бүх үйл явдлын талаар мэдээлэлтэй байх боломж барагтай л бол олгодоггүй. Парламентын болон төр засгийн төв болон орон нутгийн байгууллагын үйл ажиллагаа, шүүхийн хуралдаан, олон нийтэд нээлттэй хувьцаат компаний ажил энэ бүгд олон нийтэд нээлтэй байж болох боловч нэг ч иргэн эдгээрт бүгдэд нь биечлэн оролцоно гэдэг хэзээ ч бүтэшгүй нь ойлгомжтой. Ийм тохиолдолд бидний ганц найдвар нь бүрэн төгс, мэргэжлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл мөн бөгөөд эдгээр нь өдөр тутам гарч буй их мэдээллийг шигшин, олон нийтийн сонирхол татах мэдээллээс бидэнд хэрэгтэйг нь маш оновчтой, ухаалагаар сонгон улмаар шударга, хариуцлагатайгаар хүргэх үүрэгтэй. Мэдээж хэвлэл мэдээллийн хувьд нэг талаас олон түмэнд мэдээлэх гэсэн үндсэн хуулиар олгогдсон чиг үүрэг, нөгөө талаас олон уншигчийг өөртөө татах, аль болох өргөн реклам сурталчилгаа тавих, бодит орлоготой байх гэдэг ашиг сонирхлын зөрчил байсаар байх болно.

Чөлөөт хэвлэл мэдээлэл нь хараат бус шүүх засаглалын нэгэн адил улс төрчдийн өмнө хариуцлага хүлээх ёсгүй хоёр эрх мэдэл юм. Хоёул нийгмийн амьдралд корруцтай тэмцэх хүчирхэг зэвсэг юм. Гэхдээ хувийн эзэмшилд байгаа хэвлэл мэдээллийг шүүгч, улсын яллагч, прокурор нар шиг улс төрчид томилдог буку баталдаггүй. Төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслээс бусад нь өөрийн томилгоотой бөгөөд хувийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн бүтээгдэхүүнийг олон нийт хэрэгтэй гэж үздэг учраас

олон нийтийн дэмжлэг дээр оршин тогтнодог. Хамгийн ардчилсан гэгддэг улс оронд ч гэсэн байдаг үзэгдэл болох улс төрийн нөлөөллөөс хэвлэл мэдээлэл хараат бус, чөлөөтэй байх ёстой, байж ч чадна.

Хэвлэл мэдээлэл хувийн эзэмшилд байх нь бас нэг талаар аюултай. Энэ нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл цөөн хүний гарт төвлөрч олон нийтийн мэдээллийн хэрэгслийн конгломерат үүсэх явдал юм. Энэ байдал ардчилалд шууд заналхийлж болдог, учир нь хэрэв тэд хүсвэл сонгогчдын санаа бодлыг залуурдах чадвартай, гол улс төрийн намууд барьцаанд нь байдаг хүчирхэг хүмүүс болдог. Иймээс хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хоорондоо нэгдэх, нэг нь нөгөөгөө өөртөө уусган авах зэргийг хязгаарласан хатуу зарчимч хуулийн зохицуулалт байх шаардлагатай бөгөөд улс орнууд хэвлэл мэдээллийн зах зээлд ямагт өрсөлдөөн байх явдлыг баталгаажуулах ёстой. Глобальчлагдсан дэлхий ертөнцөд, ялангуяа сателит телевизийн эрин зуунд үүнийг хэрэгжүүлэхэд улам бэрхшээлтэй болж байна. Гэвч Интернэт хөгжихийн хэрээр мэдээллийг түгээх явдал зарим нэг талаар ардчилагдаж байна. Энэ үзэгдэл зарим бэрхшээл учруулж байгаа боловч гол нь дэлхий нийтийн мэдээллийн харилцаа нь хүчирхэг ашиг сонирхлын бүлгүүдийн дагнасан эрх мэдэл байхаа нэгэнт больжээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл ямар хэмжээнд хараат бус байгааг тэрээр төрийн албан хаагчдын үйл ажиллагааг хянах хоточ нохойн үүргээ хэрхэн биелүүлж чадаж байгаагаар хэмждэг. Хууль тогтоох байгууллага нь гүйцэтгэх засаглалыг өдөр тутам хянаж байх ёстойн нэгэн адил хэвлэл мэдээлэл хууль тогтоогчид болон гүйцэтгэх засаглалыг хоёуланг (төсвийн буюу нийтийн хөрөнгө мөнгөөр санхүүждэг бүх албан тушаалтанг) нь анхааралтай ажиглаж хянаж байх үүрэгтэй. “Эрх мэдлийг нь хараат бус хэвлэл мэдээллийн зүгээс хянахгүй бол ардчилсан зарчмаар сонгогдсон, аядуу засгийн газар ч гэсэн коррупцид хялбархан өртдөг” гэж Тайм Инкорпорэйтэд мэдээллийн компанийн ерөнхий эрхлэгч асан Хэнри Грюнвальд тэмдэглэсэн байдаг.

Коррупцтай тэмцэхэд хэвлэл мэдээлэл онцгой үүрэгтэй бөгөөд бас их эмзэг байдаг. Улс төрчид болон төрийн албан хаагчдын үйлдэл хэвлэл мэдээллээр ил тод бичигдэхгүй, олон түмний шахалтанд өртөх аюул байхгүй гэдэгт итгэлтэй байх тусам тэд бүгд өөрийн албан тушаалыг хувийн ашиг хонжоонд ашиглах сонирхолтой болдог. Улс төрчид дээрх байдлыг зорилго болгохдоо хэвлэл мэдээллийн амыг боох оролдлого ямагт хийсээр ирсэн. Хэвлэл мэдээллээ цензурддэг, хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд олон хориглолт тавьсан хуулиудтай, сэтгүүлчдээ байн байн шоронд хийдэг улс орон өнөөдөр ч гэсэн олон байна.

Өнөө үед сэтгүүлчийн мэргэжил хэзээ хэзээнээс илүү аюултай болж сэтгүүлчдийг хулгайлан барьцаалах, бие махбодь, эрүүл мэндэд нь халдах явдал гарсаар байна. “Муу мэдээ /зарим тохиолдолд шууд утгаараа/ авчирсан элчийг хөнөө” гэдэг зарчим улам бүр биеллээ олж байна. Эрх баригчид хэвлэл мэдээллийн хоточ нохойн үүргийг хязгаарлахыг эрмэлзэж, зарим тохиолдолд энэ хүсэл эрмэлзлэлээ ажил хэрэг болгосоноор айх эмээх явдалгүйгээр эрх мэдлээ урвуулан ашиглаж байна. Улсын нууцын тухай хууль гаргаж төр засгийн тухай иргэд мэдээлэл авах, хэвлэн нийтлэх эрхийг нь ихээхэн хэмжээгээр хязгаарлах явдлыг дэмждэг эрх мэдэлтнүүд өөрийгөө нээлттэй гэж тунхагладаг олон улс оронд байгаа бөгөөд тэд хэвлэлийнхэн “хариуцлагагүй” үйлдэл хийж магадгүй гэдгээр үүнийгээ хаацайлдаг юм. Эдгээр улс орон хатуу шийтгэл оногдуулдаг гүтгэлгийн тухай хуулиуд гаргаж ийм замаар хэвлэл мэдээллийнхэн болон хувь хүмүүсийг айлган сүрдүүлж хэвлэн нийтлэхээс зүрхшээхэд хүргэдэг.

Сэтгүүл зүйн мэргэжлийн хүрээнд коррупц бас байдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Жишээлбэл, Мексик, Энэтхэг зэрэг улс оронд сэтгүүлчид хариуцан сурвалжилдаг байгууллагаасаа урамшуулал авч бага цалиндаа нэмэрлэдэг байна. Индонез зэрэг бусад улс оронд ч гэсэн сэтгүүлчид иймэрхүү төлбөр авдаг. Иймэрхүү байдал нь

сэтгүүлчдийн зүгээс төрийн дээгүүр өндөрлөгт гарч буй зүй бус үйлдлийг сурвалжлах хүсэлгүй болгох том хүчин зүйл болдог.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдал

Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдал гэдэг бол маш адармаатай зарчим юм. Ерөнхийдөө энэ нь, сэтгүүлчид мэргэжлийнхээ ажил үүргийг биелүүлэхдээ аливаа хэлбэрийн нөлөөллөөс ангид байх ёстой гэсэн үндэслэл дээр төвлөрдөг. Гэтэл бодит байдалд хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшигчид сэтгүүлчдийн өдөр тутмын ажилд хөндлөнгөөс оролцож байдаг. Олон улс оронд засгийн газар нь өөрөө хэвлэл мэдээллийн хамгийн том эзэмшигч байдаг (үүнд зонхилох телевиз, радио байх нь элбэг тохиолддог) нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл жинхэнэ утгаараа төрөөс хараат бус байх зарчмыг алдагдуулдаг.

Төрийн өмчийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажилладаг сэтгүүлчдийн эрх, эрх чөлөөт байдлын хэмжээг дандаа биш гэхэд зарим тохиолдолд хуулиар хамгаалж баталгаажуулсан байдаг. Энэ талын хууль тогтоомж хангалтгүй байх явдал нь хэвлэл мэдээллийн хараат бус байдалд шууд аюул учруулдаг. Тухайлбал, Английн Би-Би-Си засгийн газрын хараа хяналтанд үйл ажиллагаагаа явуулдаг боловч тэрээр олон орны төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харьцуулахад хамаагүй илүү эрх чөлөөтэй, хараат бус байдаг гэж үздэг. Гэлээ ч Тэтчэрийн засгийн газар Би-Би-Си болон хувийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд Ирландын Бүгднайрамдах Армийн удирдагчидтай хийсэн шууд ярилцлагыг нэвтрүүлэхийг онцгойлон хориглосон байдаг. “Санхүүгийн хувьд хараат хэвлэл мэдээлэл жинхэнэ утгаар хараат бус байж чаддаггүй” гэсэн тодорхойлолт зарим талаар үнэн ажээ.

Одоогоор оршиж буй төрийн өмчийн буюу төрийн хяналтад байдаг хэвлэл мэдээллийн хэрэгслийг хувьчлах замаар хэвлэл мэдээллийн хараат бус байдлыг бэхжүүлэх хүчин чармайлт гаргах шаардлагатай юм. Үүний зэрэгцээ, дээр өгүүлсэнчлэн, хэвлэл мэдээллийн өмчийн олон хэвшлийг бий болгосон тогтолцоог хөгжүүлэх хэрэгтэй бөгөөд ингэснээр төрийн бодлогын асуудлаар олон ургальч үзэл бодлыг уралдуулах нөхцлийг бүрдүүлэн хэвлэлийн том эздийн улс төрийн эрх мэдлийг хязгаарлах бололцоотой.

Хэвлэл мэдээллийн зах зээлд бодит өрсөлдөөн байгаа тохиолдолд л чөлөөт, хувийн эзэмшлийн хэвлэл мэдээлэл оршин тогтноно. Хэвлэл мэдээлэл нь коррупцид автсан төрийн албан хаагчдад халгаатай байдгийн нэгэн адил хэвлэл мэдээллийн зах зээлийн өрсөлдөөн нь коррупцид автсан хэвлэлийн том эздийг илчилдэг. Жишээ нь, 1994 оны сүүлчээр Руперт Мэрдокийн удирддаг дэлхийн хэмжээний Ньюс Корпорэйшний эзэмшдэг ном хэвлэлийн газар тэр үед АНУ-ын Конгрессийн Төлөөлөгчдийн танхимын спикер байсан Нут Гингричид өөрийн тухай хоёр ном хэвлэхэд урьдчилгаа болгон 4,5 сая ам.доллар өгөх санал тавьжээ. Хэвлэл мэдээллийн олон хэрэгсэл энэ тухай шуурхай мэдээлж, зарим нь ноён Мэрдок өөрийн телевизийн ашиг сонирхолтой холбоотой асуудлаар Вашингтоны төр захиргаатай холбогдож байсан учраас Америкийн Бүгднайрамдах намын шинэ удирдагчид хахууль өгөхийг завдсан байж болох юм гэсэн таамаг дэвшүүлсэн билээ. Дээрхи мэдээний улмаас дурдагдсан хоёр номыг хэвлэх асуудлыг хүчингүй болгосон байна. Гэвч олон улс оронд мэдээллийн хэрэгсэл олон тоогоор өөр өөр эзэмшигчтэй байдаг иймэрхүү байдал ховор, өрсөлдөөн маш бага төдийгүй зарим тохиолдолд тухайн үеийн улс төрийн гөхцөл байдалд нийцсэн хэвлэл мэдээллийн “бүлэглэлийг” байгуулж болдог. Тухайн улс орны хэвлэл мэдээллийн хэрэгслийг нэг гэр бүл “удирддаг” явдал ч тохиолддог. Иймэрхүү хэт давамгайлсан байдалд хэвлэл мэдээллийн том эзэд өрсөлдөгчдийн зүгээс үйл ажиллагааг нь илчлэхээс айхгүйгээр барахгүй электрон мэдээллийн хэрэгслийн эрин үед тэд сонгуулийн үр дүнд ихээхэн хэмжээгээр нөлөөлөх улс төрийн эрх мэдэл олдог.

Цаашилбал, хөгжиж буй олон оронд хэвлэл мэдээлэлд рекламн орлого маш бага олддог. Иймээс эдгээр орны хэвлэл мэдээллийн хэрэгсэл санхүүжилт муутай, түүнээсээ болж хараат байдалтай байдаг. Нэг талаас том зар сурталчилгаа тавьдаг байгууллагууд (үүн дотор томоохон нь гол төлөв засгийн газар байдаг) хэвлэл мэдээллийн хэрэгслийг хатуу хяналтандаа байлгадаг, нөгөө талаас, өөрийн ашиг сонирхолд үйлчилсэн мэдээ материал бичүүлэхийн тулд улс төр, бизнесийн хүрээнийхэн цалин багатай сэтгүүлчдийг хахуульдах өргөн боломжтой байдаг. Иймэрхүү нөхцөл байдалд хэвлэл мэдээллийн хэрэгсэл хоточ нохойн үүргээ биелүүлж чадахгүй байх нь байнгын тохиолдол болдог. Ийм учраас хэвлэл мэдээллийн хэрэгслийн эзэмшлийн асуудал, тэр дотроо хувьчлалын асуудлыг нийгэм, эдийн засгийн агуулгаар нь маш их анхаарч авч үзэх шаардлагатай. Хэвлэл мэдээллийн салбар дахь монополь нь эдийн засгийн бусад хүрээн дэх монополиос хэтдээ илүү аюултай байдаг.

Манай ардчилсан байгууламжууд хэврэг байна, чөлөөт хэвлэл маань туршлагагүй байна гэж засгийн газрууд байнга ярьж хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшилдээ байлгаж байгаа нь тэдний гавъяа хэмээн маргадаг. Энэ нь зөв байх тохиолдол олон боловч, ийм нөхцөлд төрийн эзэмшлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл дангаар ноёрхож болохгүй. Засгийн газар хэвлэл мэдээллийг тодорхой хэмжээгээр хянах зайлшгүй хэрэгтэй гэж үздэг улс орнуудад төр засагаас чөлөөт хэвлэлийн эрхийг хамгаалах хамгаалалтын механизм буюу хараат бус зохицуулалт байх шаардлагатай.

Чөлөөт хэвлэлийн баталгаа нь хэн байвал зохих вэ?

Хэвлэлийн цензур нь янз бүрийн хэлбэрээр илэрдэг бөгөөд бараг бүх улс оронд толгойгоо өндийлгөж байна. Цөөн улс оронд хэвлэлийн эрх чөлөөний туйлын баталгааг хууль эрхийн тогтолцоогоор хангасан байдаг. АНУ-ын Дээд Шүүхийн шалгуурыг давсан АНУ-ын Үндсэн Хуулийн 1-р нэмэлт өөрчлөлт нь нийгмийг цензурээс чөлөөтэй байлгах хосгүй хуулийн заалт юм. Малави улсын Үндсэн Хууль гэхэд л хэвлэлийн эрх чөлөөний коцепцийг нэг удаа биш, бүр хоёр удаа тунхагласанаар давтагдашгүй байдаг. Тэрээр:

“Хүн бүр үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй” гэж тунхаглаад, улмаар

“Хэвлэл мэдээллийн байгууллага нь Малави улс дотроо болон гадагшаа чөлөөтэй мэдээлж, нийтлэх эрхтэй байх ёстой бөгөөд төр засгийн мэдээллийг олж авах боломжтой бүх арга хэрэгслээр хангагдсан байвал зохино” гэжээ.

“Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх” явдлыг тунхагласан хуулиудыг шүүх хэрэгжүүлж дэмжих шаардлагатай байдаг. Хараат бус шүүх бол чөлөөт хэвлэлийн шадар туслагч л гэсэн үг. Хараат бус шүүх байхгүй бол хэвлэлийн эрх чөлөө мөрөөдөл төдий болдог. Иймээс чөлөөт хэвлэлийг бий болгох урьдчилсан нөхцөл бол үндсэн хуульд заасан чөлөөт хэвлэлийн зарчмыг дэмжсэн хууль тогтоомжийг хатуу баримталдаг, улс төрийн нөлөөллөөс хараат бус хууль зүйн тогтолцоотой байх явдал юм. Иргэний болон Хүний эрхийн тухай Олон улсын ковенцийн 19-р зүйлийн заалтуудыг баримлал болгосон тохиолдолд хүчирхэг хууль зүйн тогтолцоог бий болгож болох юм.

Өргөн хүрээнд хүлээн зөвшөөрөгдсөн энэхүү эрхүүдийг хязгаарлах нь хувь хүний эрх буюу нэр хүнд болон үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбоотой байдаг. Олон сэтгүүлч ийм хязгаарлалт байхыг зөвшөөрч болох боловч хязгаарлалтууд нарийвчилсан тайлбартай байх ёстой гэдэг дээр бүгд санал нийлдэг. Төрийн албан хаагчийн олон нийтийн нэр хүндийг хохирооход хүргэнэ гэсэн айдсаас болж сэтгүүлчид хэвлэн нийтлэхээс эмээхэд хүргэсэн хязгаарлалт хууль журамд байж болохгүй. Ийм хязгаарлалт нь хэрэг дээрээ үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг үгүйсгэсэн болно. Иймээс ч Европын Хүний Эрхийн Шүүхийн тодорхойлсноор, улс төрчид “өөрийн хэлсэн үг, хийсэн үйлдэл бүр нь ил тод нарийн хараа хяналтад байх ёстойг сэтгүүлчид

болон өргөн олон нийтийн өмнө гарцаагүй хүлээн зөвшөөрөх ёстой, тэд бусдаас илүүтэйгээр хүлээцтэй байх ёстой” гэжээ.

Залуу, хэврэг ардчилсан тогтолцоонд хэвлэл мэдээлэл нь туршлага хомс бөгөөд хариуцлага багатай байх хандлага ихээхэн өндөр байдаг. Хэвлэл мэдээлэл хариуцлагагүй байх бүх боломжийг угтаа хангасан хууль тогтоомж нь шинэ тутам хөгжиж байгаа ардчиллын хөгжилд муугаар нөлөөлж болно. Ийм нөхцөлд Хэвлэлийн Зөвлөл байгуулах нь зөв зүйтэй байж болох юм. Хэвлэлийн зөвлөл нь ерөнхийдөө олигтой амжилтанд хүрч байгаагүй боловч хэвлэл мэдээллийн талаар гарсан санал гомдлыг олон нийтийн оролцоотойгоор нээлттэй хэлэцэх боломжтой байдлаар бүтэц, зохион байгуулалтыг нь хийж, хариуцлагагүй хэвлэлийг шийтгэх зэргээр хэвлэл мэдээллийн үйл ажиллагаанд (тодорхой хэмжээгээр) нөлөөлөхүйцээр байгуулж болох юм.

Хэвлэлийн зөвлөл хараат бус, түүнийг удирдаж буй хүмүүс нь аль нэг талыг барьдаггүй байр суурь, шударга шулуунараа өргөн хүрээнд хүндлэгдсэн байх хэрэгтэй. Ийм байгууллага нь цензурын хүчирхэг зэвсэг болохгүйн тулд хуулийн хариуцлага хүлээлгэх эрх мэдэлгүй байх ёстой. Харин нэр хүнд шударга байдлаараа дүгнэлтүүд нь ёс суртахууны талаар хүчирхэг байх ёстой. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн талаарх санал гомдлыг Хэвлэлийн зөвлөл судалж үзээд гаргасан дүгнэлтийг тухайн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд бүрэн хэмжээгээр, засаж хасалгүйгээр хэвлэх шаардлага тавигддаг байвал зүйтэй.

Хариуцлагатай, хариуцлагагүй сэтгүүл зүй хоорондоо маш нарийн шижмээр холбогддог. Цаг хугацаа, хаана болж байгаа зэрэг нь үүний үнэлгээнд нөлөөлөх чухал хүчин зүйлүүд байх учиртай. Тиймээс хариуцлагатай хэвлэл мэдээлэлтэй байхын тулд засгийн газар, шүүхийн хүчээр хэвлэлийг дарж байхын оронд Хэвлэлийн зөвлөлийн ёс суртахууны хүчин зүйлээр нөлөөлөх нь илүү үр дүнтэй арга зам юм. Хэвлэлийн хариуцлагыг хэт тунхаглах явдал ихэнхдээ чөлөөт хэвлэлийг зөвхөн “зохистой хэмжээнд” баталгаажуулсан хууль, тогтолцоотой байх явдалд хүргэдэг. Туршлагаас харахад “зохистой хэмжээнд” хэмээсэн нэр томъёо нь маш субъектив чанартай бөгөөд энэ утгаар нь хүлээж авбал цензурын төрөл бүрийн хэлбэр рүү гулсан орох халтиргаат замын эхлэл болно.

“Зохистой хэмжээнд” байлгах эрмэлзлэл ихэнхдээ үндэсний аюулгүй байдлын асуудалтай холбогдож гарч ирдэг. Их Британий Албан ёсны нууцын хууль болон бусад орны үүнтэй төстэй хуулиуд нь засгийн газрын бүхий л нууц үйл ажиллагааны халхавч болж болдог талтай. Нэг жишээ хэлэхэд, 1970-аад онд Ерөнхийлөгч Никсон Цагаан ордны хуралдаан, ярилцлагын соронзон бичлэгүүдийг үндэсний аюулгүй байдлын үндэслэлээр шүүх болон Конгресст өгөхгүй байхыг оролдсон байна. Гэвч эдгээр бичлэгийг нийтэлсний дараа ингэснээр үндэсний аюулгүй байдалд харш зүйл болсон гэж тун цөөхөн хүн шүүмжилсэн гэдэг.

Төр засгийн удирдлага олон арван жилийн турш асуудалд “нууц”, “маш нууц” гэсэн хаяг зүүж мэдээллийг олон нийтэд дэлгэхийн эсрэг хүчтэй сэтгэл зүйн саад бий болгон үндэсний аюулгүй байдлаар шалтаглан мэдээллийг нийтэд ил тод болгохгүй байхыг ямагт оролддог. Энэ асуудалд үлгэр жишээ хандлага бий болгоё гэвэл нууцлалын үндэслэлийг дүгнэхдээ хараат бус шүүх бодитой байр сууринаас ханддаг байх нь чухал. Засгийн газар нууцлалыг ноцтой бөгөөд зайлшгүй гэсэн үндэслэл гаргасанаас бусад тохиолдолд төр засгийн бүх мэдээлэл олон нийтийн хүртээл байх ёстой гэсэн байр сууринаас шүүх хандах хэрэгтэй. Нууцлал нь үндэсний аюулгүй байдлын үндэслэлтэй (энэ нь ч харьцангуй ховор) гэхээсээ илүү хувь хүний хууль ёсны нууцыг юмуу бизнес арилжааны нууцыг хамгаалах үндэслэлээр хийгдэх нь илүү байдаг.

Хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах хамгийн үр ашигтай тогтолцоо нь хэвлэл мэдээлэл өөрөө өөрийгөө няхуур хянаж дүгнэх чадвартай байдаг тийм тогтолцоо юм. Хэвлэн нийтлэгч болон сэтгүүлчдийг эрх чөлөөтэй байлгана гэдэг нь нөгөө талаар тэднийг олон нийтийн өмнө хариуцлагатай шийдвэр гаргах хүнд ачаа үүрүүлнэ гэсэн үг юм. 1960-аад онд Нью-Йорк Таймс сонин АНУ-ын Батлан Хамгаалахын департаментад байсан эх сурвалжаасаа хэдэн мянган хуудас бүхий баримт бичиг авчээ. Вьетнамын дайнтай холбоотой энэхүү баримт бичиг хожим “Пентагоны баримт бичиг” нэрээр алдаршжээ. Нью-Йорк Таймс сонины эрхлэгчид дээрх баримт бичгийн үнэн бодитойг баталгаажуулж, улмаар нийтлэх нь хариуцлагатай үйлдэл мөн эсэх дээр хэдэн өдрийн турш толгойгоо гашилгажээ. Тэд үндэсний аюулгүй байдлын асуудал, олон түмний мэдэх эрх хоёрын аль нь давамгайлахыг цэгнэж байжээ. Тэгээд эцэст нь дээрх материалыг нийтлэхээр шийдвэлэсэн байна. Энэ шийдвэр хялбар байгаагүй бөгөөд материал нийтлэгдсэний дараа төрийн удирдлагын мэргэжлийн хүмүүс, хууль эрх зүй, хэвлэл мэдээллийн салбарын туршлагатай мэргэжилтнүүд энэ талаар янз бүрийн байр суурьтай байдаг нь харагдсан байна. Гэвч, тэр нь зөв ярьж байна гэж, эсвэл сэтгүүлчдийн шийдвэр нь өөр салбарын мэргэжилтнүүдийн байр сууринаас давуу талтай гэж хэлэх боломжгүй байлаа.

“Пентагоны баримт бичгийг” нийтлэх шийдвэрийг шүүх анхааралтай судлаж үзээд, энэ нь АНУ-ын Үндсэн Хуулийн 1-р нэмэлт өөрчлөлт заасан хэвлэлийн эрх чөлөөний асуудал нь энэ тохиолдолд АНУ-ын засгийн газраас дэвшүүлсэн үндэсний аюулгүй байдлын асуудлаас илүү ач холбогдолтой гэж үзжээ. Хараат бус шүүхийн систем иймэрхүү байдлаар шийдэх нь яваандаа хэвлэлийн эрх чөлөөний уламжлал бий болоход сайн түлхэц болдог. Төр засгийн бараг бүх мэдээлэлтэй танилцах эрхийг иргэн болгондоо олгосон АНУ-ын 1966 онд баталсан Мэдээллийн эрх чөлөөний хуультай адилтгаж болох “гэрэл гэгээтэй байх хууль” гаргаж дээрх уламжлалыг улам бататгаж болох юм.

Хэвлэлийн эрх чөлөөний соёл, уламжлал нь хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн эрхлэгчид болон сурвалжлагчдын хариуцлагатай үнэлэмжийг шүүх засаглалын тууштай дэмжлэгтэй хослуулсан тохиолдолд улам хөгждөг. Чөлөөт хэвлэлийн соёл нь хэвлэлийн эрх чөлөөний болоод төрийн албан хаагчдын үйл ажиллагааг хянах хоточ нохойны үүргээ бүрэн хэрэгжүүлэхэд хамгийн чухал баталгаа болдог. Сэтгэл хангалуун оршигчдыг (буюу төрийн албан тушаалтнуудыг) зовоож, зовж байгаа нэгний (буюу олон түмнийг) сэтгэлийг засах нь хэвлэл мэдээллийн үүрэг гэсэн ойлголт нь чөлөөт хэвлэлийн соёлын бүрэлдэхүүн байх ёстой гэдэг нь өнөөдөр ардчилалтай олон орны жишээн дээр харагдаж байна.

Иймэрхүү соёл нь заримдаа хэвлэл мэдээллийн хариуцлагагүй байдалд хүргэдэг нь ойлгомжтой. Энэ бол зайлшгүй үр дагавар. Ийм байдал гарах үед ухаалаг шүүх болон үр ашигтай Хэвлэлийн Зөвлөл тусалж дэмжиж чадна. Ямар ч гэсэн, хэвлэлийн эрх чөлөөг баталгаажуулах илүү эрхэм үйлсийн төлөө нийгэм тодорхой хэмжээний хөлс төлөхөд бэлэн байх ёстой. Английн Хэвлэлийн гомдол шүүх комиссын дарга, Дюррисын лорд МакГрегори хэлсэн үгийг бүхэлд нь биш юмаа гэхэд гол санааг нь хүлээн зөвшөөрөх нь зөв зүйтэй санагдана. Тэрээр хэлэхдээ: “Хэвлэл мэдээлэл хариуцлагатай ажиллах ёстой гэж үздэг нийгэмд эрх чөлөөний үнэ цэн болгож хэвлэлийн хариуцлагагүй, заримдаа цочирдмоор хариуцлагагүй үйлдлийг тэвчих хэргтэй байдаг. Учир нь хариуцлагатай байх эрх чөлөөтэй хэвлэл нь хариуцлагагүй байх эрх чөлөөг мөн эдлэх ёстой” гэжээ.

Хэвлэлийн эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой бүх асуудалд хамгийн чухал хүчин зүйл нь хэвлэлтэй холбоотой хязгаарлалтыг тогтоохдоо олон нийтээр хэлэлцүүлж, хамгийн шударга хүмүүсээс бүрдсэн бүрэн хараат бус шүүх тайлбар өгдөг байх явдал юм.

“Өөрийн цензур”

Илүү их аюултай нь өөрийн цензур байдаг. Энэ нь сэтгүүлчид болон редакторууд тухайн мэдээллийн хэрэгслийн эзэмшигчид буюу түүнтэй ойр хүмүүсийн болон бизнес ашиг сонирхлыг хөсөрдүүлэхээс эмээсэндээ тодорхой сэдвийг хөндөхгүй байх явдал юм. Ингэснээс болж тухайн сэдэв ор тас бичигдэхгүй буюу бичигдлээ ч дээд тал нь ёс зүйгүй болдог. Өөрийн цензур нь мунхаг хэлбэр (ач холбогдолтой сэдвийг “чухал биш” гэдэг үндэслэлээр хөндөхгүй байх)-ээс өгсүүлээд хэвлэл мэдээллийн хэрэгслийн өөрийн ашиг сонирхолтой зөрчилдөх (зар сурталчилгаа өгдөг байгууллага, хүмүүс буюу тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслэлийн нөлөө бүхий албан тушаалтнуудын найз нөхдөд сөргөөр нөлөөлөх учраас материал нийтлэгдэхгүй байх) хүртэл олон хэлбэртэй байж болно.

Редакцийн зөвлөл нь дор дурдсан маягийн мэдэгдэл хийсэн бол мэдээллийн хэрэгслийн эрхлэгчид тун завшаантай хэрэг болно.

“Тайм Инкорпорейтед-ийн сэтгүүлүүдийн санхүүгийн амжилт нь тэдгээрийн нэр хүндтэй зайлшгүй холбоотой гэдгийг Тайм Уорнер-ын зөвлөл, түүний ерөнхийлөгч болон Тайм Инкорпорейтед-ын ерөнхийлөгч нар хүлээн зөвшөөрч байна. Тайм Инкорпорейтедийн ерөнхий эрхлэгч нь тус компанийн сэтгүүлүүдийн нэр хүнд болон нийтлэлийн чанарыг Зөвлөл болон ерөнхийлөгчийн өмнө хариуцна. Үүний хариуд тэд ерөнхий эрхлэгчийн хараат бус байдлын өвөрмөц түвшинг хүлээн зөвшөөрөх юм.

Ерөнхий эрхлэгчийн хяналтан дор гарах нийтлэлүүд нь уншигчдад задлан шинжилсэн, олон талыг хамарсан мэдээлэл, тойм, тайлбарыг хүргэх учиртай. Нийтлэлүүд нь мөн зар сурталчилгаа тавигчдын тоо томшгүй олон эрх ашиг болон Тайм Уорнерийн өөрийн эрх ашгийг аль нэг талыг баримтлалгүй гаргаж байх учиртай.

Чөлөөт хэвлэлийн зарчмууд

Хэвлэл мэдээлэлтэй харилцахдаа удирдлага болгох үндсэн зарчмуудыг засгийн газрууд тогтоох хэрэгтэй. Үүний нэг жишээ нь Цензурын асуудлаар болсон Эрх чөлөөний дуу хоолой дэлхийн бага хуралд оролцсон 34 улс орны сэтгүүлчдийн баталсан Чөлөөт хэвлэлийн харти юм. “Эдгээр зарчмуудыг ардчилсан институтуудыг хөгжүүлэн хамгаалахыг зорьж буй хэн боловч дэмжвэл зохилтой” гэж НҮБ-ын Ерөнхий Нарийн бичгийн дарга Бутрос Бутрос-Гали онцлон тэмдэглэсэн юм. Тэрээр эдгээр зарчмуудыг заавал дагах албагүй боловч “чөлөөт улс үндэстэн бүр” хэрэгжүүлэхийг зорих нь зүйтэй гэж тэрээр нэмэж хэлсэн юм.

Хартийн зарчмууд дараах байдлаар тодорхойлогджээ:

- Шууд буюу шууд бус цензур байж болохгүй. Иймээс мэдээллийн хэрэгслийн мэдээлэл олж авах болон түгээх эрхийг хориглосон хууль тогтоомж, хэвшсэн үйл ажиллагааг үгүй болгох ёстой. Засгийн газрын төв болон орон нутгийн байгууллагууд хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл болон радио телевизийн мэдээний агуулгад хөндлөнгөөс оролцох буюу мэдээллийн аливаа эх сурвалжийг ашиглахыг хориглох ёсгүй.
- Бүх улс оронд хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл болон радио, телевизийн аль аль нь чөлөөтэй байгуулагдаж үйл ажиллагаа явуулахыг нь зөвшөөрөх ёстой.
- Тухайн улс оронд байгаа мэдээллийн хэрэгслийг засгийн газрын зүгээс эдийн засгийн талаар буюу аливаа байдлаар хавчин гадуурхаж болохгүй. Засгийн газрын мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл оршин тогтнож байгаа улс орнуудад хараат бус хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь албан ёсны мэдээллийн хэрэгсэлтэй яг адилхан бүх мэдээллийг авах болон нийтлэх, нэвтрүүлэхэд шаардлагатай бүх хэрэгслээр чөлөөтэй хангагдах ёстой.

- Төр засгийн зүгээс хэвлэлийн цаас, хэвлэх үйлдвэр, тараалтын систем, мэдээллийн агентлагын үйл ажиллагаа, радио телевизийн үелзэл болон нэвтрүүлэх төхөөрөмж зэргийг олж ашиглах явдлыг хязгаарлаж болохгүй.
- Мэдээлэл тараан түгээх явдлыг хязгаарлаж, мэдээллийн чөлөөтэй урсгалыг хориход чиглэсэн хууль эрхийн, техникийн болон тавар хураамжийн бодлого баримталдаг харилцаа холбооны салбарын төр засгийн байгууллагууд байж болохгүй.
- Төр засгийн мэдээллийн хэрэгсэлд редакцийн хараат бус байдлыг бүрэн хангаж өгөх, олон үзэл бодлыг илэрхийлэх явдал нээлттэй байх ёстой. Дээрхи байдлыг хуулиар баталгаажуулж амьдралд бодитойгоор хэрэгжүүлсэн байх шаардлагатай.
- Тухайн улс орны дотоодод байгаа хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл болон радио телевиз нь гадаад мэдээ, гадаадын мэдээллийн агентлагийн үйлчилгээг хязгаарлалтгүйгээр авах эрхтэй байх ёстой бөгөөд олон нийт ч гэсэн мөн нэгэн адил гадаадын нийтлэл, нэвтрүүлгийг хориг хязгаарлалтгүйгээр чөлөөтэй хүлээн авах эрх эдлэх ёстой.
- Улс үндэстний хил хязгаар гадаадын сэтгүүлчдэд нээлттэй байх ёстой. Гадаадын сэтгүүлчдийн тоонд квот үйлчлэх ёсгүйгээс гадна виз авах, ажил үүргээ хэрэгжүүлэхэд нь шаардагдах сурвалжлах эрхийн үнэмлэх зэрэг бичиг баримтыг шуурхай олгож байвал зохино. Гадаадын сэтгүүлчид тухайн улс оронд чөлөөтэй зорчиж албан болон албан бус эх сурвалжаас мэдээлэл олж авах, мөн мэргэжлийн техник, тоног төхөөрөмж, материал зэргийг чөлөөтэй оруулж ирэх, авч гарах боломжоор хангагдсан байх хэрэгтэй.
- Сэтгүүл зүйн салбарт чөлөөтэй орж ажиллах явдлыг лиценз, зөвшөөрлөөр хязгаарлахыг зогсоох хэрэгтэй.
- Сэтгүүлчид нийт иргэдийн нэгэн адил хувь хүний хувьд аюулгүй байж хуулийн бүрэн хамгаалатад байх ёстой. Дайны талбарт ажиллаж байгаа сэтгүүлчид энгийн иргэд гэж тооцогддог учраас энгийн иргэдэд хамаарах эрх, халдашгүй байдлыг эдэлдэг.

Хэвлэл мэдээллийг айлган сүрдүүлэх нь

Сэтгүүлчдийн эсрэг хүчирхийлэл олон оронд гарч байсан бөгөөд төр засгийн байгууллагууд нь энэ талаар юу ч хийх хүсэлгүй байгаагаа удаа дараа харууллаа. Ийм байдлын эсрэг дорвитой арга хэмжээ бол зөвхөн чөлөөт хэвлэлийн баталгаа болсон хууль тогтоомж, бүтцүүдийг бий болгох явдал мөн.

Жишээ нь, сүүлийн хэдэн жилд Алжир, Колумб зэрэг оронд олон тооны сэтгүүлчид амь насаа алдсан байна. Алуурчид нь олдоогүйгээр барахгүй ихэнх тохиолдолд эдгээр аллагыг зохион байгуулсан хүмүүсийг олох талаар эрх баригчид нь олигтой хүчин чармайлт гаргаагүй байна. 1994 онд болсон Америк хоорондын Хэвлэлийн Эвлэлийн Ерөнхий Ассамблей дээр тэмдэглэхдээ Куба дахь улс төрийн хоригдлуудын ихээхэн хувь нь “дайсны суртал нэвтрүүлэг хийсэн” гэдэг үндэслэлээр ял эдэлж байсан, “өнгөрсөн онд Колумбид арав, Мексикт дөрөв, Гватемалд гурав, Бразилд нэг сэтгүүлч алуулсан байна” гэжээ. Торонто хотноо болсон энэ хурлаас гаргасан тунхаглалд:

“Засгийн газар өөрийн зар сурталчилгааг нийтлүүлэхгүй байх, хэвлэл мэдээллийн хэрэгслийг хилс хэргээр шүүхэд өгөх, хар тамхины наймаачдын зүгээс хэвлэл мэдээллийг айлган сүрдүүлэх энэ бүхэн сэтгүүл зүйн үйл ажиллагааг чөлөөтэй явуулахад сааруулах нөлөө үзүүлж байна” гэж тэмдэглэсэн байдаг.

Зарим нэгэн сэтгүүлчдийг төр засгийн мэдээллээр илүү хангах болон ажиллах нөхцлийг нь илүү чөлөөтэй байлгах замаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийг засгийн газрын

зүгээс ялгаварлан үзэх явдал ердийн үзэгдэл байсаар байна. Энэ нь зөвхөн засгийн газрын мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ажилладаг сэтгүүлчдийг эн тэргүүнд мэдээлэллээр хангах шууд ил тод хэлбэр, эсвэл засгийн газрын зар сурталчилгааг зөвхөн засгийн газрын мэдлийн юмуу эсвэл засгийн газрын үзэл бодолд үнэнч хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тавих зальжин аргаар хэрэгжиж болдог байна.

Хэвлэл мэдээллийн хэрэгслийг айлган сүрдүүлэх буюу цензурдэхэд засгийн газрын байгууллагууд өөрийн хууль эрхийн болон зохицуулах эрх мэдлийг олонтаа ашигладаг. Тухайлбал, засгийн газар хэвлэл мэдээлэлд хязгаарлалт тавихдаа импортоор орж ирэх сонины цаасны хэмжээнд квот тогтоох, эсвэл хэвлэлд болон шуудан илгээмжинд онцгой татвар оногдуулах, хараат бус радио телевизийн нэвтрүүлгийн үелзэлд хязгаар тогтоох зэрэг байж болно. Електрон шуудан болон мэдээлэл харилцааны шинэ технологиуд хүмүүст үзэл бодлоо өргөн олон түмэнд чөлөөтэй илэрхийлэх олон шинэ боломжийг нээх тутам дээрх асуудал улам их ач холбогдолтой болох магадлалтай.

Сэтгүүлчид мэргэжлийнхээ ажлыг чөлөөтэй хийхэд эх сурвалжийг хамгаалах асуудал үндсэн шаардлага болдог. Мэдээллийн эх сурвалжаа илчлэхээс татгалзсанахаа төлөө торгуулах юмуу шоронд суух аюулаас айлгүйгээр нийтлэл нэвтрүүлэг хийж болно гэдэгт сэтгүүлчид итгэлтэй байх ёстой. “Нэрээ хэлэхээс татгалзсан” хүмүүс мэдээлэл өгөхдөө тэдний нэрийг төр засгийн байгууллага сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх замаар мэдэх боломжгүй гэдэгт итгэлтэй байх ёстой юм. Төрийн албан тушаалтнууд эрх мэдлээ урвуулан ашиглахын эсрэг үр ашигтай хүчин байхын тулд хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд дээрх баталгаа амин чухал юм.

Сэтгүүлчдэд лиценз, зөвшөөрөл олгох явдал олон хувилбартай байдаг бөгөөд ихэнхдээ айлган сүрдүүлэлтийн хэлбэрийг илэрхийлдэг. Зарим улс оронд засгийн газар нь хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон тэдгээт ажиллагсадыг бүртгэн зөвшөөрөл олгох ажлыг өөрөө шууд гүйцэтгэхийг эрмэлздэг бол зарим нэг оронд хэвлэл мэдээллийн үйлдвэрчний эвлэл нь гишүүдийнхээ үйл ажиллагаанд хязгаарлалт тавихыг зорьдог. Лиценз, зөвшөөрөл шаардах нь олон түмний ашиг сонирхолд нийцэхгүй. Лиценз, зөвшөөрлийг хүчингүй болгохдоо гадаадын сурвалжлагчдыг ч хамруулах ёстой. Тэд дотоодын бүх сурвалжлагчдын нэгэн адил байнга аль болох их мэдээлэл олж авах, мэргэжлийнхээ ажлыг хийх бүхий л бололцоогоор хангагдсан байх хэрэгтэй.

Жишээлбэл, сэтгүүлчдийн бичиж нийтлүүлсэн өгүүлэл нь төрийн өндөр албан тушаалтныг доромжилсон гэж үзвэл хатуу шийтгэл оногдуулдаг хуулиудыг сүүлийн хэдэн жилд Төв Европын олон улс ороны засгийн газрууд батлуулсан байна. Зарим тохиолдолд нийтлэл, нэвтрүүлэг үнэн бодит эсэхийг хуулиар ялгаж салгадаггүй байна. Өөрөөр хэлбэл, сэтгүүлч хүн төр засгийн удирдагчдын зүй бус үйлдлийн талаар үнэнийг бичсэн ч энэ нь нэр төр гутаасан гэх хэрэгийг шүүхээр шидвэрлэхэд сэтгүүлчийн хувьд хамгаалалт болохгүй гэсэн үг. Иймэрхүү хуулиуд нь сэтгүүлчдийг айлган сүрдүүлэх, цензурдэх хэлбэр болж коррупцид автсан албан тушаалтнуудад бүр ч завшаантай хэрэг болдог.

Хэвлэл мэдээллийг айлган сүрдүүлэх нь үнэн хэрэг дээрээ ямар зорилготой вэ гэдгийг шүүх хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Энэ нь коррупцийн уламжлалын гол зэвсэг, хүчирхэг ашиг сонирхлын бүлгүүд өөрийн коррупцийн үйл ажиллагааг тасралтгүй үргэлжлүүлэх хүчин чармайлт юм.

Шилдэг туршлагыг төлөвшүүлэх нь

Хариуцлагатай, хараат бус хэвлэл мэдээллийг төлөвшүүлэхэд гол ачааг хэвлэл мэдээлэл өөрөө үүрэх ёстой. Олон түмний итгэлийг олж авахын тулд сэтгүүлчид махруун ажиллах хэрэгтэй. Олон түмний итгэл, хүндэтгэлийг хүлээхийн тулд сэтгүүлчид хараат бус байдал, үнэн бодит мэдээлэл, мэргэжлийн үйл ажиллагааг өдөр тутам

илтгэх ёстой. Үүний зэрэгцээ сэтгүүлчид хараат байх биш хараат бус ажиллах сонирхолтой байхуйц цалинтай байх тал дээр хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшигчид анхаарах нь тэргүүн зэргийн ач холбогдолтой.

Хэвлэлийн эрх чөлөөг хамгаалах асуудалд үндэсний болон олон улсын олон байгууллага анхаарч байдаг. Чөлөөт хэвлэлийн зарчмуудад тохирсон хууль, тогтоомж гаргахад нь засгийн газруудад тусалдаг, үйл ажиллагааг нь дэмжвэл зохих олон байгууллагын дотроос заримыг нь дурдвал: Азийн Хэвлэлийн Холбооны Хороо, Сэтгүүлчдийг Хамгаалах Канадын Хороо, Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо, Дэлхийн Хэвлэлийн Эрх Чөлөөний Хороо зэрэг болно. Фридом Форум, Ройтерс Сан, Найт-Риддерийн сан зэрэг томоохон сангууд болон бусад олон сан сэтгүүлчийн сургалт хязгаарлагдмал улс орнуудад хэвлэл мэдээллийн чанар чансааг дээшлүүлэхэд чиглэсэн зохих сургалтууд явуулж байна. Коррупцийн эсрэг тэмцэлдээ сэтгүүлчид эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ур чадвараа улам сайжруулж, төр засгийн хариуцлагын тогтолцоо, орчин үеийн бизнесийн үйл ажиллагаа, мөн ялангуяа коррупцийн талаар ойлголт, мэдлэгтэй байх хэрэгтэй.

Шударга ёсны тулгуур болохын хувьд хэвлэл мэдээллийн үр ашигтай үйл ажиллагааны зарим үзүүлэлтүүд

Тухайн улс оронд:

- Мэдээллийн эрх чөлөөний хууль байна уу, мөн / эсвэл иргэд нь төр засгийн байгууллагаас мэдээлэл / баримт бичиг олж авах явдлыг баталгаажуулсан дүрэм журам байна уу?
- “Албан ёсны (төрийн) нууцын тухай хууль” байна уу, байдаг бол түүнийг хэвлэл мэдээллийг цензурдэх хэрэгсэл болгон ашиглаж байна уу?
- Олон түмэнд нөлөөлдөг хүмүүсийн тухай мэдээллийг түгээх явдлыг хаах болон хэвлэлийг хянахад гүтгэлгийн тухай хуулийг ашиглаж байна уу?
- Сэтгүүлчид лиценз, зөвшөөрөл авах шаардлагатай байдаг уу? Шаардлагатай бол үүнийг нь сэтгүүл зүйн чөлөөт байдлыг хаан боогдуулахад ашиглаж байна уу?
- Төрийн эзэмшлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл редакцийн хувьд засгийн газраас хараат бус байдаг уу? Үгүй бол, төрийн мэдлийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг өргөн олон мэдээллийн найдвартай эх сурвалж гэж үнэн хэрэгтээ үздэг үү?
- Төрийн эзэмшлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл эрх баригчдыг шүүмжилсэн материалыг (өөрөөр хэлбэл сөрөг улс төрийн хүчний удирдагчдын хэлсэн үгийн эшлэл нийтлэх зэргээр) нийтлэж нэвтрүүлэх нь ердийн үзэгдэл байдаг уу?

Өмчлөлийн хувьд

- Хэвлэмэл мэдээллийн хэрэгсэл (а), радио (б), телевиз (в)-үүдийн дотор өрсөлдөөн байна уу? Дангаар ноёрхлын эсрэг хуулиар өрсөлдөөнийг баталгаажуулсан байна уу, тийм бол энэ хууль хэрэгжиж байна уу?
- Хараат бус хэвлэл мэдээллийн салбар хөгжиж байна уу? (үүнд интернетийн мэдээллийн хэрэгсэл, албан бус сэтгүүл, мэдээллийн товхимол зэрэг хөгжиж байна уу?)
- Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд (хэвлэмэл, дуу-дүрсийн болон бусад) төр, засгийн байгууллагаас тусгай зөвшөөрөл авах ёстой юу? Тийм бол, үүнийг нь хэвлэл мэдээллийг цензурдэх хэрэгсэл болгон ашиглаж байна уу?
- Гадаадын хэвлэл мэдээллийн хэрэгсэл дотоодын нэгэн адил сурвалжлах болон нийтлэн нэвтрүүлэх ижил эрхтэй юу?

- Хэвлэл мэдээллийн хэргслийн эздийн хэвлэл мэдээллийн бус бизнесийн ашиг сонирхол (болон тэдгээрийн засгийн газартай холбогдсон бизнес ашиг сонирхол) –ын талаар олон нийт мэддэг үү?

Эрэн сурвалжлах сэтгүүл зүй

- Сэтгүүлчид амьжиргаандаа хүрэхүйц цалин авдаг уу?
- Хувийн болон төрийн хэвшлийн хүчирхэг лидерүүдийн коррупцийг илчлэх буюу ашиг сонирхлыг эрэн сурвалжилсан сэтгүүлчдийн амь нас аюулгүй байх баталгаа бий юу?
- Сэтгүүлчдэд гүтгэлгийн хэргээр эрүү үүсгэх явдал ховор байдаг уу эсвэл ердийн үзэгдэл үү?
- (а) Хэвлэмэл мэдээллийн хэргсэл, (б) радио, телевизүүд эрэн сурвалжлах сэтгүүлчдийн нийтлэлийг тогтмол хэвлэж, нэвтрүүлэг үү?
- Сэтгүүлчдийн сургууль, тэр дундаа эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сургалттай сургуулиуд байна уу?

Тайлбарууд:

1. Уламжлалт нэр томъёо нь “чөлөөт хэвлэл”. Гэвч электрон хэвлэл мэдээллийн хэргслийн ач холбогдол өсч, дэлхий дахинаа улам олон хүн мэдээллээ радио, телевизээс авдаг болсон тул илүү өргөн утгатай “чөлөөт хэвлэл мэдээлэл” гэсэн нэр томъёог одоо хэрэглэх болсон.
2. Зөвхөн сонгуулийн хувьд л гэхэд Интернет хэрхэн бэрхшээл учруулж болдгийг Канадын жишээн дээр харж болно. Канадын хуулиар улс төрийн зар сурталчилгааг нэргүйгээр нийтлэхийг хориглодог. Үүнд, бүх зар сурталчилгаа нь зохиогчийн нэртэй буюу ивээн тэтгэгчийн нэртэйгээр мөн тэдгээрийн улс төрийн харъяаллыг нэрлэсэн байх ёстой. “Зар сурталчилгааг ивээн тэтгэгчийн нэргүйгээр буюу ивээн тэтгэгчийн зөвшөөрөлгүйгээр явуулсан хэн боловч хуулийн хариуцлага хүлээнэ” гэж Канадын хуулинд заасан байдаг. Түүнээс гадна улс төрийн намын албан ёсны төлөөлөгчийг дэмжсэн аливаа гуравдагч талын сурталчилгааг (нэр устай буюу нэргүй байхаас үл хамааран) тэрхүү намын сурталчилгааны лимитэд оруулан тооцох ёстой гэж заажээ. “Тухайн нэр дэвшигч буюу улс төрийн намыг шууд дэмжсэн буюу шүүмжилсэн” сурталчилгаа гэж үзвэл дээрх хуулийн заалтууд Интернетэд байрлуулсан вэб хуудсанд мөн нэгэн адил хамаарна гэсэн үг юм. Бас нэг бэрхшээл бол Канад улс цагийн олон бүстэй. Сонгуулийн урдчилсан дүнг Канадын зүүн хэсэг дахь Халифакс мужид мэдээлсэн байхад түүнийг баруун хэсгийн Ванкуверийн сонгогчид саналын байр хаагдахаас өмнө мэдсэн байхаар мэдээлэхийг хориглодог. Нөгөө талаар олон нийтийн санаа бодлын судалгааны хувьд хориглосон зүйл бас бий. Тухайлбал, “Тухайн сонгуульд сонгогчид саналаа хэрхэн өгөхийг харуулсан буюу тодорхой асуудлыг аль нэг нэр дэвшигч болон улс төрийн нам дэмжиж байгааг харуулсан санал асуулгын дүнг сонгуулийн өмнөх Баасан гаригийн шөнө дундаас санал хураалт дуусах хүртэл хугацаанд нийтлэх, нэвтрүүлэх, тараахыг хэнд ч болов хориглоно” гэсэн хуулийн заалт байдаг байна. Дээр дурдагдсан бүх заалтуудыг Интернет хэрэглэгчид үгүйсгэж байна, ялангуяа Канад улсын гадна (жишээ нь АНУ-д) байршуулсан вэб хуудсуудын хувьд Канадын хууль үйлчлэхгүй.
3. 1993 оны 5-р сард Орос улсын Москва хотноо хэлсэн үгнээс иш татав.
4. Энэ байр суурийг Уганда болон Танзани улсад Транспаранси Интернейшнл ба Дэлхийн Банкны Хүрээлэнгээс зохиосон эрэн сурвалжлах сэтгүүл зүйн курсийг засгийн газрууд нь идэвхтэй дэмжсэн байдлаас харагдаж байна.
5. Хэвлэлийн талаархи Санал Гомдлын Комиссын хэм хэмжээний талаар ТИ-ын www.transparency.org вэб хуудаснаас харж болно.

6. Сэтгүүлчид өөрсдийн бичиж буй материалд холбогдох хувь хүмүүсийг сүрдүүлдэг тухай Транспаренси Интернейшнл ба Дэлхийн Банкны Хүрээлэнгээс сүүлийн жилүүдэд эрэн сурвалжлах сэтгүүл зүйн сэдвээр явуулж байгаа семинарууд дээр олонтаа яригдсан байна. Материалыг бичиж нийлүүлэхгүй гэсэн болзолтойгоор нэр дурдагдсан хүмүүсээс хахууль авдаг байна. Хэрэв материал бичигдэн нийлүүлэгдсэн тохиолдолд, редакторууд болон эрхлэгчид нийтлүүлэлгүй дарагдуулсаныхаа төлөө хахууль авдаг байна.
7. Энэхүү конвенц 1976 оны 3-р сарын 23-наас үйлчилж эхэлсэн юм.
8. Энэхүү заалт 1999 онд Австралийн нэгэн хотод зөрчигдсөн гэж үздэг. Энэ хотын бүх мэдээллийн хэрэгсэл хэвлэлийн нэгэн магнатын эзэмшилд байсан бөгөөд тэрээр Австрали улс хаант засаглалтай байхыг эсэргүүцдэг нэгэн байжээ. Тиймээс ч Австралийн хаант засаглалын талаар Үндсэн хуулийн референдум явуулахад түүний бүх мэдээллийн хэрэгсэл бүгднайрамдах улсыг хамгаалсан байр суурийг илэрхийлжээ. Хаант засаглалыг хамгаалагчид олон талын үзэл бодлыг сонсох иргэдийн эрхийг зөрчсөн гэж үзэж энэ талаар Өрсөлдөөнийг дэмжих хороонд гомдол гаргажээ.
9. Пью Судалгааны Төвөөс АНУ-ын хэмжээнд сэтгүүлчдийн дунд явуулсан судалгааны дүнд үндэслэв. 2000 оны судалгааны дүнгээс харвал сэтгүүлчдийн 20 % нь тухайн хэвлэл мэдээллийн компанийн санхүүгийн ашиг сонирхолд харшилсан материал бичсэний дараа өөрсдийн эздийн зүгээс шүүмжлэл буюу дарамт шахалт үзсэн гэж мэдэгдсэн байна. Өөрийн цензурт автсан олонхи сэтгүүлч удирдлагаасаа ямар нэгэн дохио авсанаа хүлээн зөвшөөрчээ. Машины дилерүүдээр дамжуулалгүй шууд өөрсдөө машин тэрэг худалдаж авбал хямд тусах тухай өгүүллийг эрэн сурвалжлах сэтгүүлч нийтэлсэнээс болж Сан Хосе Меркюри сонин дилерүүдээс олдлг зар сурталчилгааны орлогоосоо 1 сая гаруй ам.доллар алдсан байна. Коламбиа Журнализм Ревью, 2000 оны 5,6 р сар, 41 р тал.
10. Мөн тэнд, 46 р талд.
11. Санкт Петербург Таймс (АНУ), 1997 оны 5 р сарын 15 ны дугаар.
12. Тус бага хурал Лондон хотноо 1987 оны 1 р сарын 16_18 нд World Press Freedom Publishers (FIFJ), International Press Institute, Inter-American Press Association, North American National Broadcasters Association, International Federation of the Periodical Press байгууллагуудын санаачлагаар болсон байна.
13. 1994 оны 10 р сарын 16-20 нд болсон Тус Холбооны 50-р Ерөнхий Ассамблейн хурал.

2004 оны УИХ-ын сонгуулийн мэдээлэл, сурталчилгааны төлөв байдал, хэвлэл мэдээллийнхэнд зориулсан санал

2000 оны УИХ-ын сонгуулийн дараах бараг 3 жил хагасын хугацаанд Монголын үндэсний телевиз ба Монголын үндэсний радио олон нийтийн болж чадаагүй, хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хариуцлага, ёс зүйн зарим чухал асуудлаар төдийлөн ахиц гараагүй буюу шийдэгдээгүй зэргийг харгалзвал 2004 оны УИХ-ын сонгуулиар өмнөх дутагдлууд давтагдах төдийгүй улам хурцаар илэрч гарах магадлалтай байна. Ийм нөхцөл байдалд юу хийх вэ гэдгийг нээлттэй ярилцлагын хүрээнд авч хэлэлцэх, санал болгох шаардлагатай. Гол зарчим бол Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд 2004 оны сонгуульд зүгээр нэг сурталчилгааны биш, харин олон нийтийн зүгээс улс төрийн намууд, нэр дэвшигчдэд нөлөөлөх, хянах хэрэгсэл болох зүгт томоохон алхам хийх хэрэгтэй. Энэ бүхнийг шийдэхийн тулд 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанийн мэдээлэл, сурталчилгааны ажиглалт, мониторинг, хэлэлцүүлгийн хүрээнд хэвлэл мэдээллийн өөрийн зохицуулалтын зарчмуудыг нэвтрүүлэх шаардлагатай гэсэн дүгнэлтийг хийлээ.

Дараах саналуудыг дэвшүүлж байна:

1. **2004 оны УИХ-ын сонгууль хүртэл хугацаанд энэ асуудлаар тогтмол уулзаж ярилцаж байх зохион байгуулалтын бүтцийг бий болгох. Жишээлбэл, хэвлэл мэдээллийнхний оролцоотой клуб байж болох юм. Үйл ажиллагааны журам, хуваарийг хэлэлцүүлж тохиролцох Цаашдаа цуврал уулзалтуудыг явуулж “Өнгөрсөн сонгуулийн сурталчилгааны сургамж”, “Сэтгүүлч хүн намын гишүүн байж болох уу? гэх мэт асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлэх. Улс төрчид, төрийн түшээдийг урьж оролцуулан ярилцлага, маргаан зохион байгуулах. Уулзалт, ярилцлагын материалыг мэдээллийн хуудас, хавсралт хэлбэрээр олшруулж шуурхай тарааж байх. Сонгуулийн сурталчилгааны үеэр баримтлах ёс зүйн код баталж гаргах. Улмаар хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид нэгдэж орох хөдөлгөөн өрнүүлэх.**
- **Дээрх цуврал уулзалтаас төрийн бус байгууллагуудтай хамтран улс төрийн намууд ба сонгуулийн зардлын сан, үүний дотор хэвлэл мэдээллийн сурталчилгаанд зориулсан зардлыг олон нийтэд нэгбүрчлэн зарладаг байх тухай заалтыг хууль тогтоомжинд, тухайлбал, ирэх сонгуулийн өмнө шинэчлэнэ хэмээн эрх баригчдын зүгээс амлаад байгаа УИХ-ын сонгуулийн хуулинд оруулахын төлөө ажиллах.**
- **Клубыг түшиглэн сонгуулийн сурталчилгааны байнгын ажиглалт явуулах хэсэг, бүлэг байгуулах. Эсвэл хөндлөнгийн байгууллагуудын дундаас сонголт хийж захиалга өгч хийлгээд үр дүнг хэлэлцэж байх. Ажиглалтыг хэд хэдэн байгууллага зэрэгцэн эсвэл төрөлжүүлэн (сонин сэтгүүл, радио, телевиз гэх мэтээр) явуулах. Ажиглалтыг зарчмыг боловсруулж одооноос эхэлж хэд хэдэн үе шаттайгаар өрнүүлэх. Сонгуулийн сурталчилгааны ид үеэр ажиглалтыг өдөр өдрөөр явуулж тойм дүгнэлтийг мэдээллийн хуудас хэлбэрээр олшруулан шуурхай тарааж байх.**

ХАВСРАЛТ

- **1996, 2000 оны УИХ-ын сонгуулийн кампанийг хэвлэл мэдээллийн хэрэгслүүд мэдээлсэн байдалд Монголын Хэвлэлийн Хүрээлэнгээс хийсэн мониторингийн товч тайлан**

Өнгөрсөн сонгуулийн “шалгалтанд” сэтгүүлчид тааруу үнэлэлт авсан

Монголын Хэвлэлийн хүрээлэнгийн сэтгүүл зүйн багш Д.Батжаргал

Сонгогчид улс төрийн нам, эвсэл, нэр дэвшигчдийн талаар бүрэн бодитой дүр зураг авч байж л сая зөв сонголт хийнэ. Тэрхүү дүр зургийг зөвхөн сэтгүүлчид л тэнцвэртэй нийтлэл, нэвтрүүлэг, хараат бус байдал, нам бүрт тэгш хандснаар бий болгоно. Өөрөөр хэлбэл цаг үеэ олсон, үнэн зөв мэдээллийг хүргэснээр сонгогчдод улс төрийн зөв сонголт хийх боломж олгодог.

Тэгвэл сүүлийн хоёр удаагийн сонгуульд /1996, 2000/ манай сэтгүүлчид ямар үр дүнтэй ажиллав аа гэвэл сонгогч олон өөр өөрийн үнэлэлтээ тавих байх. Ямар ч гэсэн өндөр үнэлгээ өгч чадахгүй нь мэдээж. Хэвлэлийн хүрээлэн 2000 онд сонгуулийн сурталчилгааны оргил үе болох 6 дугаар сарын 20-30-ныг сонгон авч өдөр тутмын дөрвөн сонин-“Монголын мэдээ”, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Зууны мэдээ”, Монголын радио, МҮТВ, “UBS”, “Ийгл”, “25-р суваг” телевиз зэрэг гээд хэвлэл мэдээллийн гол гол хэрэгслүүдийн нийтлэл нэвтрүүлэгт анализ хийсэн юм. Ингэхэд зөвхөн Монголын радиогийн бичлэг 90 минутын 63 хуурцаг, дөрвөн телевизийн бичлэг мөн тийм хэмжээний видео хуурцаг болж байлаа.

Монголын радио эхний өдрүүдэд мэдээ, реклам, сонгуулийн сурталчилгааны нэвтрүүлэг 6 цаг буюу эфирийн 17 цагийн 35 хувийг эзэлж байсан бол сарын сүүлчээр тухайлбал 29-30 өдрүүдэд 15 цаг болж эфирийн цагийн 88 хувийг эзэлж байлаа. Минутаар авч үзэхэд өдөрт 1020 минутын нэвтрүүлгийг явуулдаг бол сарын сүүлчээр сонгуулийн сурталчилгаанд 900 гаруй минутаа зарцуулж үлдсэн 120 минутанд гадаад мэдээ, цаг агаарын мэдээ, хөгжмийн аяз төдийхөн нэвтэрч байлаа. Энэ өдрүүдэд дотоод мэдээ дуу хөгжмийн нэвтрүүлэг эрс багасч УИХ сонгуульд нэр дэвшигч болон намын сурталчилгаанд гол анхаарлаа хандуулж байлаа.

Намуудад тэнцүү цаг өгнө гэж ярьдаг хэдий ч дээр авч үзсэн 11 өдрийн байдлаар зарим том намууд нам 1000-1038 минутын нэвтрүүлэг хийж байхад жижиг намууд нь 20-40 минутын нэвтрүүлэг явуулсан байна.

Сонгогчдод зөв сонголт хийхэд сэтгүүлчид туслах үүрэгтэй. Энэ үүднээс мэтгэлцээн, халз ярилцлага, нэр дэвшигчдийн болон намын мөрийн хөтөлбөрт дүн шинжилгээ хийсэн нэвтрүүлгийг түлхүү оруулах ёстой. Сонгогч олон ч үүнийг хүсч байгаа. Гэтэл ийм нэвтрүүлэг аль ч радиогаос сонсогдсонгүй. Тэр ч бүү хэл, сонгогчдын санал бодлыг шүүмжлэлтэй тусгасан нэвтрүүлэг бараг орсонгүй. Зөвхөн нэр дэвшигчдийг дэмжсэн олон нийтийн санаа бодлыг тусгаж байлаа. Ихэнх нь нэр дэвшигчдийг өөрийг нь өөрөөр магтуулсан нөхдөөр нь үнэлүүлсэн “Онцгой чухал хүн”, “Төрийн төлөө төрсөн хүн”, “Монголын төр энэ хүнээр дутаж байна”, “Шударга бус удирдагчдаас айж эмээх, зудардсан бялдуучлах, ая тал засах булчирхай түүнд огтоос хөгжөөгүй. Өнгө, мөнгө, нам гуравт бөхийж үзээгүй” гэсэн сэтгүүлч өөрийн үзэл бодлоор дүгнэсэн цагаан магтаал зонхилж байна.

Төрөл хэлбэрийн хувьд туйлын ядуу байлаа. Ганцхан жишээ дурдахад 6 дугаар сарын 26-ны өдөр нэр дэвшигч болон намын сурталчилгаа, рекламд зориулсан 53 нэвтрүүлэгт ярилцлага 3, хөрөг, тайлбар тус бүр ганцхан байгаа нь дээрх баримтыг нотолж байна.

Ихэвчлэн мөрийн хөтөлбөр, магтаалын үгээр холбосон нэр дэвшигчийн яриа орж байна.

Дөрвөн телевизийн нэвтрүүлгүүдийг аваад үзэхэд сэтгүүлчийн хөдөлмөр бага шингэсэн, зөвхөн захиалагч нам, эвсэл, нэр дэвшигчийн санаа бодолд хөтлөгдсөн, олон түмний эрх ашгийн үүднээс чухал асуудал хөндөөгүй байна. Энэ нь намууд хэвлэл мэдээллийн алба өөрсдөө нэвтрүүлгээ бэлтгээд зөвхөн эфирт цацах үүргийг телевиз гүйцэтгэж байсантай холбоотой болов уу. Ийнхүү сэтгүүлч, уран бүтээлийн байгууллага дамжуулагч болсноор сонгуулийн чухал нэвтрүүлэг нь сэтгүүл зүйн шинэ соргог уран бүтээл гэдгийг мартаж, зөвхөн телевиздээ мөнгө олох хэрэгсэл гэж үзэж гарын үзүүрээр хийж байсан гэхэд хэтрүүлэг болохгүй. Бүх телевизийн нэвтрүүлэг өөр хоорондоо төдийгүй, нэг телевизийн дөрвөөс таван нэвтрүүлэг адилхан, нэг загвартай болжээ.

Эхлээд намтар ярьдаг дараа нь тухайн нэр дэвшигчдийг хаана ч байхгүй гоц сод хүн хэмээн өргөмжилдөг, эцэст нь тойргийнхоо сонсогчидтой уулзаж ярилцдаг, тэднээс хэн нэг нь “Энэ маш сайн хүн. Би түүнд л саналаа өгнө” гэж яриад ганц нэг реклам оруулаад төгсгөдөг.

Энэхүү нэг хэв загвар нь сонгогчдыг залхаагаад зогсоогүй, үнэн зөв сонголт хийхэд олон түмэнд саад болсон ч байж болох юм. Манай сэтгүүлчид тухайн хэвлэл мэдээллийн байгууллага нь нэг нам, нэр дэвшигч нь нөгөөгөө гүтгэж дайран доромжилж байсан ч, сонгуулийн хууль зөрчсөн дутагдал доголдол гарсан ч тайлбар хийлгүй, сэтгүүлчийн эрэн сурвалжлах зүтгэл огт гаргалгүй тэр хэвээр нь нийтэлж нэвтрүүлэх буюу зарим тохиолдолд буруу тийш нь хүч оруулан сурталчлах, нэг эх сурвалжид найдах зэрэг дутагдал гарч байлаа.

Энэ нь сэтгүүлч улс төрийн үзэл бодлоороо биш, үнэнийг эрэлхийлсэн чин шударга байх ёс зүйгээ мартаж байгаа хэрэг юм. Ийм зүйлийг сэтгүүлчдээр хийлгэх, телевизээр гаргахын тулд нөгөө нам, нэр дэвшигч нь тэрхүү гүтгэлэгтэй холбогдох зураг, баримт, эсэргүүцэх иргэний хэлэх үг зэргийг бэлтгэж өгөөд уг мэдээллийг авсан сэтгүүлчийн “гараар могой бариулдаг” байна. Энэ мэтээр нам эвслийн гар хөл болж, улс төрийн аль нэг хүчний хэвлэл мэдээллийн ажилтны үүрэг гүйцэтгэдэг сэтгүүлч олон байлаа.

Мөнгө л авч байвал чөтгөр байсан ч бурхан мэтээр магтан нэвтрүүлж нийтэлдэг, аль ч нам хамаагүй, нэр дэвшигч л байвал өмнө нь бөхөлзөн, гөлөг мэт шарвалзан мөнгөний боол болдог дутагдлаа энэ 2004 оны сонгуульд бүү давтаасай билээ.

Олон түмний мэдээллийн хэрэгслийг нэг хүчний өмч мэтээр ойлгож ашиглах нь ард түмний эв нэгдлийг бусниулах, хэвлэл мэдээллийн хэрэгсэл хоорондоо сөргөлдөх муу талтайг мартаж боломгүй. Хувийн байлаа ч гэсэн “Чөлөөт хэвлэл мэдээлэл” гэсэн ариун хүндтэй, цаанаа ихээхэн утга учиртай нэр төрөө бодолцмоор юм даа. Түүнчлэн нэвтрүүлэг нь эфирт гарч байгаа үедээ саатах, эвлүүлэг нь туйлын муу, авцалдаа холбоогүй байсныг “Сонгогчдод хүрч л байвал юу ч яахав” гэсэн сэтгэхүйгээр гоомой хандаж байсны жишээ гэлтэй. Ийм гологдол “Ийгл” “25 дугаар суваг” “UBS” телевизийн нэвтрүүлгүүдэд олонтаа гарч байлаа.

Сонгуулийн мэдээ мэдээлэл захиалгат нэвтрүүлэг рекламнаас өөр нэвтрүүлэг байхгүй юм шиг эфирийн бүх цагаа үүнд зориулаад гадаад, дотоод /сонгуулийн биш/ үйл явдлын мэдээ, уран сайхны болон цэнгээнт нэвтрүүлэг, кино зэргийг орхигдуулсан ноцтой дутагдал МҮТВ, Ийгл, UBS-д нэлээд давтагдлаа. Сурталчилгаанд өрөөсгөлөөр хандаж, сонсогч олон түмэнд тулгах, хэт магтсан өнгө аястай жишээ олон байлаа.

Баянгол дүүргийн 66-р тойрогт нэр дэвшигч нэгэн эрхмийг “Ардчиллын анхны сэтгэгчдийн нэг. МСДН-ын баримт бичгийн эх зохиогч, намынхаа улс төрийн бодлогыг тодорхойлогч” гэсэн бол 64 дугаар тойрогт нэр дэвшигчийн сурталчилгаанд “Хүндтэй

сонголт тохиох болж. Түүнийг сонгох нь эрхэмсэг сонголт” гэж сүржигнэжээ. Мөн 66 дугаар тойрогт нэр дэвшигчийн рекламд "Шударга үнэний төлөө ганц зүтгэгч, гэмт хэрэг, хээл хахуулийг илчлэгч" гэх зэргээр нэг талыг хэт барьж магтсан жишээ олон байна. Энэ мэт жишээг тоочоод байвал дуусашгүй. Сэтгүүлчид нь дэмжлэг намаа сайшаан өмөөрч, нөгөө өрсөлдөгч намыг шүүмжлэн өөнтөглөх маягаар “Үгүйсгэл” “Гүтгэлэг” нэвтрүүлэг явуулсан нь МАХН дангаараа суудал авах нөхцлийг бүрдүүлж сөрөг сурталчилгаа болсон ч байж болзошгүй.

“Өмнөх сонгуульд монголын сэтгүүлчид мөнгөний төлөө ажиллалаа. Энэ байдлыг давтахгүй гэх баталгаа байна уу?” гэсэн асуултад 2000 оны 4 дүгээр сард томоохон хэвлэл мэдээллийн удирдлагууд ийн ярьж байлаа. “Хурд” агентлагийн захирал “Сонгуулийн сурталчилгааны бизнес бол 4 жилд ганц удаа олддог боломж учраас сэтгүүлчид түүнийг алдаж болохгүй. Сонгогчид тэрхүү судалгаанд автах албагүй” гэж мэдэгдэж байсан бол “Өнөөдөр” сонины удирдлага “Сонгууль бол сонины ажил биш, ард олон, улс гүрний хэрэг” гэж үзэж байв. “Өдрийн сонин”-ы дарга нар “Уншигчид тэнэг хүмүүс биш. Тэд мөнгийг төлсөн мэдээлэл тавиад байна уу, шударгаар олсон шинэ мэдээлэл тавиад байна уу гэдгийг ялгана” гэж хэлж байсан бол “Зууны мэдээ” сониныхон “Өнөөдөр үнэгүй ажил үйлчилгээ гэж үгүй. Бүх юм өөртөө таарсан үнэ цэнэтэй. Мэдээлэл өөрөө маш өндөр өртгөөр бүтдэг эд дээ” гэж ярьж байлаа.

Сэтгүүлч аль нэг нам, эвсэл, улс төрийн хүчинд тал засаж, мэдээллийг гуйвуулж, уншигч, үзэгчдийг хуурч хэрхэвч таарахгүй билээ. Телевизүүдэд өрөөсгөл, нэг талыг барьсан нэвтрүүлэг зонхилж байсныг дээр өгүүлсэн. Ялангуяа МҮТВ-ийн нэвтрүүлэгт МҮАН-МШАН-ын “Ардчилсан холбоо” эвслийн сурталчилгаа зонхилж байсан бол “Ийгл” нэвтрүүлгийнхээ ерөнхий агуулгаар МСДН-ыг голлож, МҮАН-ыг дэмжиж, МАХН-ыг эсэргүүцэх хандлага олонтаа илэрч байлаа. “Улаанбаатар” телевиз намуудын захиалгат цагийн хувьд МАХН-д 30 хүртэл хувь өгч, мэдээ мэдээллээрээ МАХН-ын үйл явдлыг түлхүү тусгаж байлаа. Харин “25 дугаар суваг” телевиз голч байр суурьтай, энэ бүх өрөөсгөл хандлагаас ангид байсныг хэлэх хэрэгтэй.

Сонинууд бас л өрөөсгөл байдалтай хандаж байв. Тухайлбал, “Өдрийн сонин” нэр дэвшигчийн төлбөртэй сурталчилгаа 29 нийтэлсний 21 нь МҮАН-МШАН-ын “Ардчилсан холбоо” эвслийнх байлаа. Тав нь МСДН-аас нэр дэвшигчдийнх бусад гурав нь өөр өөр намынх байв. “Зууны мэдээ” сонин намуудын мөрийн хөтөлбөрийг нийтлээгүй атал ганцхан МАХН-ынх гарчээ. “Монголын мэдээ” МАШСН-ын мөрийн хөтөлбөрийг сурталчилсан материалыг нэгдүгээр нүүрэндээ хоёр удаа гаргасан бол бусад намуудыг шүүмжилсэн 10 материал нийтэлжээ.

Харин “Өнөөдөр” сонин нам эвсэл, нэр дэвшигчдийн талаар тэнцвэрт сурталчилгаа хийхийг зорьжээ. Бас нөгөө талаар бусад гурван сониноо бодвол сонсогчийн санаа бодол 17, тэдний боловсролд зориулсан материал 11, мэтгэлцээн 6-г нийтэлсэн нь сайшаалтай. Гэхдээ л дээрх сонинуудад нэр дэвшигчийн мөрийн хөтөлбөр, амлалтад шүүмжлэлтэй хандсан болон улс төрийн намуудын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг судалж, эрэн сурвалжилсан нийтлэл үгүйлэгдэж байв.

Эцэст нь хэлэхэд 2000 оны хаврын УИХ-ын гишүүдийг сонгох сонгуулиар сэтгүүлчид мэргэжлийн ёс зүйгээ умартаж “Муу” дүн авсан юм. “Цаг цагт нэг цаддаг, цагаан сараар нэг цаддаг” гэгчээр бидэнд олдох ганцхан боломжийг ашиглан “Мөнгөний төлөө урагшаа” хэмээн бүгдээрээ гүйлджээ. Ард нь ард түмэн, тэднийг зөв сонголт хийхэд тусалдаг сэтгүүлчийн үүрэг цөм мартагдан үлджээ.

- **2000 оны УИХ-ын сонгуулийн кампанийг мэдээлсэн хроник**

(Хэвлэл мэдээлэлтэй холбоотой зарим үйл явдлууд)

2000 оны 1-р сар

“Зууны шилдэг луйвар” улс төрийн нэвтрүүлгийг “Ийгл” телевиз ба Монголын үндэсний телевизээр цацсан байна.

2000 оны 3-р сар

Монголын үндэсний телевизээр “ММ” агентлагаас бэлтгэсэн “Энэ үнэн үү” цуврал нэвтрүүлгийг үзүүлсэнтэй холбогдуулсан МСоХ-ноос МРТХЭГ-ийн дарга Б.Билэгтэд хандан мэдэгдэл гаргаж “МҮТВ-ээр чөлөөт хэвлэлийг дахин дайрч доромжилсон нэвтрүүлэг явуулахгүй байхыг албан ёсоор мэдэгдэж байна” гэжээ.

2000.04.03

Төрийн мэдээллийг төвийн нээлтийн ёслол болов. Ерөнхийлөгч, УИХ-ын тамгын газар, ЗГ-ын хэрэг эрхлэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн хэвлэл мэдээллийн албадын төлөөлөгчдөөс бүрдсэн зөвлөл төвийн үйл ажиллагааг зохион байгуулна. Ингэхдээ 40 мянгаас доошгүй үзэг, сонсогчтой телевиз, радио, 5000-аас дээш уншигчтай сонин хэвлэлийн хүсэлтийг хүлээн авч сурвалжлага хийх эрх олгоно. Жилд 16 мянган төгрөгийн хураамжтай.

2000.04.10

МСХ ба МСоХ-ноос санаачлан зохион байгуулсан намуудын удирдлага, сэтгүүлчид, чөлөөт хэвлэлийнхний дугуй ширээний ярилцлага болжээ. Ярилцлагын зарим хэсгээс: МУНН-ын ерөнхий нарийн бичгийн дарга З.Нармандах

- “Монгол телевиз, “Монголын мэдээ” агентлагийн мэдээллийн түгжээ хэр удаан үргэлжлэх юм бэ?

Ү.Хүрэлбаатар (МУНН-ын дарга):

- Ер нь Монгол телевизэд парламентийн бус намуудын материалыг үл нэвтрүүлэх тухай ямар нэг нууц тогтоол байх шиг байна. Та нар ажилтнуудынх нь хувьд энэ талаар дуулж мэдсэн юм байна уу?

Х.Өлзийбаяр (“ММ” агентлагийн ахлах редактор):

- Би МСХ-ны тэргүүлэгчийн хувьд энэ ярилцлагад оролцож байна. МРТХЭГ маань Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг гэдэг утгаараа ажиллаж байгааг ойлгох биз. Бид энэ газраас цалин авч ажилладаг, Харин би өөрийн ажилладаг ММ агентлагийн тухайд арай аядуу байр суурь баримталдаг гэдгийг хэлмээр байна. Манайхаар намуудын мэдээлэл харьцангуй бага ч гэсэн ордог. Гэхдээ тодорхой хэмжээнд гэдгийг ч бас л ойлгох учиртай л даа.

Ү.Хүрэлбаатар: Радиогийн тухайд?

М.Цагаан (“Хурд” агентлагийн захирал):

- Та нар зөв ойлгоорой. Бид чинь 2-3 талаасаа дарамт хүлээж ажилладаг. Харин МСХ-нд хандаж хэлэхэд сэтгүүлч биднийгээ хамгаалаач ээ. Дарга нар биднийгээ ажлаас халчих гээд айлгаад байх юм. Сэтгүүлч нөхөд маань “Бидний юмыг нэвтрүүлсэнгүй” гэж гомдоллоод, сонгогч олон нэг талыг барьж байна гэж загнаад дунд нь сэтгүүлч бид л зовж байна.

Т.Төмөрмөнх (МЛАН-ын тэргүүн)

- Сэтгүүлчид ээ, та нар сурталчлахаа л бод. Бид мөнгө хаяна. Бидний өгч байгаа мөнгийг хэрхэн зөв зүйтэй зулгааж идэхээ л сайн бод.... Сонгууль гэдэг маань хэвлэлийн хүчирхийллийн үр дүн... Ерөнхий сайд маань халамжийн тусламжаар ирсэн машин бэлэглээд л зурагтаар гарч байна. Батхүү сайд байсхийгээд л төсөл мөсөл гээд гарчихдаг. Ийм замаар 3-4 жил өөрсдийгөө сурталчлаад бусад намд хоёрхон сар дуугарах эрх өгөх бодолтой байна. Ийм л сонгууль биднийг хүлээж байна.... Сурталчилганы энэ тэнцвэргүй байдлыг халаач гэмээр байна....

2000.04.18

“Ийгл” ТВ-ийн “Монгол мэдээ”

20 цагаас УИХ-ын гишүүн Э.Бат-Үүлийн эсрэг ба ба төлөө утгатай хоёр мэдэгдлийг уншив. Харин 23 цагаас “Монгол мэдээ”-г давтахдаа эхнийхийг хасч зөвхөн хоёрдахийг нэвтрүүлэв.

2000.04.30

МАХН-ын сонгуулийн сурталчилгаа МАХН-ын дарга Н.Энхбаярын оролцсон UBS телевизийн “Нүүр тулсан ярилцлага” нэвтрүүлгээр эхлэв.

2000 оны 4-р сар

МУ-ын Их хурлын сонгууль ойртох тусам МАХН-аас нэр дэвшигчд рүү чиглэсэн гүтгэлгийн чанартай цуврал нэвтрүүлгүүдийг “Монголын сонгогчдын эрх ашгийг хамгаалах хороо” хэмээх төрийн бус байгууллага МоАН-ын нэрийн өмнөөс Монголын үндэсний телевиз ба “Ийгл” телевизээр удаа дараа цацлаа” гэсэн мэдэгдлийг МАХН-ын сонгуулийн штабаас гаргажээ.

2000.05.01

“Сэтгүүлчийн ёс зүйн тулгамдсан асуудал” дугуй ширээний ярилцлага Төрийн ордонд болов. Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх мэдээллийн бодлогын салбар зөвлөлөөс, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр, Монголын хэвлэлийн хүрээлэнгийн оролцоотой зохион байгуулжээ. Энэ ярилцлага УИХ-ын сонгууль ойртож буйтай холбоогүй гэж зохион байгуулагчид нь тайлбарлав.

2000.05.03

Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрөөр Монголын сонины холбооноос Ялалтын талбайд “Хэвлэлийн эрх чөлөө-хүний эрх: ус агаар” уриан дор цуглаан зохион байгуулжээ.

2000.05.06

UBS телевизийн “Нүүр тулсан ярилцлага” нэвтрүүлэгт” УИХ-ын гишүүн Т.Ганди оролцож “Монголын Үндэсний телевизийг эвслийнхэн эзэмшиж байна” гэж шүүмжиллээ. Энэ удаагийн сонгуулийн сурталчилгааны үеэр UBS телевизээр зөвхөн МАХН-ын нэр дэвшигчид ярьж байлаа.

2000 оны 05-р сар

“Ардчилсан холбоо эвслийн алдаа оноо” цуврал нэвтрүүлэг Монголын үндэсний телевизээр гарч эхлэв.

2000.05.06

МҮТВ. “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр

- Ерөнхий сайд Р.Амаржаргал хүүхдийн чуулган дээр үг хэлсэн тухай сурвалжлага
- УИХ-ын дарга Р.Гончигдорж Сэлэнгэ аймагт математикийн олимпиадын ёслолд оролцсон. Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболд хамт явсан тухай.
- Мэндсайхан сайдын нэгэн арга хэмжээ.
- Эрүүл мэндийн сайд С.Сонин өрхийн эмч нартай уулзсан ба тэр үеэр хүмүүсийн хэлсэн үгийг оруулсан сурвалжлага
- УИХ-ын гишүүн Н.Алтанхуягийн нэрэмжит “Өнөр” хорооллын сагсан бөмбөгийн тэмцээний тухай сурвалжлага.

2000.05.06-07

Бүгд Найрамдахчуудын олон улсын хүрээлэнгээс “Хэвлэл мэдээлэл ба 2000 оны сонгууль” семинарыг зохион байгуулав.

2000 оны 5-р сар

УИХ-ын сонгуульд хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, эсвэл ажиллаж байсан, мөн сэтгүүлч мэргэжилтэй дараах хүмүүс нэр дэвшсэн байлаа.

С.Цогтсайхан - УИХ-ын хэвлэл мэдээллийн албаны зөвлөх, “ММ” агетглагийн захирлаар ажиллаж байсан. (“Хонх” хамтлагийн дуучин)

Д.Нинж – Улс төрч, МСХ-нд ажиллаж байсан

Х.Дашзэвэг – УИХ-ын гишүүн,

Б.Билэгт – МРТХЭГ-ийн дарга

Ч.Куланда- МРТХЭГ-ийн гадаад харилцааны хэлтсийн дарга

Ц.Мөнхтөр – МҮТВ-ийн “Монголын мэдээ” агентлагийн захирал

Г.Энхтайван – Монголын радиогийн ерөнхий захирал

С.Батмөнх – УИХ-ын хэвлэл мэдээллийн албаны дарга

Т.Ганди – УИХ-ын гишүүн

Ө.Энхтүвшин – МАХН-ын нарийн бичгийн дарга, “Ардын эрх” сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга байсан

Г.Төртогтох - “Үнэн” сонины ерөнхий эрхлэгч

Ч.Базар – Хэвлэлийн хүрээлэнгийн ажилтан

Д.Бадамханд - “Амьдралын тойрог” (тахир дутуу иргэдийн) сонины эрхлэгч

Ц.Ганболд - “Хөдөлмөр”, “Ил товчоо”, “Ардын эрх” сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга, “Монголын мэдээ” агентлагын захирал байсан

Ү.Хүрэлбаатар – МУНН-ын дарга, “Улаанбаатар” сонины эрхлэгч байсан.

2000 оны 5-р сар

Монголын сонины холбооноос Хэвлэлийн эрх чөлөөний төлөө УИХ дахь сэтгүүлчдийн лобби бүлэг байгуулах итгэлцлийн гэрээг байгуулах санаачлага гаргасан байна.

2000.05.11.

Монголын үндэсний телевизийн “Монголын мэдээ” агентлагийн захирлаар МҮАН-ын хэвлэл мэдээллийн албаны дарга У.Сарантуяаг томилсон тухай мэдээлэв. МСДН-аас УИХ-ын сонгуульд нэр дэвшсэн тул Ц.Мөнхтөрийн энэ албан тушаалаас чөлөөлжээ.

2000.05.18

УИХ-ын сонгуульд Завхан аймагт МАХН-аас нэр дэвшигч МҮОХ-ны дарга Ш.Отгонбилэг хэвлэл мэдээллийнхнийг хүлээн авч уулзжээ. Маргааш нь “Өдрийн сонин” Ш.Отгонбилэгийг дэмжихээ зарласан байна. Энэ тухай мэдээнд: “Өдрийн сонин”-ы ерөнхий эрхлэгч Ж.Мягмарсүрэн сэтгүүлчдийг төлөөлж хэлэхдээ, “манай сонин хэвлэл үйл явдлыг бүх талаас нь харж бичдэг. Бид УИХ-ын сонгуулийн үеэр нийтлэлдээ онцгой анхаарал тавьж байгаа. Учир нь нэр дэвшигчдийн талаар алдаатай мэдээлэл гарсан тохиолдолд залруулагдаж амжилгүй санал хураалт болж болох юм. “Өдрийн сонин” Ш.Отгонбилэгийг “Эрдэнэт” үйлдвэртэй холбогдуулж нэлээд бичсэн. Ер нь шүүмжлэлсэн талдаа байх. Харин сонгуулийн үеэр түүнийг дэмжиж ажиллана” гэжээ.

2000.05.19

Монголын үндэсний радио, телевизээр сонгуулийн сурталчилгааг үнэ төлбөргүй явуулах хугацаа, боломж нэр дэвшигч бүрт адил байна гэж хуульчилсны дагуу СЕХ-ноос тогтоол гаргажээ. Монголын үндэсний телевизээр нам, эсвэл бүрт нэг удаа 20 минут, бие даасан нэр дэвшигч тус бүрт нэг удаа хоёр минут, Монголын радиогоор нам, эсвэл бүрт долоо хоног тутам нэг удаа 20 минутийн үнэ төлбөргүй сурталчилгаа явуулахаар тогтжээ. Ингэхдээ МРТХЭГ-ийн саналыг үндэслэсэн байна. Дээрх тогтоолын дагуу МҮТВ, радиогоос үнэ төлбөргүй сурталчилгааны хуваарыг гаргажээ. Харин төлбөртэй сурталчилгаагааны талаар намууд Монголын үндэсний телевиз, радиотой шууд цагаа тохирч гэрээ байгуулж байв.

2000.05.24

”Нэр дэвшигчдийн халз мэтгэлцээн”

“Ийгл” телевиз шинэ мянганы анхны төрийн эрх барих дээд байгууллага – УИХ-ын сонгуульд хотын 20 тойрогт өрсөлдөж буй нэр дэвшигчдийн дунд халз мэтгэлцээнийг цувралаар анх удаа зохион явуулах гэж байна.... Нэвтрүүлэг 2000 оны тавдугаар сарын 27-ноос эхлэн 7 хоногт 4 удаа, нийт 20 удаа явагдана. Нэвтрүүлгийг “Ийгл” телевизийн төв байрны их танхимаас орой 21 цаг 30 минутаас 23 цаг хүртэл 1 цаг 30 минутийн хугацаатайгаар шууд явуулна. Тойргийн дарааллыг намуудын төлөөлөл, хөндлөнгийн ажиглагчдын дунд сугалаагаар гаргасан бөгөөд энэ дарааллаар нэр дэвшигчид халз мэтгэлцээнд оролцонон Нэг нэгтгүүлэгт тухайн тойрогто өрсөлдөж буй бүх нэр дэвшигчид оролцох боломцоог бид олгож байна” хэмээн зарлав.

5-р сарын 27-нд 69 дүгээр тойргоор эхэлж 6-р сарын 30-нд 70 тойргоор дуусгах хуваарь гаргажээ.

2000.05.26

“Ийгл” телевиз. “Монгол мэдээ” хөтөлбөр:

Манай ТВ-ээс зохион байгуулах гэж байгаа Дебют буюу Халз мэтгэлцээн нэвтрүүлгийн эрхийг UBS телевиз булааж авах оролдлого хийж эхэллээ. Тус ТВ-ын өчигдрийн мэдээллийн хөтөлбөртөө энэ тухай зарлаж, нэг нэвтрүүлэгтээ 2 нэр дэвшигчийн оролцуулна гэжээ... Улаанбаатарт сонгуульд өрсөлдөх 203 хүний талынх нь ч байр суурийг багтааж чадахгүй... UBS бол хотын төсвөөс санхүүждэг. Энэ санхүүжилтыг удирддаг хүн нь хотын засаг дарга МАХН-ын гишүүн бөгөөд тус телевизийнхний учирласнаар дээрээс буюу МАХН-ын эрх бүхий тушаалтнуудын үүрэг даалгавраар хийх болсон. Оролцох хүмүүс нь тодорхой болж байна.. Маргааш манай дебат эхлэнэ. МАХН-ын Болормаа “манай намынхан оролцохгүй” гэж ярьж явсан. Тэр өөрөө UBS-ээр мөнгө төлөхгүй өөрийгөө сурталчлуулна гэж найдаж байна.... Манайх ардчилалынхны талд үйлчилж байсан бол ингэж маргаан зохион байгуулахгүй байсан”

2000.05.27

“Ийгл” телевизийн “Дебат” буюу шууд мэтгэлцээний анхны нэвтрүүлэг.

Улс төрийн гол хүчнүүдийг төлөөлсөн нэр дэвшигчид оролцоогүй. Жижиг намуудын болон бие даасан 4 нэр дэвшигч иржээ.

2000.05.27

UBS телевиз.

МАХН-аас нэр дэвшигч Болормаа: UBS телевизээр зарласан “Нүүр тулсан ярилцлага” нэвтрүүлэгт баяртай оролцоно... “Ийгл” телевизийн хувьд 250000 төгрөг нэхсэн. Энэ мөнгөөр 5000 сонин хүргэж болно... Бодит мэдээллийг эрхэмлэхийг МАХН-ын дарга Н.Энхбаяр сануулж байсан.

2000.05.31

UBS: “Нүүр тулсан ярилцлага” шууд нэвтрүүлэг маргааш эхлэнэ.. Тухайн тойрогт нэр дэвшигч бүгд нэг ширээний ард сууж маргалдана.... Даваа, Пүрэв, Баасан, Бямба гаригт 22-23 цаг явагдана. Уг ярилцлагад оролцоход үнэ төлбөргүй...

2000.06.01

UBS: “Тухайн тойргоос нэр дэвшигчид бүгд оролцохгүй нь тодорхой боллоо” гэж зарлав.

Удалгүй “Ийгл” телевизийн халз мэтгэлцээний “Дебат” нэвтрүүлэгт улс төрийн гол намуудын нэр дэвшигчид оролцохгүй байсан шалтгаанаар зогссон байна.

Нэр дэвшигч Д.Чулуунжав үүнийг ингэж тайлбарлажээ:

- Тэдний гарт үндэсний телевиз радио байна. Тэд үндэсний хэмжээнд нэвтрүүлгээ явуулдаг учраас зөвхөн Улаанбаатарт нэвтрүүлэг явуулдаг жижиг телевизүүдийг

тоохгүй байна. Тэдэнд шаардлага алга... Тэд бидэнтэй илэн далангуй маргахаас айж байна... Би танай ярилцлаганд оролцохын тулд 150 мянган төгрөг төлсөн...”

2000.06.07

“Чөлөөт хэвлэл” төслийн хүрээнд бий болсон “Чөлөөт хэвлэл” сан ба Хэвлэлийн хүрээлэн ТББ-уудын эзэмшдэг байрыг өмчлөх эрхийн гэрчилгээг гардуулах ёслол болжээ. (Засгийн газрын өмч байсан энэ байрыг үнэ төлбөргүй олгох шийдвэрийг бүр 1999 онд гаргасан юм). Ингэж УИХ-ын сонгуулийн сурталчилгааны өдрүүдэд Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболд, өмч хувчлалын газрын дарга Л.Энхтөр нар Төрийн өмчийн хорооноос энэ талаар зохих шийдвэр гаргасныг албан ёсоор мэдэгдэх, бас тэр шийдвэрийг гардуулах ёслолыг хэд хэдэн удаа зохион байгуулав. Тэд хоёулаа УИХ-ын сонгуульд нэр дэвшигчид юм.

2000.06.12

Төрийн хянан шалгах хорооны дарга Л.Жавзмаа Төрийн ордонд байсан нэгэн семинар дээр мэдэгдэхдээ “...тус хорооноос Засгийн газрын харьяа сангуудад хийсэн шалгалтын тухай Монгол телевиз гурван цуврал нэвтрүүлэг явуулах ёстой байсан. Гэтэл эхнийх нь яваад нэвтрүүлэг сураг тасарсан. Би Засгийн газраас үүнийг гаргахыг хориглосон тухай дуулсан” гэжээ.

2000.06.14

Данийн Засгийн газрын “Данида”-гийн тусламжаар байгуулагдсан “Чөлөөт хэвлэл” төслийг амжилттай хэрэгжүүлэх, хараат бус хэвлэл мэдээллийг хөгжүүлэхэд Монгол Улсын Засгийн газрын зүгээс болон хувиасаа хувь нэмэр оруулсан Ерөнхий сайд Р.Амаржаргал, УИХ-ын гишүүн Н.Энхбаяр нарыг Монголын хэвлэлийн хүрээлэнгийн удирдах зөвлөлөөс тус хүрээлэнгийн “Хүндэт диплом”-оор шагнасныг гардуулах ёслолын ажиллагаа болов.

2000.06.26

Монголын радио. 14.30 цаг.

Хэнтий аймгийн Засаг дарга, нэр дэвшигч Ч.Энхээгийн тухай радио найрууллын хэсгээс: “... төрдөө хэрэгтэй хүн болох гэж ээж нь энхрийлэнхэн өсгөж бойжуулжээ”

2000.06.29

МҮТВ. “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөр

- Монгол Улсын Ерөнхий сайд Р.Амаржаргал Дархан, Сэлэнгийн замын нээлтэнд оролцсон тухай сурвалжлага. Түүнийг хэлсэн үгнээс: “... Би энд Энхболдыгоо онцолж хэлмээр байна. Түүний хувьчилсан 40 тэрбумын 6 тэрбумаар энэ замыг барьсан...”
- “МҮАН-МШАН-ын “Ардчилсан холбоо” эвслээс гаргасан мэдэгдлийг бүрэн эхээр уншив. МАХН-тай холбоотой янз бүрийн баримтууд, тухайлбал, “... биднийг гүтгэж байна, бид Жасрай хүүдээ 220 мянган долларын зээл авсныг бид сөхөөгүй” гэх мэт баримтыг цухуйлгажээ. Бас “... Зоригийн аллагын бурууг МҮАН-ын удирдлагад тохож байна” гэсэн
- Сангийн сайд Очирсүх сайдынхаа эрх мэдлийн хүрээнд үерийн далан барив гэсэн сурвалжлага
- МҮАН—ын “Ардчилсан холбоо” эвслээс нэр дэвшигч Ц.Цолмон хэвлэлийн бага хурал хийв
- Нэр дэвшигч Ц.Энхтүвшин нэрээ татав.
- Нэр дэвшигч Сосорбарам нэрээ татаж мэдэгдэл гаргаж Б.Билэгтийг дэмжихыг сонгогчиддоо уриалан, энэ талаараа “Монголын мэдээ” агентлагт хандсаныг үзүүлэв.
- Улс төрийн хэлмэгдүүлэлт, нөхөн олговрын тухай клип.
- Нэр дэвшигч До.Ганболд
- Бид 10 жилийн өмнө ямар ч эрхгүй байлаа гэсэн утгатай сурталчилгааны клип

Цагийн хүрд”

Энэ өдрүүдэд МРТХЭГ-ын дарга Билэгтийн сонгуулийн кампанийг “Цагийн хүрд”-ээр байнга сурвалжилж (заримдаа тэр тэгэж асуухад тэгэж хариулав) байв. “Ард түмнийхээ төлөө ажиллахыг Билэгтэд хүсэн ерөөв... Ихэнх сонгогчид Билэгтийг дэмжиж буйгаа илэрхийлэв” гэх мэт. Мөн Билэгтийн сурталчилгааны клипийг “Цагийн хүрд” ба “Долоо хоног” хөтөлбөр болгоны дараа нэвтрүүлж байлаа.

2000.06.30

Сонгуулийн сурталчилгааны сүүлчийн өдрийн өдөр.

Монголын үндэсний телевиз энэ оройжин “Ардчилсан холбоо” эвсэл ба тус эвслээс нэр дэвшигчдийн сурталчилгаа бүхий ярилцлага, сурталчилгааны клипүүдийг үзүүлээ. Сүүлчийн цагуудыг жишээ болгон авч үзье.

20.30. “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрт сонгуультай холбоотой дараах сэдвүүд багтлаа.

- Ерөнхий сайд Р.Амаржаргалын хэлсэн үг
- МРТХЭГ-ийн дарга Билэгтийн яриа. Сонгуулийн сурталчилгаа тэгш явагдаж байгаа, МАХН-ынхны гомдол үндэслэлгүй гэсэн утгатай.
- МҮАН ба МСДН-ын сурталчилгааны клипүүд, Үүний дотор ММ агентлагийн захирал Ц.Мөнхтөрийн тухай.
- УИХ-ын сонгуульд МАХН-аас нэр дэвшсэн Ц.Баасанжав “Нарантуул” захыг хууль бусаар хувьчлахад оролцсон гэсэн утгатай тайлбар. Нэр хаяггүй.
- CNN: Сонгуулийн тухай, “Монголын коммунистууд” гэхчлэн нэрлэсэн, С.Зоригийн аллагын тухай, мөн Р.Амаржаргал, Э.Бат-Үүл нарын яриаг оруулсан сурвалжлага. Харин дүрсэнд гарсан МҮАН-ын байрны гаднах самбарт сурталчилгаа тавигдаагүй, “Улаанбаатарын үдэш намуухан” гэж байсан нь нэлээд эрт бэлтгэсэн сурвалжлага бололтой. (Энэ сурвалжлагыг “Ийгл” телевизээр бас нэвтрүүлэв)

21.40. “Эвлүүлэггүй яриа”. Сэтгүүлч Сарантуяа (МҮАН-ын хэвлэл мэдээллийн албаны дарга) Ерөнхий сайд Амаржаргалтай ярилцав

22.10. Сэтгүүлч Оюунчимэг (МҮАН)-ийн УИХ-ын гишүүн Э.Бат-Үүлтэй хийсэн ярилцлага.

22.30. А.Ганбаатар, Б.Батбаяр нарын сурталчилгаа

22.40. Төрийн өмчийн хорооны дарга З.Энхболдын яриа.

22.45. Батж.Батжаргал, Н.Алтанхуяг, Ц.Төмөртоогоо, Р.Гончигдорж нарын яриа, сурталчилгаа. Завсраар нь МСДН-ын клипүүд.

22.55. МСДН-аас нэр дэвшигч Г.Энхтайваны сурталчилгааны клип

22.55. Ш.Түвдэндоржийн сурталчилгаа. (Р.Амаржаргал, Чойжамц хамба, сэтгүүлч Л.Пүрэвдорж (Түвдэндоржийн өрсөлдөгч Р.Гавааг шүүмжлэв) нар оролцсон. Мөн хэд хэдэн иргэн Түвдэндоржийг дэмжиж буйгаа илэрхийлэв.

23.05. Ш.Амаржаргалын сурталчилгааны клип.

23.08. “Ардчилал шинэчлэлийн 10 жил” баримтат кино. “Ардчилсан холбоо” эвслийн үйл ажиллагаа магтсан агуулгатай

23.52. Ерөнхий сайд Ш.Амаржаргал ард түмэндээ хандаж үг хэлэв.

Төгсгөлд нь “Ардчилсан хүчинд төрийн алтан жолоог атгуулах”-ыг уриаллаа.

00.03. “Үдшийн мэдээ”. УИХ-ын дарга Р.Гончигдорж ард түмэндээ хандаж үг хэлэв. s

2000.07.01 Сонгуулийн сурталчилгаа дууссан, ийм сурталчилгаа явуулахыг хориглосон өдөр.

Монголын үндэсний телевизээр 1980-аад оны нэгэн уран сайхны киног үзүүлэв. Түүнд МРТХЭГ-ын дарга Б.Билэгт тоглосон ажээ.

- 2001 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн компанийг мэдээлсэн хроник

(Хэвлэл мэдээлэлтэй холбоотой зарим үйл явдлууд)

2001.01.25

“Өдрийн сонин”-ы дугаарт “Н.Багабанди хар мөртэй ерөнхийлөгч” гарчигтай өгүүлэл нийтлэгдэв.

2001.04.06

Ховд аймагт Н.Багабанди сонгогчидтой хийсэн уулзалт дээр “Дээдсийн хүрээлэн” сонины сурвалжлагчийн дүрс бичлэгийн камерийг хамгаалалалтын ажилтнууд хураан авч бичлэгийг тасалсан гээд “Дээдсийн хүрээлэн” сонины эрхлэгч Н.Билгүүн хэвлэл мэдээллийн байгууллагуудад хандаж угаасаа чөлөөт хэвлэлд халтай Н.Багабандийг Ерөнхийлөгчийн сонгуульд дэмжихгүй байхыг уриалах бодолтой байгаагаа мэдэгдсэн тухай “Өдрийн сонин” мэдээлэв.

2001.04.10

“Хөх толбо” сонины эрхлэгч Б.Эрдэнэбаатар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд Н.Багабандийг дэмжих болсноо илэрхийлж өөрийн сониндоо ярилцлага нийтлүүлсэн байна.

2001.04.20

“Ийгл” телевизээр “Зоригоос хойш” нэвтрүүлэг эхэлж бүтэн сарын турш долоо хоногийн Даваа, Мягмар, Лхагва, Баасан, гаригт нэвтрүүлж Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгууль хүртэл 20 шахам дугаарыг бэлтгэн үзүүлсэн байна.

2003 оны 4-р сар

“Өдрийн сонины” ерөнхий эрхлэгч Ж.Мягмарсүрэнд МИАТ компанийн хэлстийн дарга Ц.Бат мэдэгдэл ирүүлжээ. Үүнд:

“Танай сонины 2001 оны 4-р сарын 26-ны өдрийн пүрэв гаригийн дугаарын хоёрдугаар нүүрэнд хэвлэгдсэн “Ерөнхийлөгчид МИАТ ая тал засжээ дээ, янз нь...” нийтлэлдээ Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас нэр дэвшигч Н.Багабандийн сурталчилгааны материалыг ая тал засч, хямд үнээр орон нутагт тээвэрлэсэн хэмээн нийтэлж манай компанийн бизнесийн нэр хүндэд хохирол учруулсан байна.... МИАТ компани танай сонины газартай 2001 онд хэвлэн нийтлэх тухай гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд энэхүү гэрээний хоёрдугаар зүйлийн 1-д заасныг зөрчиж, манай компанийн талаар худал ташаа мэдээлэл нийтэлсэн байгаа тул 2001 оны дөрөвдүгээр сарын 27-ны баасан гаригийн дугаарын нэгдүгээр нүүрэнд залруулга хийж, МИАТ компанийн зорчигчид “Өдрийн сонин”-ыг цаашид уншиж байх боломжийг хангана уу?” гэжээ. Энэ албан бичгийг “Өдрийн сонин” 2001.05.01-нд нийтэлсэн байна.

2001.05.03

Дэлхийн чөлөөт хэвлэлийн өдрийг тэмдэглэх ёслолын ажиллагаа “Улаанбаатар” зочид буудалд болов. “Чөлөөт хэвлэлийг дэмжих сан”-гаас Ц.Дашдондов, Ц.Бат-Орших, Р.Хадбаатар нарыг тус бүр 500.000 төгрөгөөр шагнажээ. Бусад хэд хэдэн сэтгүүлчийг 100.000-300.000 төгрөгөөр шагнасан байна.

2001 оны 5-р сарын эхний өдрүүд

“Ноцтой мэдээ” сонины 15-16-д “Ерөнхийлөгчийн сонгуулийн хамгийн том дуулиан”. “Н.Багабанди хятадуудаас нэг сая ам.доллар авсан гэх ноцтой баримт дэлгэгдлээ” том өгүүлэл нийтлэгдэж энэ сонгуулийн хамгийн том дуулиан, шүүхийн нэхэмжлэл, маргааны эхийг тавилаа. Маргаашнаас “Хүмүүс”, “Өдрийн сонин”, “Шар сонин” зэрэг хэвлэлүүд энэ мэдээллийг “Ноцтой мэдээ” сониныг ишлэн нийтэлсэн байлаа.

2001.05.08

МАХН-ын сонгуулийн комиссоос хэвлэлийн бага хурал хийлгэж Н.Багабандитай холбоотой факсыг анх хүлээж авсан гэх Д.Готов дээрх нийтлэлийг няцаав.

2001.05.09

АН-ын дарга Д.Дорлигжав, Ерөнхий нарийн бичгийн дарга З.Энхболд нар хэвлэлийн бага хурал хийлгэж "... манайд гэрээгээр ажилладаг нэг сэтгүүлч танилаасаа ийм материал олоод сонинихонд өгсөн байсан" гэж мэдэгдлээ.

2001 оны 5-р сар

"Хүмүүс" сонин. 115-д 2001 оны "Чөлөөт хэвлэлийн дайснууд" өгүүлэл нийтлэгдэв. Онтариа дахь Ардчилал, чөлөөт хэвлэлийг дэмжих "Democracy and Freedom Forever" сангаас гаргасан жагсаалтаас гээд Ардчилсан Солонгосын ерөнхийлөгч Ким Ир Сен, Казахстаны ерөнхийлөгч Н.Назарбаев, Кубын Ерөнхийлөгч Ф.Кастро, Хятадын Ерөнхийлөгч Зэнь Зэн Минь, Монголын Ерөнхийлөгч Н. Багабанди нарыг оруулжээ. Зохиогчийн нэргүй өгүүлэл.

2001 оны 5-р сар

МАХН-ын сонгуулийн төв комисс "Н.Багабандийг чөлөөт хэвлэлийн дайсан хэмээн гүжирдэв" гэсэн мэдэгдэл гаргаж няцаалт хийв.

2001.05.06

"168 цаг" хөтөлбөр.

"25-р суваг" телевизийн захирал З.Алтайн хийсэн тайлбараас:

"Үг" компанийн захирал А.Ганбаатар "25-р суваг" телевизийг тэгш биш сурталчилгаа явуулж байна гэж шүүмжилсэн. Ардчилсан Холбоо эвсэл өнгөрсөн орон нутгийн сонгуулийн үеэр "25-р суваг" телевизээр явуулсан сурталчилгааныхаа үнийг одоо хүртэл төлөөгүй луу унжиж байна. Хэрвээ МАХН энэ байдлыг мэдвэл харин биднийг Ардчилсан намын талд орж сурталчилгааг нь үнэгүй хийсэн гэдэг хардлага сэрдлэгийн үймээн дуулианыг сонин хэвлэлээр тавих байсан юм биш биз. .. телевиз дээрээ авчраад яг адил тэгш боломжийг намуудад олгосон. Гэтэл хэдхэн хоногийн дараа АН-ын сонгуулийн сурталчилгаа хариуцсан дарга Н.Алтанхуяг ирээд сурталчилгаагаа бага хэмжээгээр хийнэ гэсэн. Тэр хэмжээгээр сурталчилгаа явагдаж байгаа. Тэгэхлээр Гончигдоржийн сурталчилгааг бага явуулж Гончигдоржийг унагах гээд байгаа хүн чинь таны хамтран зүтгэгч, таны найз Алтанхуяг гэдэг хүнтэйгээ тооцоогоо хийж учраа ололцоно уу?

2001.05.19

Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн халз мэтгэлцээнийг зохион байгуулав. Ингэхдээ гурван нэр дэвшигч зэрэгцэж зогсоод сугалж гаргасан тохиолдлын асуултанд ээлжлэн хариулах хэлбэрээр явагдав.

2001.05.19. Бямба

Сонгуулийн сурталчилгааны зөвшөөрөгдсөн хугацаа дууссан өдөр "Ийгл" телевиз "Зоригоос хойш" нэвтрүүлгийг үргэлжлүүлэн үзүүлэв.

2001 оны 5-р сарын 20. Ням**Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн өдөр**

"Ийгл" телевиз "Зоригоос хойш" нэвтрүүлгийг үргэлжлүүлэн үзүүлэв.

2001.06.08

Ардчилсан намын олон нийттэй харилцах хэлтсийн ажилтан Д.Болдхуяг эрүүгийн хэрэгт сэжигтнээр татагдах болсон талаараа мэдэгдэл гаргажээ.

2001.06.10

Ерөнхийлөгч Н.Багабанди Хятадуудаас нэг сая доллар авсан гэсэн мэдээллийг анх нийтэлсэн “Ноцтой мэдээ” сонины эрхлэгч Б. Галсансүх, уг материалыг тус сонинд өгсөн Ардчилсан Намын олон нийттэй харилцах хэлтсийн ажилтан Д.Болдхуяг нарт цагдаагийнхан эрүүгийн хэрэгт сэжигтнээр татаад шалгаж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан Д.Болдхуяг хэвлэлийн бага хурал хийлгэв. Тэрбээр АН-ын нэр дэвшигчийн сонгуулийн штабт ажилллаж байх үеэр хэн нэгэн хүн түүнд шуугиан дэгдээсэн ноцтой баримт бүхий дээрх материалыг өгснийг “Ноцтой мэдээ” сонинд (хамгийн ойр хугацаанд хэвлэгдэж гарах байсан учраас) өгсөн ба ямар ч засвар хийлгүйгээр М.Жамух гэсэн зохиогчийн нэрээр хэвлэгдсэн гэжээ.

• “Монгол Төрх” сонин 2000 ба 2004 оны сонгуульд

Сүүлийн саруудад энэхүү сониныг тойрсон маргаан үргэлжилж байгаа бөгөөд шалтгаан нь 2000 оны УИХ-ын сонгуулийн сурталчилгааны кампанийн тэр үеэс үүдэлтэй.

1999 онд одоогийн УИХ-ын гишүүн У.Хүрэлсүх “Улаанбаатар таймс” сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга Ш.Амаржаргалд хамтран ажиллах санал тавьжээ. У.Хүрэлсүх тэр үед МАХН-ын дэргэдэх МАСЗХ ба “ImageMaker” төвийн удирдлагад багтаж 2000 оны УИХ-ын сонгуульд нэрээ дэвшүүлэхээр бэлтгэж байлаа. Сонгуулийн сурталчилгааг явуулахаар төлөвлөж 1999 оны 12-р сарын 1-нд Ш.Амаржаргал өөрийн нэр дээр “Монгол төрх” нэртэй сониныг Хууль зүйн яаманд бүртгүүлжээ. Гэхдээ энэ сониныг “ImageMaker” төвөөс эрхэлж, сонины редакци МАХН-ын төв байранд байрлаж 1999 оны эцэс, 2000 оны эхний саруудад нийт 4 дугаар гаргасан ба У.Хүрэлсүх УИХ-ын гишүүнээр сонгогджээ. Сонгуулийн дараа сонины үйл ажиллагаа зогссон байна.

2001 оны 8-р сард У.Хүрэлсүх “Монгол төрх” сониныг сэргээн гаргасан Ш.Амаржаргалыг эрхлэгчээр ажиллуулахгүйгээ мэдэгдэж, оронд нь Д.Бадамгарав гэдэг сэтгүүлчийг (“Хүмүүс” сонины эрхлэгч байсан) томилжээ.

Энэ хооронд Ш.Амаржаргал сонин хэвлэлийн ажлаас завсарлаж, харин “Монгол төрх” сонин үргэлжлэн гарч УИХ-ын гишүүн У.Хүрэлсүхийн тойрогтоо хийсэн ажлыг сурталчилж байлаа. Улирал дараалан жип машин амалсан захиалга явуулж 2002 онд захиалгын тоо 10 мянгаас давсан (нийт хувь ширхэг 20 мянгаас давсан гэж мэдээлж байлаа) удаатай. Эндээс үзэхэд “Монгол төрх” сониныг У.Хүрэлсүх удирдаж, бас хөрөнгө оруулж санхүүжүүлж ирсэн, хөл дээр нь босгосон гэж ойлгогдож байлаа.

Сониныг тойрсон зөрчил маргаан 2003 оны эхээр дэгдсэн юм. Чухам энд үед сонины гэрчилгээний асуудал сөхөгджээ. Дараачийн саруудад Д.Бадамгарав “Монгол төрх” сонин нэрээ “Өнөөгийн төрх” болгож өөрчлөнө хэмээн зарлаж, Ш.Амаржаргал дахин “Монгол төрх”-ийн эрхлэгч болж улмаар “манайх нэрээ солиогүй” хэмээн мэдэгдэж, мөн “У.Хүрэлсүх Д.Бадамгаравыг ажлаас халлаа” хэмээн сэтгүүлчдийн чуулган дээр яригдсан. Ямар ч байсан 2003 оны 3-р улиралд “Монгол төрх” (эрхлэгч Ш.Амаржаргал) ба “Өнөөгийн төрх” (эрхлэгч Д.Бадамгарав) нар сонинууд зэрэгцэн гарч асуудал шийдэгдсэн мэт харагдаж байлаа. Гэтэл 2003 оны 9- сард “Монгол төрх” сонины редакци руу Хүрэлсүх гишүүний явуулсан гэх 5 залуу халдаж цагдаад баригдсан” тухай дараачийн шуугиан дэгдлээ. Дараа нь “Монгол шуудан” компанид байсан “Монгол төрх” сонины 8,9 сая төгрөгийг “Өнөөгийн төрх” сонины данс руу шилжүүлжээ. Тэр ч бүү хэл “Монгол төрх” сонины гэрчилгээг “ImageMaker” төвийн тэргүүн, “Үнэн” сонины ерөнхий эрхлэгч Ц.Ганбатын нэр дээр шилжүүлэх үйл ажиллагаа явагджээ. Улмаар Ш.Амаржаргалын “Монгол төрх” сониныг “Чөлөт хэвлэл” сангийн хэвлэх үйлдвэр хэвлэхгүй болж, үүний оронд Ц.Ганбатын “Монгол төрх” сонин гарч байгаа юм. Одоо хоёр тал “Монгол төрх” сонины өмч хөрөнгө, гэрчилгээ гэх мэт янз бүрийн асуудлаар бие биенээр харилцан шүүхэнд өгөөд байна.

Ийнхүү “Монгол төрх” сониныг У.Хүрэлсүх санхүүжүүлж, удирдаж ирсэн нь үнэн боловч сонины гэрчилгээ яах аргагүй Ш.Амаржаргалын нэр дээр учраас түүний эзэн байжээ. Тус сонин өмнөх сонгуулийн өмнөхөн байгуулагдаж, энэхүү зөрчил маргаан дараачийн сонгуулийн өмнө дэгдэж байгаа нь тохиолдлын хэрэг биш. Монголд улс төрчид ба сонин хэвлэлийн хоорондын харилцаа ихэнхдээ далд байдаг, үүүнийгээ аль аль тал зарладаггүй, энэ бол ил болсон бараг анхны тохиолдол юм. Сэтгүүлч хүн сонгуулийн сурталчилгааны үеэр улс төрчидтэй ингэж хамтран ажиллаж болох уу, сэтгүүл зүйн зарчимд нийцэж байна уу гэдгээс эхлээд маш олон асуудал эндээс урган гарч байна.

- **1993 оны Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн мэтгэлцээн болоогүй**

Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдын халз маргаан буюу мэтгэлцээнийг зохион байгуулах анхны оролдлогыг 1993 оны 5-р сард хийсэн юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийг бүх нийтээр сонгосон анхны сонгууль байлаа. Өмнөхөн Монголын үндэсний телевизээр П.Очирбат, Л.Түдэв нарын оролцсон нэвтрүүлгээр тэд танхимд цугларсан сэтгүүлчдийн асуултанд ээлж дараалан хариулсан бөгөөд мэтгэлцээн биш байжээ.

Жинхэнэ халз маргааныг зохион байгуулах санаачлагыг “Өнөөдөр” сонин (улс төрч Б.Баабарын эрхэлсэн) гаргаж нэр дэвшигчдийн сонгуулийн штабт хандав. Нэр дэвшигчид өөрсдөө хариулаагүй ч, тэдний сонгуулийн кампанийг удирдаж байсан хүмүүс зөвшөөрсөн хариу өгсөн. Монголын Үндэсний телевиз хамтран ажиллахыг зөвшөөрөөгүй.

Ингээд Энх тайван, найрамдлын ордонд бяцхан студи засчээ. Халз маргааныг сэтгүүлч Ч.Эрдэнэ хөтөлж Телевиз, радиогийн “Тэнхлэг” компани (1992-93 онуудад МҮТВ-ийн сувгаар Баасан гаригт нэвтрүүлэг явуулж байсан: Захирал Д.Гарам-Очир) бичлэг хийж үзэгчдэд хүргэх байв.

Товлосон өдөр цагт нэр дэвшигч П.Очирбат хүрэлцэн ирсэн. Харин Л.Түдэв ирээгүй. Сонгуулийн штаб руу утасдахад тодорхой хариу өгөхгүй, сураглахад сонгогчидтойгоо уулзалт хийхээр Яармаг руу явсан мэдээтэй байв. Ийнхүү халз маргаан болоогүй өнгөрчээ. Л.Түдэвийн сонгуулийн штаб өөртэй нь ярьж тохирохгүйгээр зөвшөөрсөн хариулт өгснөөс ийм байдалд хүрсэн гэж үздэг.

- **Сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэлд тавигддаг зарим шаардлага**

ОХУ-ын Сонгуулийн Төв Комисс бүрэн нээлттэй

“Манай сонгуулийн төв комиссийн бүх хуралдаанд, түүний дотор ажил хэргийн шинжтэй зөвлөгөөнд хэвлэл мэдээллийн төлөөлөгчид суудаг. Манай ажилд нууц байхгүй, хэвлэл мэдээллээр нийтэлж болохгүй нэг баримт бичиг манайд байхгүй”

Вишняков А.А (ОХУ-ын Сонгуулийн төв комиссын дарга)

Хэрвээ сэтгүүлч өөрөө нэр дэвшвэл ...

Сэтгүүлчид ба хэвлэл мэдээллийн байгууллагын удирдах ажилтнууд ОХУ-ын Төрийн думын сонгуульд нэр дэвшсэн, эсвэл тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ажилладаг бол телевиз радиогоор мэдээллийн болон бусад нэвтрүүлэг хөтлөх, мөн сонгуулийн явцыг сурвалжилж тайлбарлахад оролцохыг хуулиар хоригложээ.

Гурав хоногийн дотор

Хэвлэл мэдээллийн байгууллагын удирдах ажилтнууд нэр дэвшигчдийн сурталчилгааг нийтэлж нэвтрүүлсэн зардлын тухай мэдээллийг сонгуулийн комиссын хүсэлтээр гурав хоногийн дотор гаргаж өгөх үүрэгтэй. ОХУ-д улс төрийн намууд ба нэр дэвшигчид сурталчилгааны зардлыг зөвхөн тусгайлан байгуулж бүрдүүлсэн сонгуулийн сангаас гаргах ёстой учраас үүнийг ингэж шалгаж баталгаажуулдаг.

Хэн ч түрүүлээгүй ...

Анх 1993 онд Орос дахь Соросын сангаас ОХУ-ын Төрийн думын сонгуулийн кампанийг хамгийн сайн мэдээлж таниулсан (“улс төрийн нам буюу нэр дэвшигчдийг сурталчилсан” биш болохыг анзаарна уу) хэвлэл мэдээллийн хэрэгслийг шалгаруулсан уралдаан зарлаж нэр хүндтэй комисс байгуулан дүгнүүлжээ. Нэгдүгээр байранд хэнийг ч оруулах боломжгүй гэж үзсэн байна. “Бусад шагналыг олгоход ч маш хэцүү байсан” ажээ.

Анхаар ! Сонгууль !

(ОХУ-ын НТВ-гийн сэтгүүлчид зориулсан санамжаас)

Сонгуулийн сурталчилгааны кампанийн үеэр сэтгүүлч хүн зөвхөн юу хийх ёстой бодох биш, юу хийж болохгүй тухайгаа санах хэрэгтэй.

АНУ. Сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэлд тавигддаг зарим шаардлага:

- АНУ-д сонгуулийн явц, үйл явлын талаархи сэтгүүлчийн материал ба төлбөртэй сурталчилгаа хоёрыг зааглаж ялгахыг хамгийн чухал гэж үздэг. Ямар ч сурталчилгаа, түүний дотор рекламн ролик буюу 30 секундын богинохон клипэнд хүртэл түүнийг захиалсан хүмүүсийн нэр тов тодорхой гарах ёстой гэнэ. Жишээлбэл, энэ сурталчилгааг тэр нэр дэмшигчийг дэмжих хорооноос захиалав гэх мэтээр төгсгөдөг. Эсвэл нэвтрүүлгийн дундуур титр өгнө.
- Төлбөртэй нэвтрүүлэг болон рекламн роликт сэтгүүлч хүн оролцохыг хатуу хориглоно. Тэр ч бүү хэл сурвалжлагчийн дүрс орсон кадрыг сурталчилгаанд ашиглаж болохгүй.
- Мэдээллийн хөтөлбөрийн дундуур рекламн ролик үзүүлэхгүй.
- Хэрвээ сэтгүүлч улс төрд орохыг хүсвэл сэтгүүлчийн ажлаа орхидог. Зарим тохиолдолд ажлаасаа чөлөө авах ёстой.
- АНУ-д нэр дэвшигчид ба улс төрийн намуудад үнэ төлбөргүй эфирийн цаг олгох шаардлага тавьдаггүй. Яагаад гэвэл бүх хэвлэл мэдээлэл хувийнх байдаг. Намууд, нэр дэвшигчиддийн талаар үнэн бодитой мэдээлэл өгөх, тэдэнд сурталчиганы адилхан цаг олгох тухай хууль бий. Гэхдээ хэд хэдэн цоорхой байдаг. Дээрх шаардлага сонгуулийн талаархи мэдээллийн хөтөлбөр ба баримтат кино, шууд нэвтрүүлэг, үндэсний намуудын их хурлаас хийсэн сурвалжлагад хамаарахгүй. Иймээс америкийн сэтгүүлчид сонгуулийн талаар үнэлж дүгнэх байр сууриа илэрхийлэх хавьгүй өргөн боломжтой.
- Сонгуулийн сурталчилгааг телевизээр дамжуулах тариф ердийн арилжааны тарифаас доогуур байх ёстой хуулийн заалт бий. Телевизийн дэлгэцийг бүх нэр дэвшигчдэд хүртээмжтэй байлгахын тулд үүнийг хийжээ.
-

Их Британи: Сонгуулийн үеэр хэвлэл мэдээлэлд тавигддаг зарим шаардлага:

- Энд хэвлэл мэдээлэл улс төрийн хувьд хөндлөнгийн байр суурьтай байхыг хуулиар шаарддаг. Гэхдээ ийм заалт зөвхөн радио, телевизэд хамаатай, сонин хэвлэлд хамаарахгүй учраас баруун, зүүн чиглэлтэй сонинууд оршин тогтнодог. Иймээс улс төрийн намууд, нэр дэвшигчид радио, телевизийн нэвтрүүлгийг нэг бүрчлэн ажиглаж аль нэг тал руу хазайх юм бол дор нь мэдэгдэж шаардлага тавьдаг. Үүний тулд улс төрийн намууд аль телевизээр хэнийг хичнээн үзүүлж байгааг хянах хүмүүсийг хөлсөлж авдаг. Хэрвээ ямар нэг телевиз тэнцвэргүй үзүүлсэн байвал BBC-г хүртэл шүүхэд өгдөг. Маш өндөр торгуултай. Харин сонинууд руу тэгэж халдаж чаддаггүй.
- Бүх нийтийн сонгуулийн үеэр улс төрийн сурталчилгааг хуулиар хориглодог. Их Британид консерватив нам хамгийн баян, эфирийн цагийг хавьгүй ихээр худалдан авах боломжтой ийм шийдвэр гаргахад хүрсэн байна. Гэхдээ улс төрийн гурван гол намд (консерватив, лейборист, либерал-демократ) сонгуулийн сурталчилгааны үеэр эфирийн үнэгүй цаг олгодог. Тэдний улс төрийн ролик тус бүр 5 минут үргэлжилэх ба телевизийн бүх суваг, радио станцаар цацах эрхтэй.
- BBC-гийн улс төрийн тоймч Стив Ричардс: Их Британид өргөн нэвтрүүлгийн зохицуулалт хатуу.... Бид сонгуулийн үеэр улс төрийн гурван гол намын дунд тэнцвэртэй байдлыг хангах гэж жонглер тоглох шиг болдог. Дэлгэцэн дээр эхлээд нэг намын тэргүүн гарч “Миний төлөө саналаа өгөөрэй, би татварыг бууруулна” гэж хэлнэ. 14 секунд ярилаа гэж бодье. Араас нь нөгөө намын тэргүүний кадрыг бат тэр хугацаатай үзүүлж цаана нь сурвалжлагч “Дээрх хэлсэнтэй энэ намын дарга санал нийлэхгүй байна. Татварыг бууруулж чадахгүй гэж байна” гэх жишээтэй. Төгсгөлд нь либерал-демократ намын тэргүүнээс бас энэ сэдвээр ядхдаа 12 секунд байр сууриа илэрхийлэх учиртай... Хэрвээ гурваас дээш нам байвал яах байсан бол, бүү мэд.... Телевизийн сурвалжлагч тухайн сонгуулийн тойрогт нэг нэр дэвшигчээс ярилцлага авах бол бусад нэр дэвшигчдээс мөн адил ярилцлага авахыг хууль шаарддаг. Гэтэл зарим тойрогт 8-9 хүн нэр дэвшиж зарим нь “Тэнэгүүдийн нам”-ынх байх учраас тэр алиалагчидтай ярилцахаас өөр аргагүй. Ингээд зарим редакторууд хэнээс нь ч ярилцлага авахгүй байх нь дээр гэж үздэг. Энэ зовлон юуны өмнө орон нутгийн телевизэд тохиолддог. (Үндэсний хэмжээний суваг намын дарга нартай харьцана). Улмаар сонгогчид өөрийн тойрогт нэр дэвшсэн ганц ч хүнийг зурагтаар харахгүй, дууг хоолойг нь радиогоор сонсохгүй байсаар сонгуулийн кампанийг өнгөрүүлэхэд хүрч байна.... Гэхдээ сонгуулийн дараа сурталчилгааны цагийг тэнцүүлэх талаар нэг их анхаарахаа больдог. Сонинуудыг дагаад аль нэг талыг шүүмжилж тайлбарлах нь элбэг болдог. Харин дараачийн сонгууль ойртохлоор дээр дурдсанчлан ижил цагийн хойноос санаа тавьж эхлэнэ.
- Дээрхээс үүдээд Их Британид намуудын сурталчилгаа гол төлөв сонин хэвлэлээр явагддаг юм байна.

BBC санал асуулгын дүнг мэдээлэхдээ ...

Их Британид BBC-гийн ажилтнууд үзэгч, сонсогчдод дараах сануулгыг заавал хэлэх ёстой гэнэ.: Олон нийтийн санал асуулгын дүн бол олон нийтийн санал бодол зөвхөн тухайн өдөр ямар байсныг харуулна, цаашдаа энэ санал бодол хэрхэн өөрчлөгдөх, санал хураалтын дүн ямар гарахыг найдвартайхаруулж чадахгүй.

1996 оны “Сонгууль, хэвлэл мэдээлэл” гарын авлагаас:

(Олон улсын сэтгүүлчдийн байгууллага (International Federation of Journalists)-аас бэлтгэсэн гарын авлага. Улаанбаатар. 1996 он).

Ишлэлүүд:

- Сүүлийн үед зарим нэр дэвшигчид сэтгүүлчдийн шүүлтүүрээр оролгүй сонгогчидтойгоо шууд харьцах арга зам сүвэгчлэх боллоо. Тухайлбал, 1992 онд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч тэрбумтан Рос Перо чөлөөт хэвлэлээр ярихаас зайлхийж телевизийн цагийг шууд худалдан авч байв. Тэрээр эфирийн цагийг хүссэн хэмжээгээр худалдан авч байлаа. Тэр үед Рос Перо нэвтрүүлгийнхээ үеэр сэтгүүлчдийг дайрч давшлах бүрийд түүний албан контор руу олон сонгогч утасдаж түүнийг дэмжихээ илэрхийлж байсан нь бидний мэргэжлийн хувьд харамсалтай баримт болсон билээ.
- Америкт 1988 онд явуулсан нэгэн судалгаанаас үзвэл сонгогчид хамгийн сайн мэдээллийг нэр дэвшигч нарын халз маргаанаас олж авсан дүн гарчээ. Сэтгүүлчдээс биш шүү.

“Сонгуулийг сурвалжлах нь. Редакцийн загвар” зөвлөмжөөс

- Уншигчиддаа сонгуулийн кампанийг хэрхэн сурвалжлах, ямар зарчим баримтлахаа тайлбарла.
- Мэргэжлийн түвшин дорой хийгдэсэн санал асуулгыг бүү ашигла. Ашигласан ч зохих тайлбар хийж дутагдал, сул талыг нь тайлбарлах хэрэгтэй. Олон нийтийн санал асуулга нь уламжлалт, шалгарсан улс төрийн сурвалжлагыг хэзээ ч гүйцдэггүй гэдгийг бүү март.
- Сонгуульд дэвшүүлж байгаа сэдвүүдийг зөв тусга. Сэдвүүдийг намуудын байр сууринаас хараат бусаар тусгаж, тэдний орхигдуулсан, үгүйсгэсэн сэдвийг чухал байвал дэвшүүл. Нэр дэвшигчид юу хэлсэн, урьд нь (зөвхөн сонгуулийн кампанийн үеэр биш, хэдэн жилийн турш) юу ярьж, юу хийж байв гэдгийг гаргаж тавь.
- Нэр дэвшигчийн нөлөөнд бүү ор. Санал асуулгын дүнгээр дээгүүр явж байгаа нэр дэвшигчийг хэвлэлийнхэн даган хошуурч, нэг талыг барих явдал гардгийг санагтун.
- Нам болон нэр дэвшигчийн ард хэн байгааг мэдэж тэдэнтэй холбоо барь.... Мөнгө хаанаас гарч байгааг мэд. Сонгуулийн кампанийг хэн санхүүжүүлж байгаа, тэр хүмүүс юуг хүсэж байгааг (шинэ хууль, эрх мэдэл г.м) мэдэж ав.
- Улс төрийн намуудын пресс –релиз (хэвлэлийн мэдээ)-г тэр хэвээр нь хэвлэж болохгүй. Тэдгээрийг нягтлан шалгаж илүү тэнцвэртэй өгүүлэл бичих эх үүсвэр болгон ашиглах хэрэгтэй.

“Сэтгүүлч ба сонгууль” (1990-ээд оны эхээр Кенид болсон ардчилсан сонгуулийг сурвалжилсан туршлагаас):

- Ямар ч тохиолдолд нэр дэвшигч буюу түүний дэмжигчдийн зүгээс аливаа урамшлын чанартай зүйлийг бүү авагтун. Тэр ч байтугай аль нэг улс төрийн зүтгэлтний машинаар ч хүргүүлж болохгүй.
- Түүхэн үйл хэрэгт Та биечлэн оролцох болно гэдгээ санагтун. “Түүх бол өнгөрсөн улс төр, улс төр бол өнөөгийн түүх” хэмээн нэг хүн хэлсэн байдаг.
- Хөндлөнгөөс харахад хэдийд ч сэтгүүлч гэдэг нь шууд танигдах ёстой эсэх талаар нэлээд маргалддаг тал бий. Зарим сэтгүүлчид “пресс” буюу “хэвлэл мэдээлэл” гэсэн бичээстэй богино цамц өмсөх нь тохиромжтой гэж үздэг бол нөгөө хэсэг нь чухамхүү хэвлэл мэдээллийнхэн гэдэг утгаар сэтгүүлчид халдлагын бай болдог гэж үздэг. Танихад хялбар дөхөм байх нь илүү цаг үе ч бий. Танигдахгүй байх нь чухал үе ч бий гэдэг нь тодорхой. Өөрийнхөө бодлоор шийдэх биз ээ.

“Сонгууль сурвалжлах зарчмууд”

- Сэтгүүлчид сонгуулийн хугацаанд ихээхэн хяналт ажиглалтад өртдөг. Жишээлбэл, Өмнөд Африкт гадаадын санхүүжилтээр сонгуулийн ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслийнхэн хэрхэн сурвалжилж байгаад ажиглалт хийх төслүүдийг хэрэгжүүлсэн байна.... [Уг] төсөл нь бүх телевизийн станц, 13 радиостанц, өдөр тутмын 17 сонинг хяналтдаа авч байжээ. (Дэлгэрэнгүй)

- Хэрэв улсын буюу хувийн монополиуд мэдээллийн талбарыг дагнан эзэмшсэн, сонгуулийн ажиллагааны дүр зургийг тэнцвэртэй, тэгш төлөөллийн зарчмаар ард түмэнд мэдээлээгүй, эсвэл сэтгүүлчид муу ажилласан бол сонгуулийн чөлөөтэй, шударга болсон гэж үнэлэх ёсгүй.
- Мэдээллийн чанартай нийтлэл сурвалжлага сонгуулийн кампанид хамгийн их нөлөөтэй байдаг учраас сонгууль бол сэтгүүл зүйн мэргэжлийн түвшингийн дээд зэргийн шалгуур болдог.

1996 оны “Сонгууль, хэвлэл мэдээлэл” семинарын тайлангаас:

(Европын холбооны “Сонгууль, хэвлэл мэдээлэл” төслийн хүрээнд МЧАСЭ, МХХ-гээс хамтран 1996 оны 03-р сарын 26-28-нд энэ семинарыг зохион байгуулжээ).

Хелен Дербишире (ОУСХ-ны төлөөлөгч):

- Хориод ардчилсан оронд явуулсан судалгаагаар Австрали, Канад, Шинэ Зеланд, Герман, АНУ зэрэг 5 оронд төлбөртэй сурталчилгаа явуулахыг зөвшөөрсөн байдаг. Саяхан Итали үүнийг зөвшөөрчээ. Бусад орнуудад ийм төлбөртэй явуулахыг зөвшөөрдөг авч яг сонгуулийн кампанийн үеэр явуулахыг хориглодог. Жишээ нь, Франц, Япон, Израйль...
- Сонгуулийн кампанийн үеэр мэдээллийн журмаар хийж болох нэг зүйл бол Ерөнхийлөгч, эсвэл Ерөнхий сайд олон улсын ямар нэгэн баримт бичигт гарын үсэг зурсан тохиолдолд тэн нь мэдээ байхаасаа илүү сурталчилгаа байдаг. Засгийн газрын давуу тал нь өөрийнхөө бүрэн эрхийн хугацаа нь дуусаагүй байгаа учраас сонгуулийн кампанийн үеэр олон улсын хэлэлцээрт гарын үсэг зурах эрх нь байдагт оршино. Сөрөг хүчинд тийм эрх байхгүй учир тэдэнд тийм төрлийн мэдээнд орох бололцоо байхгүй....Тэгэхээр яг ийм нөхцөл байдалд сурвалжлагч нарын гол үүрэг бол мэдээ, мэдээллийг тэнцвэржүүлж өгөх, өөрөөр хэлбэл, өөр нэг талын мэдээ баримтыг мөн адил хэмжээгээр оруулах шаардлагатай тулгардаг... Гэхдээ өдөр бүр мэдээллийн хөтөлбөрийн тэнцвэрийг барина гэж хэлж байгаа хэрэг биш, ерөөс сонгуулийн кампанийн туршид улс төрийн хүчнүүдийн тэнцвэр хангагдсан байх тухай байгаа юм. BBC-гийн хувьд ... тухайн долоо хоногт мэдээлэгдсэн улс төрийн хүчнүүдийн мэдээллийн тэнцлийг харж хянадаг.
- Хэдэн жилийн өмнө Германд зөвхөн парламентад суудалтай намуудыг л сурталчлах заалттай байсан. Гэхдээ энэ заалтыг өөрчилж парламентад суудалгүй байсан намууд сонгуульд ялах бололцоотой болжээ.

Семинарын үеэр гарсан зарим санал бодол:

СЕХ-ны дарга С.Лхагвасүрэн.

- Сонгууль дөхөж олон радио, телевиз шинээр гарч, сураггүй болсон сонин сэтгүүл хүртэл сэргэн гарлаа.... тэд хахуульд өртөгдөж болзошгүй юм.
- Сонгуулийн сурталчилгааны талаар томоохо хэвлэлүүд журам гаргаж түүнийгээ зохицуулж хянаж байх нь чухал. Тэгэхгүй бол тухайн сонин, сэтгүүлийн сурвалжлагч хэн нэгэн танилыгаа, эсхүл хэдэн төгрөг атгуулчихсан хүнийг л сурталчлаад байх болдог ...

Х.Дербашире

- Сурвалжлагчынхаа хэт улс төржсөн байдлыг редактор нь дарж өгч байх хэрэгтэй.
- Сэтгүүлч, итгэмжлэгдсэн ухуулагч хоёр ялгаатай байх ёстой.
- Сүүлийн 12-15 жилд Баруун Европод нэг ч сэтгүүлч гүтгэлгийн асуудлаар шоронд сууж байгаагүй.
- Миний нэг найз BBC-гийн орон нутгийн салбарт ажилладаг юм. Их Британийн Ерөнхий сайд Мейжорын тойрог юм. Сонгуулийн кампанийн үеэр тэр тойрогт жижиг намууд өөрсдийгөө сурталчилж гарч ирэх боломжтой юм байна. Энэ нь Мэйжор байгаа тойрогт өөртөө олны анхаарлыг хандуулах гэсэн зорилго юм. Ардчиллын нэгэн сонинд тэн хагас нь эрүүл биш юм уу гэж бодогдмоор хүмүүс нэр дэвшигч болчихсон байдаг. Том малгай өмсөж этгээд хувцасласан, улс төрийн байр суурь нь

ч этгээд хүмүүс байдаг. Парламентын байрыг өөр газар, тухайлбал, сар луу зөөвөл яасан юм гэх жишээтэйгээр сонин зүйл ярьдаг. Энэ үед тухайн орон нутагт ажиллаж байгаа сэтгүүлч Жон Мефжор дээр ч, нөгөө этгээдийн нам дээр ч санал асуух зорилгоор очдог байна. Хэрэв сурвалжлагчийн очиход сурвалжлага өгөхөөс татгалзах тохиолдолд тэдний гарын үсгийг авдаг байна.

- Сэтгүүлчид улс төрийн нам, нэр дэвшигчийн үгнээс иш татсаныхаа төлөө хариуцлага хүлээхгүй талаар [хуулинд] тусгах ёстой.

Зөрчилдөөн, мөргөлдөөний үед сэтгүүлчдийг хамгаалах тухай Европын Зөвлөлийн Тунхаглал

1. Сэтгүүлчид амь насаа алдах, ор сураггүй алга болох болон бусад халдлагад өртөх явдал нэмэгдсээр байгааг Европын Зөвлөлийн Сайд нарын Хороо буруушааж, энэ нь сэтгүүл зүйн үйл ажиллагааг чөлөөтэй, саад тотгоргүй эрхлэх явдалд халдаж байна гэж үзэж байна.
2. Сайд нарын Хороо бүх улс үндэстэн, тэр дундаа Европын Зөвлөлийн гишүүн орнуудад хандаж, хувь хүмүүс болон олон нийт сонирхсон бүх асуудлаараа, ялангуяа зөрчилдөөн, мөргөлдөөний үед төр, засгийн болон оролцогч талуудын үйл ажиллагааг дүгнэхийн тулд мэдээлэл авах эрхтэйг хүлээн зөвшөөрөхийг уриалж байна.
3. Зөрчилдөөн, мөргөлдөөний үед ажиллаж байгаа бүх сэтгүүлчид, аливаа шалгуургүйгээр, олон улсын хүний эрхийн хууль, Европын Хүний эрхийн Конвенц болон олон улсын хүний эрхийн бусад арга хэрэгслээр олгогдсон бүрэн хамгааллыг эдлэх ёстойг Сайд нарын Хороо дахин батлаж байна.
4. Сэтгүүлчдийг хамгаалах дээрх онцгой баталгаануудыг дээдлэн хүндэтгэхээ гишүүн орнуудын засгийн газрууд илэрхийлсэнийг Сайд нарын Зөвлөл дахин нотлож байна.
5. Дэлхийн Хэвлэлийн өдрийг тохиолдуулан, зөрчилдөөн, мөргөлдөөний үед сэтгүүлчдийг хамгаалах Р)96) 4 тоот Зөвлөмж болон хавсралт үндсэн зарчмуудад Сайд нарын Зөвлөлөөс анхаарал хандуулж байна.
6. Зөрчилдөөн, мөргөлдөөний үед сэтгүүлчдийн эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа талаар Европын Зөвлөлийн хүрээнд мэдээлэл хүлээж авах болон арга хэмжээ авах талаар одоо мөрдөж байгаа журмыг ерөнхийд нь сайжруулах арга замыг Сайд нарын Хороо, Ерөнхий нарийн бичгийн даргын хамт авч үзэх нь зүйтэй.
7. Гишүүн орнуудад зөрчилдөөн, мөргөлдөөний үед сэтгүүлчдийн эрх, эрх чөлөөг зөрчиж байгаа талаар мэдээлэл авсан тохиолдолд Ерөнхий нарийн бичгийн дарга яаралтай тохиолдолд бүх талын арга хэмжээг шуурхай авах, энэ талаар гишүүн орнууд Ерөнхий нарийн бичгийн даргатай хамтарч ажиллахыг Сайд нарын Хороо уриалж байна.

*Европын Зөвлөлийн Сайд нарын Хорооны
1996 оны 5 р сарын 3 ны 98 р хуралдаанаар батлав.*

СЭТГҮҮЛЧДИЙН БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны тунхаглал

1. Үнэнийг эрхэмлэж, үнэнийг мэдэх гэсэн олон түмний эрхийг хүндэтгэх нь сэтгүүлч хүний нэн тэргүүний үүрэг мөн.
2. Сэтгүүлч энэ үүргээ биелүүлэхдээ мэдээ сэлтийг зүй зохистой аргаар цуглуулж, хэвлэн нийтлэх эрх чөлөө, шударгаар хэлж шүүмжлэх эрхийн зарчмуудыг цаг ямагт баримтлах ёстой.
3. Сэтгүүлч шинэ сэргэг мэдээ, гэрэл зураг, баримт сэлтийг олж авахдаа гагцхүү шударга аргыг хэрэглэх учиртай.
4. Хэвлэгдсэн зүйл хор уршиг учруулах алдаа дутагдалтай болох нь нотлогдвол түүнийг засч залруулахын тулд сэтгүүлч бололцоотой бүхнийг хийвэл зохино.
5. Сэтгүүлч итгэл хүлээж олж авсан мэдээллийн эх сурвалжтай холбогдох мэргэжлийн нууцыг хадгалах ёстой.
6. Мэдээллийн хэрэгслээр ялгварлан гадуурхах явдлыг дэвэргэх нь ямар их аюултайг сэтгүүлч ухамсарлаж, улмаар арьсны өнгө, хүйс, хэл, шашин шүтлэг, улс төрийн буюу өөр үзэл бодол, үндэс угсаа, нийгмийн гарлаар болон бусад ямар нэгэн шалтгаанаар ялгаварлан гадуурхахаас сэрэмжлэхийн төлөө чадах бүхнээ хийх хэрэгтэй.
7. Дараах зүйлийг сэтгүүлчийн мэргэжлийн ноцтой алдаанд тооцно, үүнд:
 - бусдын бүтээлийг хулгайлах,
 - асуудлыг санаатайгаар мушгин гуйвуулах,
 - бусдыг гүтгэх, нэр төрийг нь гутаах, элдвийн нэр хоч зүүж доромжлох, хүнийг үндэслэлгүй буруутгах,
 - асуудлыг нийтэд мэдээлэх эсэхийг шийдэхдээ ямарваа нэг хэлбэээр хээль хахууль авах,
8. Сэтгүүлчийн эрхэм нэр төрдөө эзэн болж, дээрх зарчмуудыг ёсчлон биелүүлэхийг өөрсдийн үүрэг гэж үзвэл зохино.

Тухайн улс орны хуулийн хүрээнд сэтгүүлчид үзэг нэгт нөхдийнхөө асуудлыг зөвхөн мэргэжлийн үүднээс шүүн хэлэлцэхийг хүлээн зөвшөөрнө. Үүнд засгийн газар болон бусад эрх мэдэлтэн хөндлөнгөөс оролцох явдал байж болохгүй.

**Брюссельд төвтэй Олон Улсын Сэтгүүлчдийн Холбооны
1954 оны Их Хурлаас баталж,
1986 оны Их Хурлаас шинэчлэн засварлав.**

- **2000 онд болсон “Улс төр ба реклам” дугуй ширээний ярилцлагын тэмдэглэлээс**

УИХ-ын сонгуулийн дараа буюу 2000 оны 9-р сарын 15-нд Монголын Рекламын Ассоциаци, Бүгд Найрамдахчуудын хүрээлэн хамтран “Улс төр ба реклам” эдэвт дугуй

ширээний ярилцлагыг “Чингэс” зочид буудалд зохион байгуулжээ. Энэ ярилцлагын тэмдэглэлээс хэвлэл мэдээлэлтэй холбоотой зарим санаа, жишээг энд сийрүүлэв.

Д.Баяндүүрэн (Сонгуулийн ерөнхий хорооны нарийн бичгийн дарга)

- 2000 оны УИХ-ын сонгуульд оролцсон намууд санхүүгийн тайлангаа ирүүлж байна. “Эх – орон” МАШСН” энэ удаагийн УИХ-ын сонгуульд хамгийн их буюу 645,7 сая төгрөг зарцуулсны 579,4 саяыг нэр дэвшигчдийнхээ рекламанд өгчээ. МАХН 492,9 сая (сурталчилгаанд 353,3 сая), МҮАН-МШАН-ийн “Ардчилсан холбоо” эвсэл 358,2 сая (сурталчилгаанд 263,5 сая), МСДН 226,2 сая төгрөгийг сонгуульд зарцуулснаараа айргийн тавд багтаж байна. Мөн “ИЗН-НН”-ын эвсэл 37, “Их эвсэл” 23, МШСДН 18, МХХН 13, МАН 9, МИАШЛН 5, МУШЭТН хагас сая төгрөгийг сонгуулийн сурталчилгааны үеэр тус тус гаргажээ.

Б.Баабар:

- Сая Сонгуулийн Ерөнхий хорооноос мэдээллээ. Энэ бол мөсөн уулын дөнгөж “албан ёсоор” цухуйж буй хэсэгхэн нь шүү дээ. Ойролцоогоор хамгийн багаар бодоход л өнгөрсөн УИХ-ын сонгуульд 7 тэрбум төгрөг гарсан ерөнхий тооцоо байна. Энэ нь нэг хүнд гурван ам доллар ба нэг нэр дэвшигчид 10 сая төгрөг ногдож байна.
- Барааг сурталчлахдаа нөгөө барааг нэр зааж муулдаггүй. Сонгуулийн сурталчилгаанд бол өөр. Магтах ба муулах гэсэн хоёр аргыг ашигладаг.
- Суртал нэвтрүүлгийн арга маш өндөр түвшинд хүрчээ.

Нэг нэр дэвшигч 150 сая төгрөгөөр шатжээ.

Энэ удаагийн УИХ-ын сонгууль Монголын улс төрийн рекламны зах зээлийн төсвийг урьд өмнө байгаагүй өндөрт өргөв.

Нийлбэр дүнгээр энэ удаагийн сурталчилгаанд доор хаяж 5 тэрбум төгрөг зарцуулагдсан тооцоо байна. Хамгийн ихээр шатсан нэр дэвшигчээр 150 сая төгрөг хаяж, 34 саналын дутуугаар өвдөг шороодсон Дэд бүтцийн сайд асан Г.Батхүү тодров.

(“Рекламын ертөнц”. 2003. 14)

• Сэтгүүлчийн ёс зүйн талаархи өгүүллүүд

Сэтгүүлчид хувьцааны дуулианд холбогдсон нь

Их Британид санхүүгийн сэдвээр бичдэг шар сонины сэтгүүлчид хувьцаа худалдаж авсаныхаа дараа өгүүлэл бичиж тухайн хувьцааны үнийг маш ихээр өсгөж албан тушаалаа ашигласаныхаа төлөө ажлаасаа халагдсан байна. Уншигчдад сурталчилсан компаний хувьцааг өөрсдөө эзэмшдэг тухайгаа мэдүүлээгүй байсан тул гэрээгээ зөрчиж Хэвлэлийн Гомдлын Комиссын хэм хэмжээг умартсан гэж тэднийг буруутгажээ. “Миррор сонины хоёр ажилтан хувьцааны дуулианы дараа ажлаас халагджээ” өгүүлээс, Гардиан сонины 2000 оны 2-р сарын 19-ний дугаараас.

Эрхлэгч буруугаа хүлээв

Энэ бол хэдэн сарын турш улс орныг доргиосон нийтлэл байлаа. 8 р сард Сан Хосе Меркюри сонинд “Хуйвалдаан” нэртэй цуврал өгүүлэл хэвлэгдэж Африк гаралтай Америкчуудын дунд кокаин хэмээх хар тамхийг анх дэлгэрүүлэхэд Тагнуулын Төв Байгууллага (ТТБ) оролцсон тухай бичжээ. Энэ нийтлэлийн мөрөөр Холбооны мөрдөн байцаалт явуулж, нийтлэлээс болж Африк гаралтай Америкчуудын дунд эсэргүүцлийн давалгаа гарсанаас гадна үндэсний хэмжээний өөр гурван сонин нийтлэлийн мөрөөр

сурвалжилсан боловч юу ч олж чадаагүй байна. Яагаад гэдэг нь одоо бидэнд тодорхой боллоо.

Тус сонины гүйцэтгэх эрхлэгч Жерри Цеппос ням гаригийн нэгэн дугаарт эрхлэгчийн буланд бичихдээ, дээрх цуврал өгүүллэгийн хамгийн их шуугиан тарьсан дүгнэлтүүд нь асуудлыг хэт хялбаршуулан, баримтаар баталгаажуулаагүйгээс болсон гэжээ. Тэрээр цааш нь бичихдээ, зарим талаар цуврал өгүүлэл нэг талыг барьсан, өөр хоорондоо зөрчилдсөн мэдээллийг оруулаагүй, таамаглалыг баримт мэтээр үзүүлснээс болж “буруу тайлбар хийж болох байдлыг бий болгожээ” гэв.

Цеппос бичихдээ, цуврал өгүүлэл буруу төсөөлөл төрүүлсэн юм, үнэн хэрэгтээ ТТГ_ын дэмждэг Контра Армид зориулж мөнгө олох зорилгоор Никарагуагийн наркотикийн наймаачид Лос Анжелес хотод кокаин зарах оролдлого хийж байсныг ТТГ_ын өндөр албан тушаалтнууд мэдэж байсан тухай баримт нотолгоо сониныхонд байгаагүй ажээ. Меркюри Ньюс сонинд нийтлэгдсэн цуврал өгүүлэл уншигч болон сэтгүүлчдэд сургамж болох юм. Үнэн бодит байдал бүрхэгдмэл байгаа адармаатай нөхцөлд эргэлзээтэй баримтыг ашиглан ноцтой дүгнэлт хийх нь ямар их аюултайг харуулж байна. Мөн аливаа нэг байгууллагын нэгэн адил сонины газрын дотоод шийдвэрийн механизм ажиллахгүй бол алдаа дутагдал гардгийг харуулж байна. Дээрх жишээгээр бол, олон сарын турш бэлдэж, ноцтой дүгнэлтүүд гаргаж ирсэн цуврал өгүүллийг сайтар нягтлаагүй байна. Ахлах редактор нь өгүүлэл нийтлэгдэхээс нэг сарын өмнө ажлаасаа гарсан байсан бөгөөд бусад гол редакторууд оролцоогүйн дээр Цеппос өөрөө өгүүллийг нийтлэгдэхээс өмнө бүрэн уншиж танилцаагүй байжээ.

Энд өгүүлсэн бүтэлгүй явдал нь зөрчилтэй асуудлыг дэвшүүлэх буюу төр, засгийн алдаа дутагдал, коррупцийг илчилдэг эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ач холбогдлыг хэрхэвч бууруулах ёсгүй. Бэрхшээлтэй асуудал дэвшүүлэхээс түвэгшээдэг сонин хэвлэл нийгэмдээ үйлчлэхгүй. Дээр өгүүлсэн түүх бол үнэн бодитой, баримт нотолгоотой байхыг сануулсан зүйл болохоос алдаа хийхээс айж асуудлаас зугтаах хэрэгтэй гэсэн үг биш юм.

Өндөр стандартын шаардлагад хүрэлгүй алдаа дутагдал гаргасан сонин хэвлэл уншигчдынхаа итгэлийг алдах нь бүгдийг алдаж байна гэсэн үг. Меркюри Ньюс сонинд гарсан цуврал өгүүллийн алдаа дутагдлыг хүлээсэнээр эрхлэгч Цеппос уншигчдынхаа итгэлийг эргүүлэн олж авах зоригтой оролдлого хийж бусад сонин хэвлэлийн эрхлэгчдэд үлгэр жишээ үзүүллээ.

Б.Одонжил (УИХ-ын тамгын газрын мэдээлэл, лавламжийн албаны дарга)-ын тавьсан “Сонгуулийн кампанийн үеийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл” илтгэлийг жич хавсаргав.

“Сонгууль ба хэвлэл мэдээлэл” сэдвээр 1996 оны 1-р сарын 16-нд зохион байгуулсан семинарт оролцогчдоос Улсын Их хурал, Сонгуулийн ерөнхий хороонд өргөн барьсан санал, зөвлөмжийг жич хавсаргав.

“Сонгууль ба хэвлэл мэдээлэл” сэдвээр 1996 оны 3-р сарын 26-28-нд зохион байгуулсан дээрх семинарт оролцогчдоос гаргасан зөвлөмжийг жич хавсаргав.